

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

# ХҮНИЙ ЭРХ

---

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,  
цаг ямагт, хүн бүрт”

---

(13 дахь жилдээ)

2014/01

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл  
2014/01(43)  
Улсын бүртгэлийн дугаар 244  
13 дахь жилдээ

П.Оюунчимэг Ерөнхий редактор /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний  
Комиссын гишүүн/  
Ц.Адъяахишиг Хариуцлагатай нарийн бичгийн дарга /Монгол Улсын Хүний  
эрхийн Үндэсний Комиссын ахлах референт/

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн  
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн  
зохиогчийн үзэл бодол болно.

## АГУУЛГА

## ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

*Н.Ганбаяр*

Хүний эрхийн боловсролыг түгээж буй Монгол Улсын Хүний эрхийн  
Үндэсний Комиссын туршлага, цаашдын чиг хандлага ..... 5

*А.Алтанзул (PhD), дэд профессор*

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах нь ..... 8

*Д.Сүнжид (PhD), Dr.jur, LL.M Munich*

ХБНГУ-ын Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглох зарчим ..... 14

*Д.Үүрцайх (Докторант, LL.M, Bonn)*

Сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх нь ..... 23

*Г.Агар-Эрдэнэ (Докторант)*

Оюуны өмчийн онолын чиг хандлага: Радикаль болон хяналтын онолууд ..... 29

*С.Боловсон (Докторант), Л.Банзрагч (Докторант)*

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн  
хэрэгжилтийн төлөв байдал ..... 34

*Ц.Одгэрэл (Докторант)*

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нийгэмд  
үзүүлж буй нөлөөлөлд зардал үр ашгийн шинжилгээ хийх нь ..... 45

*Ж.Хулан, Б.Мөнгөннахиа*

Өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх –  
Freedom of opinion and expression ..... 58

## МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

*Амартъя Сен*

Хүний эрхийн онолын элементүүд ..... 64  
орчуулсан Ө.Ундрах

## ЗОЧНЫ ЯРИА

Монголын Морин Спорт уяачдын холбооны нарийн

бичгийн дарга П.Сэргэлэнтэй хийсэн ярилцлага ..... 89

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

## ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ТҮГЭЭЖ БУЙ МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУРШЛАГА, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний  
Комиссын гишүүн

**Н.ГАНБАЯР**

Австрийн Вена хотноо 1993 онд хуралдсан Хүний эрхийн Дэлхийн чуулга уулзалтаар дэлхийн бүхий л улс оронд хүний эрх, эрх чөлөөг эдлэх, хэрэгжүүлэхэд алдаа дутагдал оршсоор байгааг хүлээн зөвшөөрч, хүмүүс эрх чөлөөгөө бодит утгаараа эдлэхэд хүний эрхийн боловсрол зайлшгүй чухал ач холбогдолтой болохыг тодорхойлжээ. Ийнхүү Венийн чуулганаар бүх талуудын харилцан ойлголцол, дэлхийн энх тайван байдлыг дээшлүүлэхийн тулд хүний эрх болон ардчиллын боловсрол, сургалтыг цогц байдлаар авч үзэхээр харилцан тохиролцсон билээ.

Энэ хүрээнд Хүний эрхийн боловсролын НҮБ-ын 10 жил (1995-2004), Бүх нийтийн боловсролын Дакарын тунхаглал (2002), Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр (2004), Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглал (2011) зэрэг олон улсын бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Ийнхүү олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүний эрхийг хангаж, хамгаалахад боловсрол чухал

үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрсөн болно. НҮБ-ийн дээрх баримт бичгүүдэд “Хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн харьцах, өв тэгш хөгжүүлж, түүний эрхэм зэргийг дээдлэх, чөлөөт нийгэмд үр ашигтайгаар оролцох зэрэг мэдлэг чадвар, хандлагуудыг төлөвшүүлэх, хүний эрхийн түгээмэл соёл бүрдүүлэхэд чиглэж буй сургалт, мэдээлэл, түгээн дэлгэрүүлэх бүхий л үйл ажиллагааг ойлгоно” хэмээн заасан нь түүнийг их өргөн хүрээнд авч үзэж байгаагийн илэрхийлэл юм.

Хүний эрхийн боловсрол нь түүнд суралцаж буй хүн бүрийн үзэл санаа, амьдралын хэв магт өөрчлөлт авчирч, эерэг үр дүнд хүргэдэг. Хүний эрхийн үзэл санаа, зарчмуудыг ойлгон мэдэж, өөрсдийн анги танхим, гэр орон, цаашлаад нийгэм хамт олны харилцаанд хэрэгжүүлэх нь түүнд суралцахын гол ач холбогдол болно.

Монгол Улсын хувьд Хүний эрхийн боловсролын НҮБ-ын 10 жилийн хүрээнд гаргасан томоохон ололт амжилт бол 2001 онд Хүний эрхийн үндэсний байгууллагыг

байгуулсан, мөн 2003 онд “Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр” баталсан явдал гэж үздэг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1-г “хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах”, 13.2.5-д “Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих” гэж заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг гол чиг үүрэг бол хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих явдал бөгөөд хүний эрхийн боловсрол олгох, энэ чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарч ирсэн билээ. Тухайлбал, Боловсролын салбар дахь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын томоохон санаачлагын нэг нь ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд” төслийг 2005 оноос хэрэгжүүлсэн явдал юм. Энэхүү төслийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуульд орж буй “Хүний эрх” хичээлийн чанар, үр нөлөө, сургалтын агуулга, заах арга зүй, хэрэглэгдэхүүний хүрэлцээ, багшлах боловсон хүчний байдал, сургуулийн хүний эрхийн орчинд үнэлэлт дүгнэлт өгөх үндэсний хэмжээний судалгааны ажлыг зохион байгуулжээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын өмнөх жилүүдийн стратеги төлөвлөгөөнд “Иргэд эрх, эрх чөлөөгөө сайтар мэдэж, эрхийнхээ төлөө тэмцэх чадвартай болгохын тулд хүний эрхийн мэдлэг, соёл, ухамсрыг дээшлүүлэхэд нөлөөлөх” гэж тусгаж байсан бол Комиссын 2012-2014 онд хэрэгжүүлэх стратегийн зорилго 4-т “Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх”-ээр тусгасан. Уг зорилгын хүрээнд:

- Албан боловсролын тогтолцоогоор олгож буй хүний эрхийн боловсролын

чанар, үр нөлөөг дээшлүүлэх,

- Хүний эрхийн албан бус сургалт явуулах чадавхийг бэхжүүлэх,
- Хүний эрхийн онолын судалгааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах,
- Олон нийтийн хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх зорилтууд багтжээ.

Комиссын зүгээс албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролыг дэмжих зорилгоор сургалт, сурталчилгааны олон арга хэмжээ зохион байгуулав. Энэ хүрээнд олон тооны зорилтот бүлгүүдийг тодорхойлж, тэдгээрт чиглэсэн сургалтыг зохион байгуулж хэвшсэн байна.

2013 онд зохион байгуулсан “Хүний эрхийн өдөрлөг” арга хэмжээний хүрээнд Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон-Уул, Хөвсгөл, Булган, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Төв аймгууд, Улаанбаатар-хотын Баянзүрх дүүргийн хороодод Төрийн захиргааны ажилтнуудад “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг хангах нь” сэдвээр тус тус нийт 1225 оролцогчийг хамруулан 112 цагийн сургалтыг зохион байгуулсан. Үүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газрын алба хаагчдад зориулсан сургалтаас гадна оюутнуудад зориулсан хүний эрхийн зуны сургалтыг энэ жил гурав дахь удаагаа зохион байгууллаа. Мөн байгууллагуудын хүсэлтээр хүний эрхийн олон тооны сургалтыг зохион байгуулсаар байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс 2001-2013 оны байдлаар хүний эрхийн боловсролд түлхүү анхаарч, жилд дунджаар 2340 хүнийг танхимын сургалтад хамруулсан ба цаг хугацаа, орон зайны хувьд алслагдмал нөхцөл байдлыг арилгах, орон нутгаас олон

Хүний эрхийн сургалт		2008	2009	2010	2011	2012	2013/12/01
Төлөвлөгөөт сургалт	Нийт цаг	591	234	147	149	75	190
	Нийт оролцогч	2749	2415	2224	2012	387	3407
Байгууллагын хүсэлтээр хийгдсэн сургалт	Нийт цаг	55	117	86	48	81	172

хүнийг хамруулах зорилгоор 2011 оноос онлайн сургалтыг нэвтрүүлэхээр судалж, 2013 оноос нэвтрүүлсэн билээ.

Хүний эрхийн боловсролыг дэмжих чиглэлээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийж буй томоохон ажил нь жил тутам Улсын их хуралд өргөн барьдаг "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай" илтгэл юм. 2007 оны илтгэлд "Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын өнөөгийн байдал" бүлгийг боловсруулсан. Энэхүү илтгэлийг жил тутам Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлэхийн хамт монгол ба англи хэлээр тус бүр хэвлэн, байгууллага, олон нийт, иргэдэд түгээн дэлгэрүүлж байна.

Комиссын зүгээс онол-арга зүйн "Хүний эрх" сэтгүүлийг жилд 2 удаа хэвлүүлж, олон нийтэд түгээхээс гадна "Хүний эрхийн мэдээлэл лавлагааны төв", олон нийтийн лекц, семинар, ярилцлага, уулзалт, хичээл, сургалт зэрэг боловсролын үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг түгээж, боловсролын технологийн ололт амжилтад тулгуурлан цахим сургалт зохион байгуулдаг талбар байгуулан, орон зай, цаг хугацааны хувьд хамааралгүйгээр алсын зайн буюу онлайн сургалтыг зохион байгуулах, мөн олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, мэдээлэл түргэн шуурхай хүргэх зорилгоор Фейсбүүк, Юүтүб зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглаж байна. Мөн хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг хүний эрх, боловсрол, технологи гэсэн гурван хүчин зүйлсийн уялдаа холбоог хамгийн зүй зохистой, ашигтай байдлаар

ашиглахаар төлөвлөж, цаашдын хандлагаа тодорхойлсон билээ.

2014 онд эрх зүйч мэргэжилтнийг бэлтгэж буй их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгож буй байдал, сургалтын хөтөлбөр дэх хүний эрх, түүнтэй холбогдол бүхий хичээл, сургалт, тэдгээрийн агуулга, арга зүй, үнэлгээ, хүний эрхийн сэдвийн хүрээнд мониторингийн ажлыг төлөвлөөд байна.

Цаашилбал эн тэргүүнд хийх шаардлагатай, хамтын ажиллагаа, оролцоо, хувь нэмэр чухал байгаа зүйлсийг дурьдвал:

- Нөхцөл байдлын ерөнхий зураглалыг үндэсний хэмжээнд гаргах;
- Албан ба албан бус шинжтэйгээр олон нийтийн өргөн хүрээг хамарч байгаа одоогийн ололт амжилтаа үнэлэх;
- Нийгэмд хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх, энэ талаар үндэсний хэмжээний санал санаачлага, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Бага, дунд болон дээд боловсролын түвшинд хүний эрхийн боловсролыг оруулах, одоогийн хөтөлбөрүүдэд интеграцичлах замаар нэвтрүүлэх
- Хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллага, хувь хүн, судлаачдын чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих, сурталчлах;
- Хүний эрхийн цахим сургалтыг түгээн дэлгэрүүлэх;
- Хүний эрхийн боловсролын нөөц, эх сурвалж хэрэглэгдэхүүнийг боловсруулах, олон нийтийн болон боловсролын байгууллагуудад түгээх хэрэгтэй байна.

## ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААНД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ



Удирдлагын академийн багш, Хууль  
зүйн ухааны доктор, дэд профессор

### А.АЛТАНЗУЛ

**Хураангуй:** Захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь иргэдийн оролцооны эрх зүйн орчинг бүрдүүлэх нь хүмүүнлэг, иргэний нийгэм байгуулах Үндсэн хуулийн зорилгыг хангаж буй явдал билээ. Гагцхүү иргэдийн оролцоог ямар шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх нь өнөөдөр эрх зүйн зохицуулалтын хүрээнд тодорхойгүй байна. Иймд нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн шийдвэр гаргаж буй захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн шууд оролцоог хангах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах талаар холбогдох судалгаанд үндэслэн санал гаргахыг оролдлоо.

**Түлхүүр үгс:** ард түмний эрх мэдэл, захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, иргэдийн оролцоо, нийтийн эрх зүйн маргаан, захиргааны хэргийн шүүх

НҮБ-ын албан ёсны баримт бичгүүдэд<sup>1</sup> засаглалыг “улс үндэсний ажил хэргийг жолоодох, улс төр, эдийн засаг, захиргааны эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд

энэ нь иргэдийн, тэдний бүлгүүд ашиг сонирхол, өөр хоорондын ялгаатай байдлаа илэрхийлэх, хуулиар олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх механизм, үйл явц харилцаа, байгуулалаас бүрдэнэ” гэж тодорхойлжээ.<sup>2</sup> Иймд эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь зөвхөн төр биш, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд ихээхэн үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа явдал юм.

Ард түмэн засаглалын анхдагч субъект<sup>3</sup> болохыг хүн төрөлхтөн хуульчлаад хэдийнээ 200 гаруй жилийн хугацаа өнгөрчээ. Нийгмийг бүрдүүлэгч социал бүлгүүд болох ард түмэн нь эрх мэдлийн анхдагч эх сурвалж гэдгийг АНУ Үндсэн хуулиар баталгаажуулсан юм. Судлаачийн үзэж байгаагаар, нийгмийн түүхийн тодорхой үеүүдэд (нийгмийг удирдах эрх мэдэл цөөнх буюу нэг хүний гарт төвлөрч байсан цаг хугацааг хамааруулав) ард түмэн энэхүү

<sup>1</sup> Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, Орон нутгийн засаглалыг дэмжих хөтөлбөр г.м

<sup>2</sup> Д.Рондинэли. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: иргэддээ үйлчилдэг засгийн газар. 2008 он. 7 дахь тал

<sup>3</sup> We the people of the United States,..., do ordain and establish this Constitution.../АНУ-ын Үндсэн хуулийн оршил. Д. Ганбат. Эрх мэдэл хуваарилах, тэнцвэржүүлэх онолын асуудалд. илтгэлээс/



эрх мэдлээ шууд хэрэгжүүлэхэд “бэлэн бус” байсан нь төр хэмээх бүтэцжсэн байгууллагын эрх мэдэл хүчтэй болоход нөлөөлсөн гэж дүгнэж байна. Тухайлбал, 18-р зуунд Ш. Монтескью “Төрийн эрх мэдэл хуваарилах, түүнийг практикт хэрэгжүүлэхэд олон түмний хөгжлийн төвшин чухал үүрэгтэй гэсэн санааг илэрхийлж, ард түмний төлөөлөгчид төрийн хэргийг хэлэлцэхэд бэлэн биш байх, шийдвэр гаргах чадваргүй байх нь бодит бэрхшээл гэдгийг тэмдэглэж, ард түмэн асуудлыг хэлэлцэхэд огт бэлэн биш байдаг нь ардчилалын сул талуудын нэг мөн<sup>4</sup> гэжээ. Мөн тэрбээр эртний улсуудад байсан нэг том дутагдал бол ард түмэн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаатай холбогдсон идэвхтэй шийдвэрийг хүлээн авах /гаргах/ эрхээ хэрэгжүүлэх чадваргүй байсан явдал юм” хэмээн төрийн эрх мэдэл хуваарилах тухай онолын бүтээлдээ дүгнэсэн байдаг<sup>5</sup>.

Иймд дэлхийн ихэнх улсуудын ард түмэн /иргэн бүр/ нь өөрийн сонгосон төлөөллийн байгууллагуудаараа уламжлуулан /хууль тогтоох, гүйцэтгэх/ засгийн бүх эрх мэдлээ хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1 дэх хэсэгт: “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”. Мөн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсэгт: “Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй” гэж тус тус заасан.

Иргэдийн төрийг удирдах шууд оролцооны эрхийн хэрэгжилт ямар байгааг гүйцэтгэх эрх мэдэл буюу захиргааны шийдвэр гаргах ажиллагаагаар жишээ авч

судаллаа.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ардчилсан засаглал, хүний эрхийн хангах бодлогын баримт бичигт “сайн засаглалын мөн чанар” бол захиргааны байгууллагууд нь шийдвэр гаргах аль ч түвшиндөө иргэдийн өргөн оролцоог хангах, тэдний өмнө ил тод ажиллах явдал гэжээ.

Ард түмэн төрийг удирдах эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ шууд биечлэн оролцооны үр дагаварт тодорхой шийдвэр гаргах, эсхүл тэдний оролцоог ашиглах замаар эрх бүхий байгууллага шийдвэрээ гаргах гэж хувааж болох юм. Үүнийг иргэдийн шууд оролцооны ба шууд бус оролцооны эрх гэж ангиллаа.

### Нэг. Шууд оролцох эрх

Иргэд буюу иргэний нийгмийн байгууллагууд эдийн засаг, нийгэм, улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд шууд оролцох замаар төрийн бодлогыг тодорхойлно.

Жишээлбэл, нийгмийн халамжид зориулсан эх үүсвэрийг зөв хуваарилж зарцуулах үр ашигтай механизм бий болгох, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар засгийн газрын байгууллагуудтай хамтарч шийдвэр гаргана.

### Хоёр. Шууд бус оролцооны эрх

Энэ нь эрх бүхий байгууллагын шийдвэрт биечлэн оролцохгүйгээр төлөөллөөр дамжуулан уг эрхээ эдлэхийг хэлнэ.

Дашрамд дурдахад ард түмнийг төлөөлж шийдвэр гаргах эрхтэй (сонгуулиар сонгогддог болон сонгуулийн үр дүнд томилогддог субъектуудыг төлөөллийн гэж хэлэхэд буруудахгүй болов уу) албан тушаалтнууд ойролцоогоор 1000 орчим байна. Тодруулбал: Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна

<sup>4</sup> Хуулийн амин сүнс. (орчуулагч ред. Т.Төмөрхүлэг). 2008 он.

<sup>5</sup> Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. 2007 он. 32 дахь тал

*/Үндсэн хуулийн 20-р зүйл/, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ. /Үндсэн хуулийн 26-р зүйл/, Засгийн газар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс бүрдэнэ /Засгийн газрын тухай хуулийн 17-р зүйлийн 1/, Ерөнхий сайдын түр эзгүйд түүний үүргийг Монгол Улсын Шадар сайд гүйцэтгэнэ /Засгийн газрын тухай хуулийн 17-р зүйлийн 2/, Монгол Улсын яамыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд тэргүүлнэ /Засгийн газрын тухай хуулийн 18-р зүйлийн 4, Засгийн газрын бүтцэд 16 яам багтсан/, Сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, агентлагийн үйл ажиллагааг сайдын өмнө хариуцах үүрэг бүхий дэд сайд байна /Засгийн газрын тухай хуулийн 18-р зүйлийн 5/, Хуульд өөрөөр заагаагүй бол агентлагийн даргыг Төрийн албаны тухай хуулийн 35<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож, эрхлэх асуудлын хүрээнд нь тухайн агентлаг хамаарч байгаа Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар томилж, чөлөөлнө /Засгийн газрын тухай хуулийн 18-р зүйлийн 2/ Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ. /Үндсэн хуулийн 60-р зүйлийн 1/.*

Иргэдийн шууд оролцооны эрхийг бодитой хангахын тулд юуны өмнө төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг иргэнлэг, хүний эрхийн мэдрэмжтэй болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй байна. Тухайлбал, засгийн газар, яамдын эрх мэдлийн төвлөрлийг сааруулахад чиглэгдсэн улс төрийн шинэчлэлийн бодлого зайлшгүй юм.

Төр зөвхөн өөрийн онцгой бүрэн эрхэд холбогдох чиг үүргийг өөртөө үлдээж, харин бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг

зохион байгуулахад иргэд, хувийн хэвшил, төрийн бус байгууллагыг өргөнөөр татан оролцуулах<sup>6</sup> байдлаар уг шинэчлэл явагдах учиртай.

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа гэдэг нь захиргааны актыг гаргах урьдчилсан нөхцөл шаардлагыг хангах, төсөл бэлтгэх, батлах хийгээд захиргааны гэрээ байгуулахад чиглэсэн байгууллагын гадагш нөлөөлөл бүхий үйлдлийг хэлнэ<sup>7</sup>. Иймд захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь дан ганц захиргааны байгууллагын хүсэл зоригийн үйлдэл бус, иргэдийг оролцуулсан хамтын ажиллагаа гэж хэлж болно.

Нэг талаас захиргааны байгууллага өөрт харьяалах албаны чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд нэг талын хүсэл зоригийн харилцаан дээр тулгуурлаж дангаар шийдвэр гаргадаг (энэ тухай өгүүлэлд хамааралгүй учраас тайлбар хийсэнгүй) бол нөгөө талаас иргэдийн санал, хүсэлт дээр үндэслэн хамтын шийдвэр гаргах ажиллагаа явагддаг. Энэхүү хамтын шийдвэр гаргахдаа оролцооны зарчмын үүднээс иргэдийн санал заавал тусгагдсан байх албагүй байдаг.

Иймд захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь иргэдийн оролцоог тэдний шууд оролцооны эрхтэй холбож авч үзэх шаардлагатай юм. Тодруулбал, иргэд захиргааны байгууллагатай хамтарч шийдвэр гаргахдаа тэдний (иргэдийн) саналыг заавал авч байж тухайн захиргааны акт хүчин төгөлдөр болохыг хэлнэ.

Одоогийн үйлчилж буй 500 гаруй хуулиудад захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо хүснэгтээр шинжилгээ хийлээ. (Хүснэгт 1)

Ийнхүү 400 гаруй хуулиудын зохих заалтуудад түүврийн шинжилгээ хийхэд

<sup>6</sup> Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. 2011 он

<sup>7</sup> П.Одгэрэл Захиргааны эрх зүйн ерөнхий анги. 2008 он. 128 дахь тал

## Жишээ: Хүснэгт 1. Иргэдийн оролцооны эрхийг зохицуулсан байдал

№	Нийгмийн салбараар нь	Жишээ авсан хууль	Иргэдийн шууд оролцоог хангасан зохицуулалт	Шууд бус оролцоог хангасан зохицуулалт
1	Суурь зохицуулалт	Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	Үндсэн хуулийн 16-р зүйлийн 9, 21-р зүйлийн 2, 25-р зүйлийн 16, 59-р зүйлийн 2 Засгийн газрын тухай хуулийн 19-р зүйлийн 1, 9-р зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3	Үндсэн хуулийн 26-р зүйлийн 2, Засгийн газрын тухай хуулийн 28-р зүйлийн 1, 29-р зүйлийн 5 –д
2	Эдийн засаг, бүтээн байгуулалт	Барилгын тухай хууль, Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль	Барилгын тухай хуулийн 8.2 Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйл	Барилгын тухай хуулийн 8.1 г.м
3	Байгаль орчин	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Агаарын тухай хууль	Агаарын тухай хуулийн 13-р зүйлийн 13.2.3, 21-р зүйлийн 4 г.м	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 7.4
4	Нийгмийн халамж, үйлчилгээ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 6.3	

иргэдийн оролцооны эрхийг хангасан 110 заалт байна. Ингэхдээ иргэдийн мэдээлэл авах, өргөдөл, гомдол гаргахыг эрхийг хангасан хуулиудыг хамааруулаагүй болно. (Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль гэх мэт.)

Эндээс захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь иргэдийн оролцооны хэлбэрийг хуульд зааснаар тодорхойлбол:

1. Оролцох, санал оруулах
2. Гэрээлэн гүйцэтгэх
3. Судалгаа хийх
4. Үнэлгээ хийх, дүгнэлт өгөх
5. Хяналт тавих
6. Дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх<sup>8</sup>

Ихэнх тохиолдолд иргэд шууд бус оролцооны эрх буюу хэрэгцээгээ хангуулах, санал хүсэлтээ дэмжүүлэх, эрхээ хамгаалуулах зэрэг асуудлаар төрийн

захиргааны байгууллагын үйл ажиллагаанд оролцдог. Харин иргэдийн шууд оролцооны хэлбэр болох засгийн газрын байгууллагуудтай харилцах, засгийн газрын бодлогод нөлөөлөх, шийдвэр гаргах зэрэгт оролцох нь хангалттай бус байна.

Ялангуяа орон нутгийн түвшинд иргэдийн шууд оролцоог дэмжсэнээр дэд бүтэц барьж байгуулах болон үйлчилгээний нэгж өртгийг ихээхэн бууруулж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах боломжийг бий болгодог. Дээрх түүвэр хийсэн хуулиудаас харахад захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцох арга зам, аргачлалын талаарх зохицуулалт бүрхэг, тодорхойгүй байна. Иргэдийн оролцоо бэлгэдлийн шинжтэй байх, (энэ тухай Арнштайны аргачлалын хүснэгтээс харна уу) шийдвэр гаргагчдын ашиг сонирхолд үйлчилдэг, хэрхэн оролцуулах талаар журамласан акт байхгүй зэргийг дурдаж болно. Жишээлбэл, Нийслэлийн засаг

<sup>8</sup> Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нь. (Удирдлагын академи. Судалгааны тайлан) 2011 он. 47 дахь тал

даргын тамгын газрын “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-д захирамжлалын төсөл боловсруулах, төсөлд санал авах зэрэг харилцааг нарийвчлан зохицуулсан боловч иргэдийн оролцоог хангасан заалт байхгүй байна. Харин Нийслэлийн засаг даргын тамгын газрын хувьд нээлттэй сайт дээр бүх захирамжаа гаргаж байгаа нь иргэдийн мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлсэн.

Жинхэнэ оролцоо мөн эсэхийг тогтоох суурь шалгуур бол тэгш бус байдлыг арилгаж чадсан эсэх явдал юм<sup>9</sup>. Энэ талаар АНУ-д Арнштайны “иргэдийн оролцооны 8

гаргах ажиллагаанд иргэдийн оролцоо ямар байгааг үнэлдэг.

Харин хуульд заасан дээрх оролцооны хэлбэрүүдийг төрийн захиргааны байгууллагууд шийдвэр гаргах ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж байгаа эсэхийг судлах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт судалгаа хийв.


Судалгаанд Нийслэлийн Засаг даргын 2013 оны нийт 800 орчим захирамжуудыг хамруулж авч үзсэн<sup>10</sup>. Иргэдийн оролцоог тогтоохдоо Арнштайны хүснэгтийг ашигласан болно.

Хүснэгт 2 Арнштайны иргэдийн оролцоог үнэлсэн аргачлал

Иргэд эрх мэдэлтэй байх	Иргэдийн хяналт	Хөтөлбөрүүдийг удирдаж, менежментийн бодлогын талаар хяналт тавж чаддаг, гэрээ хэлцлийг өөрчлөх эрх мэдэлтэй байх
	Эрх мэдэл шилжүүлэх	Төрийн зарим чиг үүргийг өөртөө хүлээн авч хэрэгжүүлэх
	Түншлэл	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг үүсгэж, гэрээгээр харилцан эрх эдэлж, үүрэг хариуцлага хүлээх механизм бий болдог.
Хэлбэрдэх	Тайвшруулах	Иргэдэд олгосон эрх мэдэл бэлгэдлийн шинжтэй байдаг.
	Зөвлөгөөн	Захиргааны байгууллагууд хурал зөвлөгөөн зохион байгуулж, мөн санал асуулга явуулдаг ч шийдвэр гаргах ажиллагаанд шууд нөлөөлж чаддаггүй.
	Мэдээлэл	Энэ нь нэг талаас гаргасан шийдвэрийнхээ талаар иргэдэд мэдээлэл өгч байгаа нь оролцоог дэмжсэн эхний алхам боловч зөвхөн нэг талын буюу иргэд саналаа илэрхийлэх боломжийг хязгаарладаг.
Оролцоогүй байх	Тушаал даалгавар	Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд зөвхөн нэг талын хүсэл зоригийн харилцаа давамгайлж байдаг.
	Элдвээр аргалах	Иргэдийг оролцуулах бүх боломжийг өөрийн байгууллагын дотоод дүрэм журмаар хааж өгдөг.

шатлал”-аргачлалаар захиргааны шийдвэр

Зураг .1 Иргэдийн оролцоог хангасан байдал



<sup>9</sup> Д.Саттертвэйт. Хотууд дахь оролцоот засаглал. 2008 он

Иргэд эрх мэдэлтэй байх эсэхийг тогтооход нэгдүгээр шалгуур болох иргэдийн хяналтан дор шийдвэр гаргаж байгаа захирамж нэг ч гараагүй байна. Энэ нь захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагааг иргэдийн хяналттай байх талаар шууд заасан зохицуулалт байхгүй байна гэж үзлээ.

Хоёрдугаарт, эрх мэдлээ шилжүүлэх замаар иргэдийн оролцоог хангаж буй байдал нь засгийн газрын худалдан авах ажиллагаа буюу тендерийн журмаар илрэн гарч байна.

<sup>10</sup> www.ulaanbaatar.mn

Энэ хэсэгт хамаарах захиргааны актууд 9% ийг эзэлж байна. Энэ нь засаглалын шинжтэй гэхээсээ бизнесийн зорилгоор иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах хэлбэр юм.

Өнөөдөр төрийн захиргааны байгууллагууд иргэдийн оролцоог хангаж буй үйл ажиллагааг зөвхөн тэдний тавьсан санал, өргөдөл, хүсэлтийг хүлээн авсан ба иргэдтэй уулзалт, зөвлөгөөн хийх, цахим сүлжээгээр санал асуулга явуулах зэргээр тодорхойлдог. Судалгаанаас харахад энэ төрлийн захиргааны актууд 27% ийг эзэлж байна. Үүнийг Арнштайны аргачлалаар тайлбарлавал хэлбэрдэх шинж нь давамгайлсан гэж дүгнэлээ. Иргэдийн оролцоог хангана гэдгийг зөвхөн тэдний мэдээлэл олж авах, өргөдөл гомдол гаргах, хурал, зөвлөгөөнд хамрагдсанаар ойлгож болохгүй.

Судалгаанд түүвэрлэгдсэн захиргааны актуудын 64% нь иргэдийн оролцоог огт хангаагүй байна гэж судлаач дүгнэсэн.

Энэ бүхнээс дүгнэхэд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцооны эрхийг хангахын тулд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Төвлөрлийг сааруулж, иргэний

нийгмийн байгууллыг дэмжих, Тодруулбал, оролцоот засаглал буюу иргэдийн зохион байгуулалттай бүлгүүдэд захиргааны шийдвэр гаргах эрх мэдэл олгох нь зүйтэй болов уу. Ингэхийн тулд иргэний нийгмийн байгууллагуудыг захиргааны байгууллага болохыг тодорхой заах, үүнтэй холбоотойгоор Төрийн бус байгууллагын тухай хуулийг үзэл баримтлалаар нь өөрчилж, Иргэний нийгмийн байгууллын тухай хууль болгох

- Захиргааны үйл ажиллагааны ерөнхий хуульд иргэдийн оролцоог хангах асуудлыг тусгайлан зарчим болгож оруулах. Түүнчлэн эрх бүхий субъектэд захиргааны шийдвэр гаргахын өмнө тухайн актын үйлчлэл нь иргэдийн нийтлэг эрх ашигтай холбоотой байвал заавал тэдний оролцоог хангахыг үүрэг болгосон байх,
- Иргэдийн оролцооны хэлбэрийг ямар шалгуур үзүүлэлтээр тооцохыг тусгай журамласан актаар тогтоох зэрэг болно.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ХБНГУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХЫГ ХОРИГЛОХ ЗАРЧИМ\*



Хууль зүйн яамны Хяналт, шинжилгээ  
үнэлгээ, аудитын газрын дарга, Хууль зүйн  
ухааны доктор /Dr.jur, LL.M Munich/

**Д.СҮНЖИД**

ХБНГУ-ын Үндсэн хуулийн “хүн бүр хуулийн өмнө эрх тэгш” /Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт/ хэмээх үндсэн зарчим нь ялгаварлан гадуурхахыг хориглодог /Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт/. Энэхүү ялгаварлан гадуурхахыг хориглох заалт нь дараах гурван цогц зохицуулалтыг агуулдаг. Үүнд:

1. Эрэгтэй, эмэгтэй тэгш байх эрх
2. Үндсэн хуульд нэрлэсэн бусад шинжээр ялгаварлан гадуурхахыг хориглох
3. Хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахыг хориглох тухай заалт хамаарна.

Ялгаварлан гадуурхалтын нэг шинжийг Үндсэн хуулинд тусгай нэг заалт болгон эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй хэмээн заасан. /Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийг 2 дахь заалт/

1949 оны ХБНГУ-ын Үндсэн

хууль нь эмэгтэйчүүдийн тэгш эрхийг баталгаажуулжээ. Тус улсын гэр бүлийн тухай хуульд 1953 оныг хүртэл нөхөр нь гэр бүлийн хамтын амьдралын бүх л асуудлаар шийдвэр гаргана, аав нь хүүхдийнхээ талаар эх эцгийн эрхийг дангаар хэрэгжүүлнэ, нөхөр нь эхнэрийнхээ хөдөлмөрийн харилцааг цуцалж болно, гэр бүлийн хөрөнгийг нөхөр дангаар захиран зарцуулна зэрэг заалтууд байжээ. Энэ бүхнийг тухайн хууль батлах 1900 оны үед ялгаварлан гадуурхалт гэж үздэггүй, харин хөдөлмөрийн хуваарь гэж үздэг байжээ. Адил хөдөлмөрт адил цалин хөлс олгох зарчмыг 1951 онд ХБНГУ-д хүлээн зөвшөөрсөн ба улмаар Үндсэн хуулийн энэ

\*2009 онд ХБНГУ-ын Мьонхэн хотын Людвиг- Максимилианы Их Сургуулийн хууль зүйн факультетэд “Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуульд тулгуурлан тэгш эрхийн зарчмыг Герман, Монголын эрх зүйд харьцуулах нь” сэдэвт докторын ажлын диссертацийн 70-85 дугаар хуудаснаас орчуулав.

“Der Gleichheitsgrundsatz in Bezug auf das allgemeine Gleichbehandlungsgesetz im deutschen und mongolischen Recht” Herbert Utz Verlag, Muenchen, 2009, S.70-85



заалтын дагуу хүйсээс улбаалан ямарваа нэг байдлаар ялгаварлан гадуурхахыг хориглосон байна. Төр зөвхөн ялгаварлан гадуурхалтыг хориглоод зогсохгүй, бодитой оршин буй ялгаварлан гадуурхалтыг арилгах нөхцөл бий болгох үүрэг хүлээсэн юм. /Үндсэн хуулийн 3 дугаар бүлгийг 2 дахь заалт, 2 дугаар өгүүлбэр/ Хүйсээс шалтгаалан ялгаварлан гадуурхалт нь шууд болон шууд бус хэлбэртэй байдаг, шууд бус ялгаварлан гадуурхалтын жишээ нь ажилд авах зард шууд эрэгтэй, эмэгтэй хэмээн хүйс заагаагүй хэдий ч түүнд дурьдсан шинж нь аль нэг тодорхой хүйсийн этгээд байхаар тоочсон байхыг ойлгоно. Цагийн ажил хийхэд энэ шууд бус ялгаварлан гадуурхалт хамгийн их яригддаг.

**Бусад шинжээр ялгаварлан гадуурхахыг хориглох** заалтын дагуу хэн нэгэн хүнийг хүйс, гарал үүсэл, арьс өнгө, хэл, төрсөн нутаг, итгэл үнэмшил, шашны болон улс төрийн үзэл бодлын улмаас ялгавартайгаар гадуурхаж буюу дэмжиж болохгүй. /Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 1 дэх өгүүлбэр/

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ялгаварлан гадуурхахыг хориглох** тухай заалтын дагуу хэнийг ч хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхаж болохгүй. /Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 2 дахь өгүүлбэр/ Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн амьдралд адил тэгш оролцох материаллаг болон материаллаг бус бусад нөхцлийг бий болгох, нийгмийн халамж, нийгмийн хамгааллын талаар үйлчилгээ үзүүлэх улмаар хөдөлмөрийн харилцаанд оролцох, Үндсэн хуулиар заасан эрхээ эдлэх, хамгаалуулах зэргээр илэрдэг өргөн хүрээтэй зарчим юм.

### Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хууль<sup>1</sup>

Европын Холбооноос эрх тэгш байх хуулийн зарчмыг бүх салбарт адил хангах, амьдралд бодитоор хэрэгжүүлэх тухайд анхаарал хандуулж “арьс өнгө, гарал угсаанаас үл хамааран тэгш хандах тухай” 2000 оны 43 дугаар тогтоол, “ажил, хөдөлмөр эрхлэхэд адил тэгш байдлыг хэрэгжүүлэх тухай” 2000 оны 78 дугаар тогтоол, “эрэгтэй эмэгтэй хүмүүсийн ажил хөдөлмөр эрхлэх, мэргэжлийн боловсрол олгох, *албан тушаал ахих*, зэрэглэл дээшлэх, ажлын нөхцөл хангахад адил хандах үндсэн зарчмыг хэрэгжүүлэх тухай” 2002 оны 73 дугаар тогтоол, “эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эд хөрөнгө, үйлчилгээ авахад адил боломжтой байх, тэгш хандах тухай” 2004 оны 113 дугаар тогтоол гэсэн үндсэн дөрвөн баримт бичгийн хүрээнд түүний гишүүн улс бүр уг ялгаварлан гадуурхалтыг хориглох, ялгаварлан гадуурхалтыг арилгах тухай үндэсний хууль тогтоомж гаргах үүрэг хүлээсэн билээ.

Эдгээр болон бусад холбогдох баримт бичгийн дагуу Европын Холбооны гишүүн улс бүр ялгаварлан гадуурхалтын дээр дурьдсан хэлбэрийг хориглоод зогсохгүй түүнийг бодитоор арилгахын тулд идэвхтэй үйл ажиллагаа явуулах шаардлагатай болсон юм.

Энэхүү үүргийн дагуу ХБНГУ-ын баталсан “Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хууль” 2006 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон бөгөөд энэ хуулийн зохицуулж байгаа харилцаа нь Үндсэн Хуулийн 3 дугаар

<sup>1</sup> Allgemeines Gleichbehandlungsgesetz, үг нь тэгш хандах тухай гэж орчуулагдах боловч утгаар нь дээрх байдлаар орчуулав.

зүйлийн 1 дэх заалтаар баталгаажуулсан тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэх улмаар аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглох, ялгаварлан гадуурхалтыг арилгах болно. Анх энэ хуулийн төсөл нь “Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль” гэсэн нэрээр томъёологдож байсан бөгөөд улмаар тэгш эрхийн зарчмыг хэрэгжүүлэх, баталгаажуулах, хангах үүрэг хүлээдэг төр, нийтийн эрх зүйн болон хуульд заасан бусад субъектүүдээс харилцаанд оролцогч иргэдийн хувьд уг зарчмыг хангах ёстой гэсэн үндэслэлээр хуулийн нэрийг өөрчлөн баталсан байна.

Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуулийн зорилго нь дараах нийтлэг долоон шинжээр буюу **арьс өнгө, гарал үүсэл, /угсаа язгуур/, хүйс, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, хөгжлийн бэрхшээл, нас болон бэлгийн чиг хандлагын улмаас** хуулиар зохицуулсан харилцаанд аливаа нэгэн байдлаар ялгаварлан гадуурхагдахаас хамгаалахад оршино. Энэхүү хууль нь зөвхөн шууд заасан энэ шинжийн ялгаварлан гадууралтаас гадна шууд бус ялгаварлан гадуурхалтаас хамгаалах, эрх бүхий этгээдийн зүгээс төвийг сахисан байр суурь баримтлахыг үүрэг болгох, нийгмийн аль нэг бүлгийг ялгаварлан гадуурхагдахаас урьдчилан сэргийлэх зорилготой.

Уг хуулийн зохицуулах харилцаа нь **хөдөлмөрийн харилцаа, эрүүл мэндийн хувийн даатгалын салбар, иргэний эрх зүйн харилцааны зарим тодорхой хэсэг /байр түрээслэх, түрээслүүлэх г.м/ болно.**

Үндсэн Хуулийн заалтын дагуу үүрэг хүлээгч субъектээс өөрийн дур зоргоор ялгавартай шийдвэр гаргахаас сэргийлэн тэгш эрхийн зарчмыг хангахын тулд тухайн тохиолдлыг харьцуулах боломж, тулгуур

асуудал, хууль зүйн талаас хянан шалгах нарийвчилсан зааг, хязгаар хэрэгтэй болдог. Энэхүү тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэглэхэд харьцуулах, үнэлэх, үнэ цэнийг нь жишихийг хамгийн рациональ байдлаар байнга хэрэглэх шаардлага тулгардаг байна. Тус хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглосон үндсэн долоон шинжийг дэлгэрэнгүйгээр авч үзье.

### 1. Арьс өнгө

ХБНГУ-ын хууль тогтоогчоос “арьс өнгөнөөс болж” гэж бус “арьс өнгөнөөс шалтгаалан” буюу “арьс өнгөний улмаас” ялгаварлан гадуурхахыг хориглох гэж хуульчилсан. Монгол хэлнээ арьс өнгө гэж орчуулж буй уг шинжийг “үүлдэр” гэдэг үгээр герман болон англи хэлнээ илэрхийлсэн байдаг. /Rasse, Race./ Тиймээс хүний үүлдэр гэж байхгүй гэж онолын хувьд үздэг учраас, Германы хуульчилсан энэхүү томъёоллын ялгаа нь чухал ач холбогдолтойд тооцогдож байгаа юм. Арьс өнгө нь хүний удамшил, насан туршид харагдах гадаад үзэмж, биеийн бүтэц, арьсны өнгө мөн нүдний хэлбэр /азийнханыг жартгар нүдтэн гэдэг/, тэр бүү хэл зарим нэг тодорхой нийгмийн бүлгийг илэрхийлдэг растафарисийн /Rastafaris/<sup>2</sup> ч юмуу үсний засалт, хэрэгсэл мөн түүнчилэн нүүрний хэлбэрийг ч хамааруулна. Арьс өнгө хэмээх энэхүү ялгаварлан гадуурхалтын нэг шинж нь гарал үүсэл буюу яс үндэстэй нягт холбоотой.

### 2. Гарал үүсэл буюу яс үндэс

Энэ шинж нь аливаа нэг улсын харьяат байхаас маш өргөн хүрээтэй ойлголт юм. Гарал үүсэл буюу яс үндэс хэмээх шинжид

<sup>2</sup> Энэ нэрийн утга нь 1930-аад оны үед үүссэн Христийн шашнаас салбарласан шүтлэгийн нэг урсгал, өнөөдөр Ямайкад 24000 хүн өөрийгөө ийм шүтлэгтэй хэмээн үздэг.



тодорхой соёлын болон газар нутгийн хүрээнд амьдрах ард түмэн, үндэстэн, ястан, омог эсвэл тухайн бүлгийг тодорхойлогч шинж чанар нь удамшдаггүй ч байж болох нийгмийн тодорхой бүлгийг хамруулдаг. Өргөн утгаараа өөрсдийн нийтлэг ялгагдах шинж, онцлогтой, адил нийтлэг соёлтой хүмүүсийн бүлгийг угсаатан гэж нэрлэдэг байна. Хэл, яс, үндэс, түүх, оршин буй газар нутаг, төрөлх эх орон, соёлын үнэ цэнэ, зан заншил, хандлага зэрэг шалгуураар нийгмийн нэг гарал үүсэл бүхий бүлэг хэмээн үзэж болно. Англи улс өөрийн жишиг тогтоосон шүүхийн шийдвэрээр нэг яс үндэстэн байх шалгуурын хамгийн чухлыг дээрх хэдэн шинж байна хэмээн тайлбарласан ба энэ шалгуурын дагуу Энэтхэгийн сикхүүд<sup>3</sup>, еврей нарыг нэг гарал үүсэлтэй гэж үзсэн бөгөөд харин Растафарис нарыг нэг гарал үүсэлтэй буюу нэг яс үндэстэнд хамааруулахгүй гэжээ. Ялгаварлан гадуурхалтыг хориглох энэхүү шинжийн эрх зүйн үйлчлэл чиглэх этгээд нь өнгөт арьстан, эрлийз, хурлийз, синти болон рома<sup>4</sup> нар ч байж болно. Харин нэг улсын тодорхой нэг хэсгийг ястан, угсаатан гэж үздэггүй. Жишээ нь: зүүн герман, эсвэл баруун герман гэх мэт. Зөвхөн нэг улсын харьяат иргэн байх, эсвэл нэг үндэстэн байх нь гарал, үүсэл, яс үндсийг тодорхойлохгүй гэж үздэг. Энэ нь гэхдээ аль нэг үндэстэнийг ялгаварлан гадуурхаж болно гэсэн үг бол мэдээж биш юм. Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуулиар жишээ нь өөрийн компанийн ажилтнуудаас зөвхөн германчуудад нэмэлт мөнгөн тэтгэмж, хөлс олгоно, харин бусад улсын харьяат ажилтанд олгохгүй гэвэл энэ нь ХУУЛИЙН дагуу зөвтгөх ямарваа нэг үндэслэлгүй ялгаварлан

гадуурхалт болох юм. Тэгш байдлыг хангах тухай энэ хуулиар нийгмийн гарал байдлыг хамгаалахгүй. Гарал үүсэл, яс үндэс хэмээх энэ ялгаварлан гадуурхалтын шинж нь Европын Холбооны иргэд, гадаадын иргэд, гуравдагч орноос ирсэн иргэд, баск /Испани/, курд /Турк/ г.м үндэстэний цөөнх, цагаачлагчид, хожим суурьшигчид гэх мэт бүгдэд нь хамаарна. Тухайн хүн герман улсын иргэний харьяалал авсан эсэх нь ястан, угсаатны гарал үүсэл огт хамааралгүй. Амьдралд арьс өнгөнөөс шалтгаалан ялгаварлан гадуурхах нь ертөнцийг үзэх үзэл буюу шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхахтай давхцан илрэх нь элбэг байдаг. Жишээ нь: лалын шашинтан эсвэл еврей хүнийг ажилд авахгүй байх гэх мэт. Тэгвэл одоо энэ хууль гарсны дараа дээрх хоёр шинж дээр нэмээд яс, угсааны гарал үүслийн хувьд мөн ялгаварлан гадуурхагдсан эсэх тухай давхар авч үзэх шаардлагатай болж байна. Герман улсын дотоодын муж улс, ястаныг тусад нь яс, угсааны гарал үүсэл гэж үзэх эсэх нь нэг мөр болоогүй ойлголт хэвээр байна. Жишээ нь: баваричууд, энэ нь ХБНГУ-ын нэг муж улсын нэр бөгөөд хэлний аялга, үндэсний уламжлал, хувцас зэргээр өөрийн онцлогтой.

### 3. Хүйс

Энэ нь хүний бодит хүйс буюу эрэгтэй эмэгтэй манин гэдгийг илэрхийлнэ. Хүйсээ солиулах нь мөн хүйсийн шинжид хамаарна. Мөн энэхүү биологийн хүйснээс гадна гэрлэсэн эмэгтэй, ижил хүйстэн эсвэл хөгжлийн бэрхшээл зэрэг тодорхой бүлгийг ч мөн энэ шинжид хамааруулдаг. Энэ шинж нь ялангуяа эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглоход илэрдэг. Үндсэн Хуулийн 3 дахь зүйлийн 2 дахь заалтын 2 дэх өгүүлбэр

<sup>3</sup> Сикх нь 15 дугаар зуунаас үүссэн шашны урсгал, гол шүтэгчид нь Энэтхэгийн зүүн хойт хэсэгт оршдог, тэдний нэр, хувцаслалт зэрэг нь өөрсдийн онцлогтой.

<sup>4</sup> Цыгануудыг албан ёсоор нэрлэдэг томьёолол.

нь зөвхөн хүйсний улмаас ялгаварлан гадуурхахыг хориглоод зогсохгүй, цаашлан амьдралын бодит харилцааны тэгш байдал буюу материаллаг тэгш байдлыг тэнцвэртэй байлгахыг зорьдог. Энэ нь ялангуяа хөдөлмөрийн эрх зүйн харилцааны хүрээнд ажилд орох, амралт авах, хөдөлмөрийн хөлс, цалин авах, ажлын байрны дарамтанд өртөх, чөлөөтэй ажиллах хөдөлмөрийн орчин бүрдүүлэх, албан тушаал, зэрэглэл ахих боломж, эхчүүдийн хамгаалалт зэрэгт хамаатай яригддаг. Жирэмслэлт, хүүхэд асрах чөлөө зэрэг ч мөн хүйс хэмээх ялгаварлан гадуурхахыг хориглох шинжээр дамжуулан илэрнэ. Тухайлбал: Жирэмсний улмаас өвчтэй байх, жирэмсэн хүнийг ажилд авах, жирэмсэн хүн тодорхой ажил хийхийг хориглох, жирэмсэний улмаас ажлаас халах гэх мэт. Энэхүү шинж нь эмэгтэйчүүдийн улс төрийн үйл ажиллагаа, идэвхтэй байдлыг ч мөн хамруулдаг. Жирэмсэн болон хүүхэд асрах чөлөөтэй эмэгтэйчүүдэд таатай бус нөхцөлөөр хандахыг Европын Холбооны тогтоолоор хориглосон. Энэ нь ажлын байрыг нь хадгалах тухайд хамаатай. Мөн хүүхдээ өвчтэй үед асрах чөлөөтэй байсан эхчүүдийг ажлаас халахаас хориглохыг заасан байна.

Харин гэрлэлт нь германы эрх зүйд аль нэг шинжээр ялгаварлан гадуурхалтыг хориглох шинжтэй шууд холбогддоггүй. Хөдөлмөрийн эрх зүйн практикт гэрлэлт, гэр бүлийн байдал нь нийтийн эрх зүйн субъектээс тэгш хандахад хамаатай байж болно. Жишээ нь: нийгмийн хамгааллын дэмжлэг үзүүлэхэд гэрлэсэн байх, хүүхэдтэй байх эсэх нөлөөлөх, гэр бүлийн орлого, хүүхдийн тоо зэрэг нь хамаатай байж болно. Байр түрээслэхэд гэр бүл, хүүхэдтэй эсэх нь ялгаварлан гадуурхахыг хориглоход шууд хамаатай байдаг.

#### 4. Ертөнцийг үзэх үзэл, шашин шүтлэг.

Энд нэгдүгээрт нь шашин шүтлэгийн буюу сүмд харьяалагдах эсэх, итгэл үнэмшлийн бүлэгт хамаарах эсэх, дагадаг, шүтдэг, итгэдэг аль нэг шашин болон шүтлэгийн урсгалыг хамруулна. Томоохон шашнууд болох христ, еврей, лал, будда, хинди, шинто зэрэг нь ямар нэг эргэлзээгүй энэ шинжид хамаарна. Мөн ямарваа нэг шүтлэггүй хүн ч мөн энэ заалтаар хамгаалагдана. Чех улсад шашингүйчүүдийг ч гэсэн ялгаварлан гадуурхахаас хуулиараа хориглохоор тодорхой заасан байна. Шашнаас салбарласан урсгал, чиглэлүүд ч ялгаагүй энэ шинжээр хамгаалагдана. Хэдийгээр шашин гэдэг нэгдмэл тодорхойлт байхгүй ч бодит байдал, материаллаг ертөнцөөс ангид байдаг гэж үздэг бол харин ертөнцийг үзэх үзэл нь дотоод ертөнцөд байдаг. Харин үүнийг маш өргөн утгаар авч үзвэл бүх л ойлголт, хандлагыг ертөнцийг үзэх үзэлд хамааруулж болох юм. Шашныг нийтийн эрх зүйн субъект болох хувьд нь авч үзвэл ямар нэг зөрчилтэй ойлголт байдаггүй, Еховын гэрч, шинэ апостолын сүм, мормонууд болон “анагаагч арми” гэж нэрлэсэн буяны үйл үйлдэхийг голлосон христийн урсгалын чөлөөт сүм гэх мэт. Энэ нь тухайн улсын дотоодын хуулиар зохицуулагдсан байдаг. Харин маргаантай асуудал нь шүтлэгийн гаж урсгал уу эсвэл шашин уу гэж ялгахад хамгийн тод илэрнэ. Жишээ нь: сайнталожи /scientology/ Герман улсад өнөөдрийг хүртэл уг урсгалыг шашин гэж хүлээн зөвшөөрөөгүй байгаа. Харин АНУ-д үүнийг шашин хэмээн хүлээн зөвшөөрсөн. Бусад Европын Холбооны гишүүн улсуудад харилцан адилгүй үзэл, хандлагатай байна.

Шашин шүтлэгт өөрийнхөө амьдралыг өөрийн зарчмын дагуу зохион байгуулах

эрх ч мөн хамаарна. Хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд энэ шинжтэй холбоотой илэрдэг бэрхшээл нь шашин, шүтлэгийг илэрхийлсэн хувцаслалт болон тодорхой өдөр, сар буюу баярын өдөр, мөргөлийн цаг зэрэг байдаг. Германд лалын шашинтай эмэгтэйчүүдийн толгойн алчуурын тухай олон удаа хянаж шүүхийн шийдвэр гарсан байдаг. Холбооны хөдөлмөрийн шүүхээс хэрэв толгойн алчуур зүүх нь хөдөлмөрийн харилцаанд саад, бэрхшээл учруулж улмаар эдийн засгийн хохирол учруулахаар бол ажил олгогчоос уг ажилтаныг халах эрхтэй хэмээн тайлбарласан. Энэ тайлбарыг эсэргүүцэгчид зөвхөн хувцаслалтаас болоод хөдөлмөрлөх нөхцөлд саад учруулах тухайд болон тэр нь эдийн засгийн хор хохирол учруулсан гэдгийг нотлоход хэцүү, боломжгүй хэмээн үздэг. Толгойн алчуурын тухайд Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуулиар Үндсэн хуулийн зорилгын дагуу зөвтгөгдөж болох шууд бус ялгаварлан гадуурхалт уу эсвэл хөнгөн хэлбэрээр илэрч байгаа шууд ялгаварлан гадуурхалт уу гэдгийг ялгах шаардлагатай болдог. Шууд бус ялгаварлан гадуурхалтын хувьд уг толгойн алчуур нь лалын шашны илэрхийлэл болох тухайд яригдана. Шууд ялгаварлан гадуурхалт нь уг алчуурыг зөвхөн шашны улмаас бус хувцасны хэв маяг, мода, улс төрийн шалтгааны улмаас зүүсэн тухайд яригдаж болно. Толгойн алчуур буюу гивлүүр зүүсний улмаас ялгаварлах нь бодит нөхцөл байдал дээр хүйсийн улмаас, шашны улмаас, яс үндсийн гарал угсааны улмаас ялгаварлаж байгаа хэрэг юм. Тэгэхээр толгойн алчуурын хэргийг шашны болон ертөнцийг үзэх үзлийн үүднээс шалгах шаардлагатай болно. Ажил олгогч нь Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуулийн дагуу зөрчил үүсэхээс

зайлсхийх стратеги баримтлах үүрэг хүлээнэ. Хэрэв өөрөөр шийдэх, өөр хувилбар сонгох, ямар нэг байдлаар зайлсхийх боломжгүйн улмаас шууд бус ялгаварласан үйлдэл гаргасан бол уг үйлдлийг хуулийн дагуу гэж үзэх боломжтой. Хэрэв шашны нийгэмлэг буюу бүлэг нь өөрөө ажил олгогч бол энэ нь тусдаа асуудал болдог. Хэрэв хэн нэгэн хүн шүтлэггүйн төлөө ялгаварлагдсан бол мөн л энэ шашин шүтлэгээр нь гэдэг шинжээр ялгаварлагдсанд тооцно.

Хоёрдугаарт нь ертөнцийг үзэх үзэл гэдэг ойлголтыг энэ хуулиар ялгаварлан гадуурхаж болохгүй нэг шинж болгон заасан. Европын Холбооны улсуудад энэ шинжийг харилцан адилгүй ойлгодог. Австрид үүнийг явцуу утгаар буюу итгэл үнэмшил гэсэн байдлаар ойлгодог бол Их Британид илүү өргөн утгаар буюу шашин шүтлэгийн, үзэл санааны, улс төрийн хандлага, амьдралын утга учир, ертөнцийн тухай хүн хувийн үзэл бодлын болон нийгмийн стандартын үүднээс цогцоор ойлгох, хувийн амьдралд уг зарчмыг баримтлах гээд л бүгдийг багтаана гэж үздэг байна. Зарим оронд тухайлбал Словак, Унгарт үүнийг итгэл үнэмшил хэмээн ойлгодог байна. Европын хүний эрхийн тунхагийн 14 дүгээр зүйлд улс төрийн болон бусад үзэл бодол хэмээн томьёолсон байдаг бөгөөд энэ заалтын итгэл үнэмшил гэдгийг зөвхөн хатуу тогтсон итгэл үнэмшил байх ёстой хэмээн тайлбарладаг юм. Улс төрийн намд хамаарах үйл ажиллагаа бол итгэл үнэмшлийг төлөөлөхгүй. Энэ тайлбарын үүднээс улс төрийн үзэл бодлыг ертөнцийг үзэх үзэл гэж үзэхгүй. Учир нь энэ нь амьдралын зөвхөн нэг ерөнхий хэсгийг л хамаардаг, тиймээс шашин юмуу эсвэл ертөнцийг үзэх үзэл шиг үнэ цэнэ бүхий хандлагатай адилхан биш хэмээн үздэг. Ертөнцийг үзэх үзлээр

халхавчлан эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгаа бол тэр нь дангаар ертөнцийг үзэх үзэл болохгүй. Европын Холбооны гишүүн улсуудын ялгаатай тайлбар, хандлагын улмаас энэхүү ертөнцийг үзэх үзэл хэмээх шинжийн хамаарах хүрээ нь өнөөдөр ч тодорхой зааглагдаагүй байна. Ертөнцийг үзэх үзэл нь шашиныг бодвол материаллаг зүйлээс халин гарсан далд ертөнц, нууц ухамсар байхгүйгээр ялгаатай гэдгийг дэлхий даяар хүлээн зөвшөөрдөг байна. Шашин эсвэл ертөнцийг үзэх үзэл гэдэг ойлголтын доор дэлхий ертөнцийн тухай үзэл, хандлагаас гадна хувь хүний өөрийн амьдралын зорилгодоо хүрэх талаар тодорхой илэрхийлэл, мөрдлөгтэй холбоотой гэж шүүхээс үздэг байна.

### 5. Хөгжлийн бэрхшээл

Европын социал хартагийн 15 дугаар заалтад биеийн, оюун ухааны, сэтгэл зүйн хөгжлийн бэрхшээл нь мэргэжлийн сургалт, ажил мэргэжил болон нийгмийн амьдралд оролцох, эргэж оролцоход адил эрхтэй хэмээн заасан байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан тодорхойлолтын дагуу нэг нэгнээсээ уялдаатай гурван хүчин зүйлийг хөгжлийн бэрхшээл хэмээн тодорхойлж байна. Европын Холбооны 2000 оны 78 дугаар тогтоол нь хөгжлийн бэрхшээл гэдгийг тодорхойлоогүй. Германд Үндсэн хуулиар хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлахыг хориглох тухай заалт үйлчилдэг. Мөн Нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлийн тухай хуулиар энэ зарчмыг илүү тодорхой болгосон. Энэ хуулийн заалтын дагуу хөгжлийн бэрхшээл гэдэг нь бие махбодын үүрэг, оюун ухааны чадамж, сэтгэл зүйн эрүүл мэндээ б-аас дээш сараар алдах өндөр магадлалтай

бөгөөд өөрийн насандаа тохирсон хэвийн байдалд эргэж орох боломжгүй болсны улмаас нийгмийн амьдралд ердийн байдлаар хэвийн оролцоход сөргөөр нөлөөлөхөөр бол хөгжлийн бэрхшээлтэй гэж үзнэ. 2002 оноос ХБНГУ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэгш хандах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу нийтийн эрх зүйн субъектээс хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ялгаварлан гадуурхахыг хориглосон. Энэхүү хуулийн зорилго нь 1 дүгээр зүйлдээ тодорхойлсоноор хөгжлийн бэрхшээлтэй хүний ялгаварлан гадуурхалтыг арилгах, багасгах, түүнчлэн нийгмийн амьдралд оролцох боломжийг хангах, мөн өөрийн зорьсон амьдралаар замнах боломжийг олгоход оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглосон Үндсэн Хуулийн заалт нь иргэний болон хөдөлмөрийн эрх зүйд шууд үйлчилнэ. Нийгмийн халамжийн тухай хуулиас ялгаатай нь Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуульд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн тусгай эрх, үйлчилгээ авах боломжийг хангадаггүй. Харин Тэгш байдлын тухай ерөнхий хуулиар хөгжлийн бэрхшээлтэй хүнийг аливаа ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байлгах ингэснээрээ өөрийн бие махбодын болон оюун ухааны хязгаарлагдмал байдлын улмаас эрх зүйн болон бусад байдлыг дордуулахаас сэргийлэх юм. Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтын хувьд тухайн хүн нь ямар төрлийн буюу хүнд эсвэл хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байх эсэх нь ялгаагүй гэсэн үг юм. Бүх өвчнийг хөгжлийн бэрхшээл гэж үзэхгүй. Үүнээс улбаатай өвчин болон хөгжлийн бэрхшээл хоёрын заагийг тогтоох тухай төвөгтэй асуудал урган

гардаг. Нийгмийн халамжийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолтыг хөдөлмөрийн харилцаанд оролцох хугацаа болон боломжийг дээр дурьдсан байдлаар заасан. Энэ тодорхойлолтоор ДОХ өвчинтэй хүн хөгжлийн бэрхшээлтэйд тооцогдохгүй. Харин архины дон, мансууруулах бодисын дон, хэт таргалалт, хөдөлмөрийн осол, нүдний хараа муу, сэтгэцийн бэрхшээл, удаан хугацаагаар өвчтэй байх, сэтгэл санааны хямрал зэргийг хөгжлийн бэрхшээлд оруулж болно. Тэгш байдлын тухай ерөнхий хуульд хөгжлийн бэрхшээлийг ялгаварлан гадуурхагдахгүй байх тусгай нэг шинж болгон оруулсан нь өвчний улмаас халагдахгүй байх мөн эрүүл мэндийн даатгалын гэрээг хувийн даатгагчаар хийлгэхтэй холбоотой хуулийн хамгаалалтыг өргөнөөр хэрэгжүүлэх боломжтой юм. Иргэний эрх зүйн салбарт хөгжлийн бэрхшээлийг хөдөлмөрийн эрх зүйтэй адилхан ойлгодог.

## 6. Нас

Европын Холбооны 2000 оны 78 дугаар тогтоолын дагуу нас гэж биологийн насыг ойлгоно. Зөвхөн хөгшин насыг ялгаварлан гадуурхагдсанд тооцох бус ялгаагүй залуу үеийн насыг ч хамааруулна. Хэзээнээс хөдөлмөрийн эрх зүйн харилцаанд хамгаалах ёстой нас эхлэхийг уг тогтоолд заагаагүй. АНУ-д 1967 оны хуулиар 40-өөс дээш насны хүнийг хөдөлмөрийн харилцаанд хамгаална гэдгийг заасан байдаг. Германы Хамтын гэрээний тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх заалт 2 дахь өгүүлбэрийн дагуу ажил олгогч болон үйлдвэрийн зөвлөл нь ажилтныг тодорхой нас хэтэрсэний улмаас ялгаварлан гадуурхахыг хориглоно хэмээн заасан. Энэ шинж нь германы хөдөлмөрийн эрх зүйн шинэ сорилтыг бий болгож байна гэж үздэг.

## 7. Бэлгийн чиг хандлага

Бэлгийн чиг хандлага нь үгийн утгаараа хэрэглэгдэнэ. Юуны өмнө энэ ойлголт нь тухайн хүнийг бусад хүнтэй сексийн хувьд ямар харилцаатайг илэрхийлнэ. Ижил хүйстэн эмэгтэй, эрэгтэйчүүд, хүйсээ солиулсан болон аль ч хүйсэд хамаарахгүй хүн зэрэг бүгдийг энэ шинж багтаадаг. Аль ч хүйсэд хамаарахгүй хүний ялгарах онцлогийг анхаарах ёстой гэж Европын шүүхээс үзсэн. Амьдралд ижил хүйстэний хамгаалалт ямар байгаа нь ач холбогдолтой байдаг, тухайлбал гэрлэлт, гэр бүлд олгох хөнгөлөлт, гэр бүлд олгох дэмжлэг, хөдөлмөрийн харилцааны бусад арга хэмжээ, байгууллагын тэтгэвэрт гарах систем зэрэгтэй уялдан ижил хүйстэнийг ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах шаардлагатай байдаг. Транссексуалист хүмүүст ч энэ бас хамаатай. Хэрэв ялгаварлан гадуурхалтаас ангид байх хуулийн энэ хамгаалалтыг эдлэхийг хүсвэл хүйсээ солиулсан хүн ажил олгогчдоо өөрийн хүйсээ солиулсан талаар мэдээлж өөрийн амжилт нь тогтвортой биш байж болзошгүй гэдгийг сануулах үүрэгтэй. Ажил олгогчийн хувьд тусдаа хувцас солих өрөө гаргах эсэх, холбоотой бусад урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой эсэх нь маргаантай асуудал хэвээр байгаа юм.

Хэвийн биш гаж сексийн хандлага педофил, содоми, некрофил, садо мазохист зэргийг бэлгийн чиг хандлагаар ялгаварлан гадуурхахгүй гэдэг шинжийн хүрээнд хуулиар хамгаалахгүй. Хуулиар хориглоогүй хэдий ч нийгэмд нийтээр хүлээн зөвшөөрөгддөггүй сексийн хандлагыг чухам ямар хүрээнд яаж авч үзэх вэ гэдэг нь тодорхойгүй. Жишээ нь: нэгээс дээш бэлгийн хамтрагчтай байх г.м

Европын Холбооны Комиссоос Германы хуулийн энэ заалтыг илүү тодорхой болгох

ижил хүйстэн гэр бүлийг ердийн гэр бүлтэй адилд тооцон адилхан тэтгэмж, тусламж хүртэхээр эрх зүйн зохицуулалтыг бий болгох ёстой гэж зөвлөсөн.

#### **8. Бусад ялгаварлан гадуурхалтын шинж**

Тэгш байдлын тухай ерөнхий хуулийн 1 дүгээр зүйлд нэрлээгүй бусад ялгаварлан гадуурхагдах үндэслэл болж болзошгүй шинжүүд нь энэ хуулиар бус харин Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтаар хамгаалагдана. Ажилд орж чадахгүй байх, хүүхэд асрах эх, эцгийн чөлөө, ажиллах хугацаандаа өвчтэй байх, улс төрийн үзэл бодол, хорих ялтан, гэрлэсэн хос, хамтран амьдрагч нар зэргийг Тэгш байдлын тухай ерөнхий хуулийн 1 дүгээр зүйлийн нэрлэсэн шинжтэй холбож ойлгох уялдаа шууд байхгүй байгаа бол арьсны өнгө, эхчүүдийн чөлөө, жирэмслэлт, хэл зэрэг шинж нь уг хуулийн хамгаалах шинжид шууд хамаатай байна.

Зарим тохиолдолд ялгаварлан гадуурхалт нь шууд аль нэг шинжээр илрэхгүй байж болно. Энэ тохиолдолд тухайн этгээд түүнийгээ нотлох үүрэгтэй байна. Энэ нь өртөгч этгээдээс ялгаварлагдсанаа нотлохын

тулд өөрийн хувийн нууцыг бусдад дэлгэх шаардлагатай болдог тул бэрхшээлтэй байдаг гэж үздэг.

Мөн гуравдагч этгээдийн төлөө хүн хуульд заасан аль нэг шинжийн улмаас ялгаварлан гадуурхагдах тохиолдол гарвал яах вэ гэдэг асуудлыг уг хуулиар тодорхой зохицуулаагүй. Жишээ нь: ижил хүйстэн хүүгийнх нь улмаас аавыг нь ажлаас халах, гэр бүлийн нэгийг нь нөгөөгийнх нь шүтдэг шашны улмаас ялгаварлан гадуурхах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эх, эцгийг мөн ялгаварлан гадуурхах зэрэг тохиолдол.

Тэгш байдлыг хангах тухай ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь заалтаар ялгаварлан гадуурхах тухай зааварчилахыг мөн хориглодог.

Энэ хуулийн эрх зүйн үйлчлэл чиглэх субъект нь хувь хүн байна, харин хуулийн этгээд буюу хүмүүсийн нэгдэл, бүлэг байх боломжгүй. Гэсэн хэдий ч Европын Холбооны нэрлэсэн дөрвөн тогтоолд гишүүн улсуудын хуулийн этгээд нь өөрийн арьс өнгө, гарал үүслийн яс угсааны улмаас ялгаварлан гадуурхагдаж байгаа тохиолдолд төрөөс хамгаалах үүрэгтэй хэмээн тодруулсан байдаг.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



## СОНГУУЛИЙН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ НЬ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн  
зөвлөх багш (LL.M, Bonn)

### Д.ҮҮРЦАЙХ

Монгол улс ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойшх 23 жилийн түүхэнд нийтдээ 6 удаагийн Улсын Их Хурлын, 5 удаагийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын, 6 удаагийн Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулаад байна.

Эдгээр сонгуулиуд нь тухай бүр сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн гэх маргаантай асуудлуудыг дагуулж байсан бөгөөд ард түмний төрийн эрх барих дээд байгууллагаа сонгодог Улсын Их Хурлын сонгуулийн асуудал нь онцгой анхаарал татдаг юм. Учир нь Улсын Их Хурлын сонгууль явагдсаны дараа сонгуулийн маргааны улмаас тухайн сонгуулийн үр дүнд бүрдсэн улс төрийн хүчний харьцаанаас шалтгаалан сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг удаан хугацаагаар хүлээн зөвшөөрөхгүй байх, Улсын Их Хурал бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж чадахгүй болох нөхцөл байдлууд үүссээр байна.

Ийм нөхцөл байдлууд үүсэхийн гол шалтгаан нь сонгох, сонгогдох эрхийн хууль зүйн баталгаа бүрэн хангагдаагүй, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтын

учир дутагдалтай байдал гэж үзэж болно. Тиймээс энэхүү өгүүлэлд Улсын Их Хурлын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэхтэй холбогдон үүссэн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудлыг авч үзнэ.

Төрийн бүх эрхийг ард түмэн барьдаг, энэхүү бүрэн эрхээ голчлон төлөөллийн зарчмаар хэрэгжүүлдэг байх нь Үндсэн хуулийн суурь зарчим тул ард түмний төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагыг бүрэлдүүлэхэд ард түмний хүсэл зориг чөлөөт, ардчилсан сонгуулийн үр дүнд бодитойгоор тусгагдсан тохиолдолд л бүрэн төлөөлөх чадварыг олно. Тиймээс сонгуулийг Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн аливаа эргэлзээ, маргаангүй, сонгогчдын өгсөн саналын үр дүнгээр төрийн эрх барих төлөөллийн байгууллагыг бүрэлдүүлэхүйцээр зохион байгуулж явуулах шаардлагатай байдаг.

#### Эдүгээгийн эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Үндсэн хуулийн /цаашид “Үндсэн хууль” хэмээн товчлох/ Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т “ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал,

түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх”-ийг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулахаар зохицуулсан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 2012 оны шинэчилсэн найруулга Арван нэгдүгээр бүлэгт сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол, маргаан шийдвэрлэх харьяалал, журмыг хуульчилсан.

Ингэхдээ Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн Арван нэгдүгээр бүлэгт Үндсэн хуулийн шинжтэй зөрчил, маргааныг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалтгүй орхисон нь хууль тогтоогч Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар зохицуулагдсан хэмээн үзсэнийх болов уу.

Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн нилээд олон зүйлд сонгуулийн тодорхой зөрчлүүдэд хүлээлгэх захиргааны хариуцлагыг тухайлан хуульчилж, зарим сонгуулийн зөрчлүүдээс үүдэн гарах хууль зүйн үр дагаврыг мөн материаллаг байдлаар хуульчилан зохицуулжээ. Улсын Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасны дагуу уг хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

Уг хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт “Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй

нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” хэмээн заасан бөгөөд Эрүүгийн хуулийн 82<sup>1</sup>, 130, 130<sup>1</sup>, 131 дүгээр зүйлүүдэд сонгох, сонгогдох эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Харин шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр сонгох, сонгогдох эрхийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсоноос үүсэх тухайн гэмт этгээдийн эдлэх ялаас бусад хууль зүйн үр дагаврыг тухайлбал Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.34, 35.35 дахь хэсгүүдэд зааж өгсөн байна.

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяаллыг тогтоосон 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн дагуу “Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд” гаргаж шийдвэрлүүлэх ба 56 дугаар зүйлийн 56.1.1, 57 дугаар зүйлийн 57.1.5-д заасанчлан хэсгийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг тойргийн хороо, тойргийн хорооны шийдвэрийн талаар гаргасан гомдлыг Сонгуулийн ерөнхий хороо шатласан байдлаар хянан шийдвэрлэхээр байна.

Үндсэн хуулийн цэц 2005 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 2/02 дугаар дүгнэлтдээ “Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн



хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна" гэж зааж, "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн ... 4.1.6,-д "Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ын ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг ... зөрчсөн байна" хэмээн шийдвэрлэжээ.

Энэхүү шийдвэрийн дагуу сонгуулийн аливаа маргааныг дээд шатны сонгуулийн хороонд нь гомдол гаргах байдлаар шийдвэрлүүлсээр эцэст нь Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг Үндсэн хуулийн цэцэд Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр өгч шийдвэрлүүлэх зохицуулалттай болжээ. Энэхүү шийдвэрийн үр дагаварт зарим эрдэмтэд “захиргааны олон зүйл маргааныг Захиргааны хэргийн шүүхийн харъяаллаас гаргаснаар”<sup>1</sup> алдаатай болсон хэмээн шүүмжлэлттэй хандсан байдаг.

<sup>1</sup> Б.Чимид. Сонгуульд суралцахуй: тогтолцоо, үйл явц, эрх зүй. УБ, 2008, 280 дахь тал.

Сонгуулийн хууль тогтоомж Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан нь хэм хэмжээний хяналтын журмаар Үндсэн хуулийн цэцээр хянагдах боломжтой ба сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн тухай хэрэг маргаан нь зөвхөн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарсны дараа тухайн шийдвэр нь Үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр Үндсэн хуулийн цэцээр хянан шийдвэрлэгдэх боломжтой болох юм.

### **ХБНГУ-ын сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх зохицуулалт**

ХБНГУ-ын хувьд сонгуулийн маргааныг шийдвэрлэх онцгой процессийг хуульчилж өгсөн бөгөөд энэ нь ардчилсан сонгууль явуулах болсноос хойшх сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэж ирсэн эрх зүйн уламжлалаар тайлбарлагддаг.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд хоёр шаттай байхаар зохицуулсан.

Уг хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн нэгдүгээр өгүүлбэрт зааснаар “Сонгуулийг шалгах нь Бундестагийн эрх хэмжээний асуудал” байх бөгөөд Бундестагийн сонгуулийн шалгалтын тухай хуулийн 3, 11, 12 дугаар зүйлийн дагуу Бундестагийн Сонгуулийн шалгалт, иммунитет, дэгийн байнгын хороо хянан үзэж, Бундестагаас гарах шийдвэрийг бэлтгэн хуралдаанд оруулна. Бундестагийн хуралдаан энгийн олонхоор шийдвэрээ гаргана. Хэдийгээр шийдвэрийг бэлтгэнэ гэж байгаа боловч бодит байдал дээр шийдвэрийг уг байнгын хороо гаргадаг гэж хэлж болно. Шийдвэр нь хэлбэрийн хувьд шүүхийн шийдвэрийн адил бүтэцтэй байдаг ба Бундестагийн хуралдаанаар санал хураахаас өмнө илтгэгч гишүүн товч үг хэлдэг байна.

Ийнхүү парламент өөрийн сонгуулийн хууль ёсны байдлыг шалгах нь нэг талаас сонгуулийн байгууллагын шийдвэрүүдийг хянаж, парламентын хяналтыг хэрэгжүүлж буй хэлбэр, нөгөөтэйгүүр түүхэн уламжлалын хувьд үндсэн хуульт ёсны эхэн үед шүүхийн хараат бус байдал зохистой хэмжээнд хангагдаагүй байсантай холбоотой юм.<sup>2</sup>

ХБНГУ-ын хувьд Бундестаг сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх процессийн хугацаа тогтоож өгөөгүй байдаг тул Бундестагийн зүгээс ихэвчлэн хугацааг удаашруулж, гишүүдийнхээ суудал болон өөрийн сонгогдсон сонгуулийн дүнг хамгаалах байдал ажиглагддаг байна. Харин Нордрайн Вестфален муж улсын Ландтагийн сонгуулийг шалгах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Ландтаг сонгуулийн маргааныг 3 сарын дотор шийдвэрлээгүй бол татгалзсан хэмээн үзэж, шууд Муж улсынхаа Үндсэн хуулийн шүүхэд давж заалдах боломжийг хуульчилж өгсөн байдаг нь сонгуулийн маргааныг шуурхай шийдвэрлэхэд ач холбогдолтой болсон юм.<sup>3</sup>

Гомдол гаргах эрх нь Бундестагийн сонгуулийн шалгалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Сонгогч, сонгогчдын бүлэг, албан үүргийн хувиар муж улсын Сонгуулийн хорооны дарга, Холбооны сонгуулийн хорооны дарга, Бундестагийн ерөнхийлөгчид олгогдсон байна. Гомдлыг сонгуулийн өдрөөс хойш 2 сарын дотор бичгээр, үндэслэлтэйгээр гаргах ёстой.

Дараагийн шатанд ХБНГУ-ын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн шалгалтын тухай хуулийн 18

дугаар зүйл, Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн № 3, 48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу Бундестагийн сонгуулийн маргааныг хянаад гаргасан шийдвэрийн эсрэг:

- Гомдлыг нь хүлээж авахаас татгалзан шийдвэрлэгдсэн сонгогч болон сонгогчдын бүлэг,
- Бундестагийн суудал нь маргаантай байгаа гишүүн,
- Бундестаг дахь намын бүлэг эсхүл Бундестагын хуулиар тогтоосон гишүүдийн тооны 10 хувиас дээш тооны гишүүдийг хамааруулсан цөөнх тухайн шийдвэр гарснаас хойш хоёр сарын дотор үндэслэлээ гарган Холбооны Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхтэй байдаг.

Ийнхүү Холбооны Үндсэн хуулийн шүүхээр эцэслэн шийдвэрлүүлэхийн учир нь Бундестагийн сонгууль ард түмний бүрэн эрхийг хэрэгжүүлэх, төрийг эмхлэн байгуулах суурь акт, төрийн засаглалын хүлээн зөвшөөрөгдөх чанарын ардчилсан гинжин хэлхээний эхлэл болдогт оршино.

Онолын хувьд сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа нь сонгууль хүчинтэй эсэх буюу сонгуулийн үр дүнд парламентын суудал зөв хуваарилагдсан эсэхийг шалгадаг объектив эрхийн маргаан байдаг.<sup>4</sup> Бундестагийн сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх эрх зүйд 2012 оны 7 сарын 12-ны өдрийн сонгуулийн эрх зүйн өөрчлөлтийг хүртэл субъектив эрхийг хамгаалах шаардлагагүй хэмээн үздэг байлаа. Учир нь нэгд, парламентын суудлын хуваарилалт нэг саналаар л шийдэгдээгүй бол сонгуулийн шалгалтын гол зорилго болсон парламентыг зөв бүрэлдүүлэх явдал

<sup>2</sup> Lqwer/Tettinger Kommentar zur Verfassung des Landes NRW, 2002. Art. 33. Rdn. 1; Ruzsoly, Der Staat 1982, S. 205.

<sup>3</sup> H.Meyer, KritV 1994, 312. (359); Lqwer/Tettinger Kommentar zur Verfassung des Landes NRW, 2002. Art. 33. Rdnr. 32.

<sup>4</sup> BVerfGE 1, 208 (238); 1, 430 (433); 4, 370 (372 0; 22, 277 (281); 37, 84 (89); 40, 11 (29); 66, 369 (378).

ач холбогдолгүй, хоёрт, тухайн сонгогчийн сонгох эрх нь бусад олон сонгогчийн эрхийг цаг хугацаанд нь хүчин төгөлдөр сонгуулийн үр дүн болгож хэрэгжүүлэхэд саад болох нь зүйд нийцэхгүй гэж үзсэн явдал юм. Харин сонгогдох эрхийн зөрчлийн хувьд парламентын суудлын хуваарилалтад нөлөөлөхүйц учраас боломжтой. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн энэхүү байр суурь шударга шүүхээр шүүлгэх эрх, эрхийн хамгаалалтын Үндсэн хуулийн зарчмыг зөрчиж байна гэсэн шүүмжлэлийг дагуулдаг.<sup>5</sup> Бундестаг 2012 оны 7 дугаар сарын 12-ны өдөр баталсан сонгуулийн эрх зүйн өөрчлөлтөөр субъектив эрхийн хамгаалалтыг нэмэгдүүлэх чиглэлд Сонгуулийн шалгалтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг субъектив эрх нь зөрчигдсөн байх нь сонгуулийн шалгалтын зүйл болгож, 2 дугаар зүйлийг сонгогчийн сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн нь сонгуулийг хүчингүй болгохоор бус байсан ч зөрчлийг тогтоох шийдвэр гаргахаар болгож, Холбооны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 48 дугаар зүйлийг сонгогч сонгох эрхээ зөрчсөн хэмээн гомдол гаргахын тулд 100 сонгогчийн бичгээр гаргасан дэмжлэгийг авсан байх шаардлагыг хасаж тус тус өөрчилсөн байна.

Холбооны Үндсэн хуулийн шүүх нь зөвхөн өргөдөл, гомдолд дурдагдсан сонгуулийн зөрчлийг тогтоож, сонгуулийн дүн, мандатын хуваарилалтыг зөвтгөхөөр хязгаарлалгүй мөн холбогдох сонгуулийн хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянан шийдвэрлэдэг юм. Харин Бундестагт мэдээж ийм боломж байхгүй юм.

ХБНГУ-ын хувьд сонгуулийн шалгалтын материаллаг хэм хэмжээг бүх

сонгуулийн алдаа, зөрчил, тохиолдлуудыг тодорхойлох боломжгүй учраас тухайлан хуульчилж өгөөгүй. Харин сонгуулийн алдаа нь мандатын хуваарилалтад нөлөөлсөн байх зарчмаар тодорхойлсон юм.<sup>6</sup>

Мөн сонгуулийн маргаан нь нийт улсын хэмжээнд явагдсан сонгуулийн дүнг сонгууль болсноос хойш зохистой хугацаанд нэгэн зэрэг гаргах зорилгын үүднээс сонгуулийн үйл явц дунд бус голчлон сонгуулийн дараа хуулиар тогтоосон сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх процессоор шийдвэрлэдэг байхыг Үндсэн хуулийнх нь суурь зарчмуудын агуулга шаарддаг.<sup>7</sup> Улс даяарх сонгуулийн байгууллагуудын шийдвэр бүртэй холбогдсон маргаануудыг сонгуулийн үйл явц дунд хянан шийдвэрлэнэ гэвэл сонгуулийн үйл явц удааширч, ард түмэн төрийн эрх барих бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох нөхцөл байдал үүсэх билээ.

### Дүгнэлт

Улсын Их Хурлын сонгуультай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх зохицуулалтыг эдүгээ Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн өөрчлөлтийн төслийг боловсруулан, олон нийтээр хэлэлцүүлж буй дор онцгой анхаарч, урьдын бэрхшээлтэй асуудлуудыг гаргахгүй байхаар, гадаадын ардчилсан орнуудын сайн туршлагыг харгалзан өөрчлөхийг хичээх шаардлагатай байна. Тиймээс зарим зарчмын саналаа энд илэрхийлэхийг хүсэж байна.

Нэгд, сонгуулийн зөрчлийг Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ийн дагуу Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр дамжуулан Үндсэн

<sup>5</sup> Lang, Subjektiver Rechtsschutz im Wahlprüfungsverfahren, 1. Aufl., Berlin 1997 S. 183.; харьцуулан үзэх: BVerfGE 1, 208 (238); 1, 430 (433); 22, 277 (281); 34, 201 (203); 40, 11 (29); 48, 271 (280); 59, 119 (123).

<sup>6</sup> Schreiber, Wolfgang: Handbuch des Wahlrechts zum Deutschen Bundestag, 8. neubearb. und erw. Aufl., KUlN, Berlin, Bonn, 2009. § 49, Rdnr. 13 ff.

<sup>7</sup> BVerfGE 14, 154 (155) Намын сонгуулийн нэрийн жагсаалтыг хүлээж аваагүй тухайд.

хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргаан болгох нь зүйтэй юм.

Хоёрт, сонгуулийн маргаан аль болох сонгуулийн үйл явц дунд бус сонгууль явагдаж дууссанаас хойш хянан шийдвэрлэгдэж, Улсын Их Хурлын суудал хуваарилалт, сонгуулийн дүнд нөлөөлөхүйц байгаа тохиолдолд зөвтгөн шийдвэрлэгддэг зохицуулалт хийх нь Улсын Их Хурал цаг хугацаандаа бүрэлдэж, ард түмний төрийн бүх эрхийг барих бүрэн эрх зүй ёсоор хэрэгждэг байх нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Гуравт, сонгуулийн зөрчлийн талаарх материаллаг хэм хэмжээг хуулиар тухайлан тогтоох бол аль болох хийдэлгүй, төрийн тогтвортой байдал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны чадамжийг бууруулахгүйн тулд сонгуулийн дүн, Улсын Их Хурлын суудал хуваарилалтад боломжит бага хэмжээгээр халдахуйц, зөвхөн суудал хуваарилалтад нөлөөлсөн сонгуулийн зөрчил гарсан тохиолдолд сонгуулийг хүчингүй болгох,

сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний мандатыг хүчингүй болгох гэх мэт хууль зүйн үр дагавар үүсдэг байхаар зохицуулах нь зохистой.

Дөрөвт, сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэх хэргийн харъяаллыг нэг мөр, тодорхой болгож, аливаа сонгуулийн зөрчлийн улмаас захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан байх нь Үндсэн хуулийн цэцээс тухайн сонгуулийн маргааныг хянан хэлэлцэхэд саад болдог бус харин нотлох баримт, дэмжлэг болдог байх ёстой гэж үзэж байна.

Тавдугаарт, сонгох, сонгогдох субъектив эрхийн зөрчлийг Улсын Их Хурлын суудал хуваарилалт, сонгуулийн дүнд нөлөөлөхгүй байсан ч хянан шийдвэрлэж, тухайн зөрчил гарсан гэдгийг тогтоож, зөрчсөн этгээдэд аливаа хариуцлага хүлээлгэдэг, цаашид тийм алдаа гарахгүй байх эрх зүйн тодорхой байдлыг буй болгодог байхаар зохицуулах шаардлагатай юм.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ОЮУНЫ ӨМЧИЙН ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА: РАДИКАЛЬ БОЛОН ХЯНАЛТЫН ОНОЛУУД



Хүний эрхийн Үндэсний Комиссын Бодлогын  
дүн шинжилгээ, хүний эрхийн боловсролын  
хэлтсийн дарга, докторант

### Г.АГАР-ЭРДЭНЭ

*“Биет эд юмсын харилцааг зохицуулахын тулд эрх зүйн хэм хэмжээ тогтоох, хэрэгжүүлэх шаардлагатай байдаг бол хүн өөрийн бодол, санаа сэдлийг ямар нэг эрх зүй, философигүй өмчилж чаддаг.”*

- Брэд Тэмплтон

Оюуны өмч<sup>1</sup> нь нийгэм, эдийн засаг, оюуны санааны хөгжлийн өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагаас хамааран улам бүр ач холбогдолтой болж байна.

<sup>1</sup> Оюуны өмчийн тухай ойлголтыг 1845 оны 10 дугаар сард АНУ-ын Массачусеттсын тойргийн шүүх Дэволл болон Брауны хооронд үүссэн патентын маргааныг хэлэлцэх үед албан ёсоор хэрэглэсэн гэсэн мэдээ байдаг. Шүүгч Чарльз Л. Вудбюри шүүхийн шийдвэрт бичихдээ: “Хэн нэгэн улаан буудай тарьж, түүнийг ургуулдаг шиг, хүний ашиг сонирхол, оюуны хөдөлмөр гэх мэт “оюуны өмч”-ийг бид мөн адил энэ арга замаар хамгаалж чадах байна...” гэсэн байдаг. Харин энэ ойлголтыг Европт дэлгэрүүлсэн хүн бол Францын зохиолч А. Нион юм. Тэрээр 1845 онд хэвлүүлсэн Droits civils des auteurs, artistes et inventeurs буюу “Зохиолч, зураач, зохион бүтээгч зэрэг иргэдийн хууль ёсны эрх” хэмээх номдоо “оюуны өмч” гэсэн нэр томъёог оруулжээ. НҮБ-аас 1967 онд баталсан Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенцид зааснаар “оюуны өмч” гэж: утга зохиол, урлаг, шинжлэх ухааны бүтээл, тоглогчдын тоглолт, дуу авианы бичлэг болон радио телевизийн нэвтрүүлэг, хүний бүтээн туурвисан бүх шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, бараа болон үйлчилгээний тэмдэг, хуулийн этгээдийн нэр болон илэрхийлэл, шударга бус өрсөлдөөний эсрэг хамгаалалт болон аж үйлдвэр, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн салбарт гарч буй оюуны бүтээлээс үүдэн гарах бусад бүх эрхийг хэлнэ. Монгол Улс 1979 онд энэхүү конвенцид нэгдэн орсон.

Үүнтэй холбоотойгоор хувийн өмчийн онолын судалгааг оюуны өмчийн салбарт үргэлжлүүлэх шаардлага байгаа төдийгүй энэ чиглэлээр цөөнгүй сэтгэгчид үзэл санаагаа дэвшүүлж, зохиол бүтээлээ туурвиж байна. Оюуны өмчид чухам ямар шалгуураар хандах тухайд Ричард Рэйсман, Брэд Шэрман, Лайонэл Бэнтли, Брэд Тэмплтон зэрэг сэтгэгчдийн үзэл, сэтгэлгээ голлох байр суурийг эзэлж байна. Эдгээрээс багагүй дэмжлэг авч буй нь өмчийн үнэ цэнэд суурилсан хандлага буюу оюуны өмчийн радикаль онол, өмчийн хяналтад суурилсан хандлага буюу оюуны өмчийн хяналтын онолууд юм. Эдгээр онолууд нь хувийн өмчийн сонгодог онолын үзэл санаан дээр суурилж, оюуны өмчийн тухай ойлголтыг батжуулахад чиглэснээрээ ихээхэн дэмжлэг хүлээж буй. Энэ сэдвээр дээрх хоёр чиг хандлагыг товч авч үзье.

## 1. Өмчийн үнэ цэнэд суурилсан хандлага

Хувийн өмчийн сонгодог онолын үндэс болсон өөрийгөө өмчлөх эрхийн тухай ойлголтыг оюуны өмчийн салбарт нэвтрүүлэх замаар жинхэнэ өмч гэж хүлээн зөвшөөрүүлэхэд чиглэсэн онолын урсгал /өөрөөр оюуны өмчийн радикаль онол гэж нэрийддэг/ юм.

Өнгөрөгч хугацаанд Ж.Локк, Д.Юм зэрэг сэтгэгчид өмчлөх эрх нь хүн өөрөө өөрийнхөө бие махбод, оюун санааг удирдаж, өмчлөхөөс эхэлдэг<sup>2</sup> гэсэн тайлбар хийж байв. Ж.Локк хүн өөрийгөө анхнаас өмчилсөн байх нь өөрийн хөдөлмөрийг эзэмших, улмаар өмчтэй болох явдалтай учир зүйн холбоотой гэж үзсэн юм. Өмчлөх эрх дэх өөрийгөө өмчлөх тухай ойлголт ёсоор аливаа субьектын өмчийн объекттой харилцах харилцаа өөрийгөө өмчлөхөөс эхэлдэг ба энэ сэтгэлгээ чөлөөт хүсэл зоригийн ахуйтай холбогддог. Хүн өмчлөх эрхээ хэрэгжүүлж буйн бодит илрэл бол өмчийн объектыг өөрийн эрх чөлөөт хүсэл зоригийн үндсэн дээр, гадны хараа хяналтаас ангид өмчилж байгаа явдал юм гэдгийг энэ үзлийг дэмжигчид тайлбарладаг. Өөрийгөө өмчлөх эрх нь өмчийн тухай хөдөлмөрийн онолын бүрэлдэхүүн хэсэгт багтдаг.

Өнөөгийн сэтгэгчдээс Жералд Коэн Өөрийгөө өмчлөх эрх, эрх чөлөө ба тэгш эрх номдоо “Хүн өөрийн бие махбодыг бүхэлд нь удирдан захирч байхдаа л өөрөө өөрийнхөө өмчлөгч мөн бөгөөд харин тэр хүнийг албадан хөдөлмөрлүүлж байгаа тохиолдолд эзэн нь түүний биеийг захирна. Албадан хөдөлмөрлүүлж буй хүн өөр хэн нэгэнд туслахгүй, ямар нэг хөлсгүйгээр бусдын хөдөлмөрийг зөвхөн өөрийн тусын тулд ашигладаг. Тэгвэл өөрийгөө өмчилнө

гэдэг нь хүн өөрийн оюуны болоод биеийн бүх баялгийг удирдаж, өөртөө ашиг бий болгох эрхтэй гэсэн санааг илэрхийлэх нь гарцаагүй юм”<sup>3</sup> гэж тайлбарлаж байв.

Оюуны өмчийг дэмжигчид өөрийгөө өмчлөх тухай үзэл санаанд тулгуурлаж технологийн хөгжлийн үр дүнд ирээдүйд молекулын түвшинд ашиглагддаг технологитой болох цаг үе ирвэл өмчийн үнэ цэнийг дээр дурдсан технологи тодорхойлохоос бус тухайн зүйлийн материаллаг эсэх нь чухал биш болно гэсэн тайлбар хийжээ. Энэ урсгалыг дэмжигчид цааш нь тайлбарлахдаа, хүн бол өөрөө өөрийгөө өмчилдөг эзэн нь. Өөрөө өөртөө эзэн байх, өөрийгөө мэдэх эрх зэрэг ойлголтууд нь зөвхөн өмч ба эрх чөлөөний үндсэн зарчмууд дээр суурилоод зогсохгүй иргэний эрхийн тулгуур үзэл санаанд үндэслэдэг гэсэн байна.

Оюуны өмчийн радикаль онолоор өөрийгөө өмчлөх гэдэг нь толгойн доторх бодолдоо эзэн нь байна гэсэн үг юм. Энэ ойлголтын тусламжтайгаар оюуны өмч бол жинхэнэ өмч гэсэн тайлбарыг хийдэг. Мөн хүний бодож, сэтгэж буй оюун сэтгэхүйн үйл ажиллагаа бол ертөнц дээрх жинхэнэ, бодит харилцаа юм гэж үздэг ба тэдний нэг болох сэтгэгч Э.Тоффлер “Өмчийн хамгийн чухал хэлбэр эдүгээ үл хүртэгдэх болжээ. Энэ бол мэдлэг юм. Мэдлэгийг өдий төдий хүмүүс сайн сайхныг бүтээхийн тулд болон шинэ мэдлэгийг бий болгохын тулд нэгэн зэрэг ашиглах боломжтой”<sup>4</sup> гэсэн байдаг.

Радикаль онол ёсоор оюуны өмч өөрийн гэсэн давуу чанартай агаад энэ нь оюуны өмчид бусад материаллаг эд баялаг шиг хязгаар үгүй явдал юм. “Би өөрийн газар буюу үл хөдлөх хөрөнгийг өмчилж минийх

<sup>2</sup> John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 27

<sup>3</sup> G.A Cohen (1995), *Self-ownership, Freedom and Equality*, Cambridge: Cambridge University Press.

<sup>4</sup> Э.Тоффлер (2007), *Эрх мэдлийн огцом хувирлууд* [1990], Орч Ч.Баатар. 533-р тал.



гэж нэрлэнэ гэдэг харин ч эргэлзээтэй юм. Нутгийн уугуул овог аймаг суугуул нутгаа өөрийн газар хэмээн итгэж ашиглаж байтал аль нэг Засгийн газар гарч ирээд газрыг нь булаах боломжтой бөгөөд тэрхүү булаан эзлэгч засгийн газраас зөвшөөрөл хүсч, мөнгө төлж байж газраа худалдаж авахад хүрч байна. Харин үүний дараа л тэд газраа өөрийн өмч гэж нэхэмжлэх эрхтэй болдог. Учир нь нийтийн зүгээс хүлээн зөвшөөрсөн баримт бичиг байгаа. Харин хүний толгой доторх бодол, санаа сэдлүүдийг ямар ч бичиг баримт, нийгэмгүйгээр өмчилж болдог.” гэж Б.Тэмплтон үзэл санаагаа тайлбарласан байна.

Хүний бодож, сэтгэж буй бүхэн толгойноос нь гадагш гараагүй байх үедээ түүний оюуны өмч хэмээн хүлээн зөвшөөрөгдөж чаддаг юм бол хэрэвзээ тухайн этгээд өөрийн бодлыг бусдад илэрхийлэн гаргавал түүнийг нь хэрхэн зохицуулах вэ гэсэн асуудал үүсч байна. Түүгээр зогсохгүй материаллаг эд юмсаас ялгаатай нь зарим тохиолдолд тухайн бодлын эзэн этгээдээс шалтгаалах зүйлгүйгээр өөр хэн нэгэн хүн түүнийхтэй адил бодолтой байж болно. Иймээс бусадтай хуваалцсан бодлыг зохицуулах эрх зүй, эсхүл философи хэрэгтэй юм.

Оюуны өмч нь жинхэнэ өмч болох тухай радикаль онолыг хөгжүүлэгчдийн анхаарлаа хандуулдаг зүйл нь өмчөө хяналтдаа байлгаж буй өмчлөгчийн хууль ёсны эрхийг хэрхэн хангах тал дээр төвлөрдөг. Тэд өмчлөгчийн хууль ёсны эрхийг хэрхэн хамгаалах тухай Ж.Локк болон түүнийг залгамжлагчдын үзэл санааг энэхүү өмчийн төрөлд ч мөн адил хөгжүүлж, оюуны өмчийг хүлээн зөвшөөрүүлэх нааштай үр дагаврыг авчрах боломжтой гэж үздэг.

Энэ онолын төлөөлөгчид оюуны өмчийн эрхийг өмчийн хяналтын тухай онолын тусламжтайгаар хамгаалж болно гэж үзжээ.

## 2. Өмчийн хяналтад суурилсан хандлага

Оюуны өмчийн хяналтын онол ёсоор оюуны өмчийг сайтар ойлгохын тулд эхлээд өмчлөх эрхийн мөн чанарыг ойлгох хэрэгтэй гэж үздэг. Өмч нь ямар нэг зүйлийг эзэмших тухай биш, харин түүнд тогтоосон хяналт юм гэдгийг ойлгох хэрэгтэй гэж уг онол тайлбарладаг<sup>5</sup>.

Хувийн өмчийн хяналт нийгмийн хяналтын хамтаар улам төгөлдөрждөг гэж сонгодог онол тайлбарладаг. Тодруулбал, энэхүү хяналт нь нэгдүгээрт, бусдын хэрэгцээ шаардлага болон нийтийн сайн сайхныг үл харгалзан баялгийг хувь хүн хэрхэн ашиглахаа шийдвэрлэх бүрэн эрхийг илэрхийлдэг, хоёрдугаарт, хувийн өмчийг нийтийн зардлаар, нийтийн хүчээр хамгаалах механизм ажиллах ёстой гэсэн үг юм. Өмчлөх эрх нь өөрөө нийгмийн зорилго ба хувь хүний эрх хоёрын харилцан уялдаат байдлаар илэрдэг<sup>6</sup> жам ёсны эрх тул нийтийн зүгээс хувь хүний өмчлөх эрхийг хамгаалах зохицуулалт байх ёстой юм.

Эдийн засагч Эрнандо дэ Сото “Хувийн өмч бол цэвэр төсөөлөл юм” гээд “ямар нэгэн байшинг та хараад хэн эзэмшдэг болохыг нь мэдэхгүй. Өчигдөр минийх байсан байшин өнөөдөр таных боллоо гээд юу ч өөрчлөгдөхгүй... Хувийн өмч бол байшин өөрөө биш харин байшингийн тухай эдийн засгийн ойлголт хууль зүйн загварт биеллээ олсон зүйл юм” гэсэн байдаг.

Үүнийг тодруулбал, хэн нэгэн хүн ямар нэг зүйлийг өмчлөхийг хүсвэл түүнийгээ хянах л асуудал яригдах ба цөөнгүй тохиолдолд тухайн объектыг ашиглаагүй байхад ч түүнийгээ хянаж байх явдал гэж тайлбарладаг. Жишээ нь, мөнгөнд хүмүүс өөрийн биеэр шууд хяналт тавьж, харьцаж

<sup>5</sup> A.M.Honore Ownership. 1961. Ed A.G.Guest. Oxford essays in Jurisprudence, Oxford: Oxford University Press.

<sup>6</sup> Harel Alon, Theories of Rights /The Blackwell Guide to the Philosophy of Law and Legal Theory/ (2005)Blackwell Publishing Ltd. Pg 198

чаддаггүй. Учир нь зах зээл хөгжсөн өнөө үед хүмүүс өөрийн биеэр өмчид хандахаас илүү тэдний энэхүү эрхийг хамгаалж, баталгаажуулж байх өөр арга хэрэгслийг шаардаж байдаг гэж энэ онолыг дэмжигчид үздэг. Тэдний нэг Калифорнын их сургуулийн эрдэмтэн М.Постер “Хөгжингүй орнууд дахь хөдөлмөр нь эд юмстай ажиллах явдал байхаа нэгэнт больж хүмүүст нөлөөлж буй мэдээллүүд болж байна”<sup>7</sup> гэж хэлсэн байдаг.

Өмч бол бүхэлдээ хяналт юм гэсэн үзлийг тууштай дэмждэг Б.Тэмплтон үүнийг газрын эрх зүйн харилцаан дээр тайлбарлахыг оролджээ. Тэрээр “ихэнх хүмүүс өөрсдөө хэзээ ч хөл тавьж үзээгүй, эсвэл ганц хоёр удаа л очиж үзсэн газрыг эзэмшиж байдаг. Тэгсэн атал тэд энэ газар дээрээ өөр бусдыг зорчихыг хэзээ ч зөвшөөрдөггүй. Өөрөөр хэлбэл газар нь зөвхөн харахад л зориулагдсан зүйл мэт байдаг. Гэсэн ч тэд цаашид уг газраа хяналтдаа байлгахыг хүсдэг” гэжээ. Өмчийн хяналтын талаарх дээрх жишээн дээр үндэслэн оюуны өмч бол хяналт шаарддаг албан ёсны институт болох тухайд зарим нотолгоог тэд хийсэн юм. “Та гартаа ямар нэгэн объектыг бодитойгоор атгаж, мэдэрч байгаа бол энэ нь материаллаг зүйл юм. Гэхдээ жинхэнэ үнэ цэнэ нь гарт мэдрэгдэхгүй, тэрхүү барьж боломгүй зүйлд байна. Оюуны өмчийн эрх гэдэг бол зохион бүтээгч өөрийн бүтээсэн зүйлсийг мэдэлдээ байлгаж, хянах эрх юм”<sup>8</sup>. гэжээ.

Б.Тэмплтоны үзэл санааг хувийн өмчийн сонгодог онолын тусламжтайгаар тайлбарлавал, өмчлөгчийг эзгүй хойгуур хэн нэг этгээд газар дээгүүр нь яваад өнгөрсөн бол тухайн өмчлөгчөөс ямар ч биет зүйл алдагдахгүй. Түүний газарт зөвшөөрөлгүй нэвтэрснээрээ чухам юуг зөрчсөн бэ гэвэл өмчлөгчийн өмчлөлийн зүйлээ буюу газраа өөрийн хяналтдаа байлгах эрхийг

зөрчсөн үйлдэлд шалтгаан нь байгаа юм. Тодруулбал, газар өмчлөлийн харилцаанд өмчлөгч этгээд тэр газар дээрх хөрс, шороог гартаа атгаад сууж байх явдал биш гэдэгтэй адилхан зохиогчийн эрхийн харилцаанд өмчлөгч өөрийн бүтээлээс яг хэдэн хувийг өөртөө үлдээх тухай асуудал биш юм гэсэн тайлбарыг хийж болно.

Тиймээс оюуны өмчийн салбар дахь зохиогчийн эрхийн харилцаа нь оюуны хөдөлмөрөөр бүтсэн өмчийг хэн хувилж авах эрхтэй вэ гэдэгт гол зохицуулалтыг хийхэд чиглэж байна. Компьютерын программ хангамжаас ямар нэг зүйлийг зөвшөөрөлгүй хуулбарлан авсан тохиолдолд энэ үйлдэл нь өмчлөгчийн буюу зохиогчийн бүтээсэн оюуны өмчөө хяналтдаа байлгах эрхийг ноцтойгоор зөрчсөнд тооцогдох ба АНУ-д Гэмт хэргийн тухай хуулиар кибер гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэж байна. Хэдийгээр бүтээлийн эх хувь өмчлөгчид үлдэж байгаа боловч өмчийн хяналтын онолын үүднээс авч үзвэл тухайн объектоос тодорхой нэг хэсэг нь хулгайлагдсанд тооцогдоно. Үүнийг Гэмт хэргийн тухай хуульд заахдаа бусдын хөдлөх хөрөнгийг хууль бусаар авсан, эсхүл түүнд хууль бусаар хяналт тогтоосон этгээдийг хулгайн гэмт хэрэгтэн гэж тооцож, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид бусдын хөрөнгийг хууль бусаар авч байгаа, эсхүл хууль бусаар хяналт тавьж байгаа гэмт хэрэгтний үйлдэл нь зайн үйл, хууль ёсны өмчлөгчөөс эд хөрөнгийг нь авах гэсэн зорилго нь оюун санааны байдал, гэмт хэрэгтэн эд хөрөнгийг авах, эсвэл хяналт тогтоох ямар нэг хууль зүйн эрхгүй байдал нь туслах нөхцөл байдал, хохирогч эд хөрөнгөө алдаж буй нь хориглосон үр дагавар буюу хор хохиролд тооцогддог<sup>9</sup>.

Хэн нэг хүн машин хулгайлснаар хууль ёсны өмчлөгчийн өмчлөх эрх зөрчигдөнө гэх мэтээр эд юмсын эрх зүйн харилцаа

<sup>7</sup> Mark Poster [1984] Foucault, Marxism and History. Oxford: Policy Press. Page 53

<sup>8</sup> Brad Templeton A Radical Theory of Property. Para 4, verse 16

<sup>9</sup> Susan W. Brener Virtual Crime [www.boalt.org](http://www.boalt.org) Орчуулсан Ц.Хүрэл-Очир. Эрх зүй сэтгүүл. 2010 18-19



ойлгомжтой байдаг. Харин хуулиар хамгаалагдсан номыг зөвшөөрөлгүй хуулбарласан тохиолдолд тухайн номын зохиогч, эсвэл өмчлөгч нь эх хувиа өөрт хадгалж үлдсэн байх боломжтой. Хэдийгээр энэ тохиолдолд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ тодорхой болчихсон боловч жирийн иргэдийн хувьд бусдын оюуны өмчийг хүндэтгэхгүй байх, хийдүүлэх үйлдлийг гаргасаар байна. Үүний нэг жишээг Б.Тэмплтон тайлбарлахдаа, “Газраас Ролекс цаг олоод эзэнд нь буцааж өгөх ёстойг ухамсарласан, буцааж өгөхгүй бол өөрийгөө хууль зөрчинө гэдгийг мэддэг хүмүүс бодох санах зүйлгүйгээр программ хангамжийг хууль бусаар хуулбарлаж л орхидог.<sup>10</sup>” гэжээ. Зүй нь хууль бус үйлдэл хийсэн этгээдэд *abusus non tollit usum*<sup>11</sup> гэдгийн адил ямар нэг эрх үүсэхгүй.

Дээрх харьцуулсан жишээ нь оюуны өмчийн талаарх ойлголтын цар хүрээг өсгөн нэмэгдүүлэхэд тус дөхөм болох боломжтой юм. Учир нь оюуны өмчийн эрхийг ихэнх онолчид зохиогчийн эрхтэй холбон ойлгож, түүгээр дамжуулж тайлбарладаг ба үүний шалтгаан нь түүнийг зөвшөөрөлгүйгээр хувилж олшруулахыг хориглосон байдагтай холбоотой. Гэвч оюуны өмчийн эрх зүйн ойлголтод хамаарах хуулбарлах, олшруулах зэрэг үйлдэл нь зохиогчийн өөрийн бүтээлд тавих хяналтын зөвхөн нэг хэсэг болдог байна.

### Дүгнэлтийн оронд:

Дээрх чиг хандлагууд нь оюуны өмч нь жинхэнэ өмч болох, улмаар өмчлөх эрх мөн эсэх талаарх маргаанд онолын үүднээс оновчтой хариулт өгч чадахуйц гэж үнэлэгддэг. Дурдсан бүхнээс үзвэл ямар нэг мэдээллийг хялбар, энгийнээр хуулбарлан авч болдгоосоо хамаарч

оюуны өмчийн эдийн засгийн үнэлэмж нь уламжлалт өмчийн тогтолцооныхоос ихээр ялгарч байна. Гэвч АНУ болон Европын ихэнх хөгжингүй улсуудад үүний эрх зүйн зохицуулалт, журмыг сайтар хийсэн байдаг<sup>12</sup>. Тухайлбал, 2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Европын зөвлөлөөс баталсан Цахим гэмт хэргийн тухай конвенцид 2013 оны 11 дүгээр сарын байдлаар 41 улс нэгдэн орж, соёрхон баталсан ба 11 улс нэгдэн орохоор гарын үсэг зураад байгаа билээ. Энэхүү конвенцийн дагуу компьютерын программ хангамж эвдэх, хууль бусаар хуулбарлах, интернэт орчинд залилан мэхлэх, арьс өнгөөр ялгаварласан мэдээлэл түгээх, хүүхдийг садар самуунд уруу татах зэрэг гэмт хэрэгтэй гишүүн орнууд хамтран тэмцэх үүрэг хүлээсэн ба конвенцийн 2-р бүлэгт эрүүгийн хэрэг гэж тооцох гэмт хэргийн төрлүүдийг тодорхойлохдоо зохиогчийн эрх, бусад оюуны өмчийн эсрэг гэмт хэргийг багтаасан байдаг<sup>13</sup>.

Түүнчлэн хөгжингүй улсуудад үл хөдлөх хөрөнгийн эдийн засгийн харилцаан дахь үүрэг, оролцоо багасч байна. Канад, АНУ зэрэг улсуудад үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн харилцаанд дундад зууны үеийн Английн өмчийн эрх зүйн үзэл баримтлал нөлөөтэй хэвээр ч 20-р зууны дунд үеэс хөдлөх эд хөрөнгө өмчийн эрх зүйн салбарт илүү жин дарах болсон юм<sup>14</sup>. Компанийн хувьцаа, патент, компьютерын технологи гэх мэт оюуны өмчийн институтэд хамаарах өмчийн төрлүүд нь бүгд хөдлөх эд хөрөнгийн харилцаанд хэрэглэгдэж заншжээ.

<sup>10</sup> Brad Templeton A Radical Theory of Property. Para 3, verse 2

<sup>11</sup> Хууль бусаар олж авсан эд баялаг өмч гэж тооцогддоггүй тухай Ромын эрх зүйн зарчим

<sup>12</sup> 1967 оны 7 дугаар сарын 14-ний өдөр Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенцийг баталж, үүний дагуу Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулагдснаар оюуны өмчийг хамгаалах олон улсын механизм бий болсон.

<sup>13</sup> [http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/cybercrime/Documents/Convention%20and%20protocol/ETS\\_185\\_Mongolian.pdf](http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/cybercrime/Documents/Convention%20and%20protocol/ETS_185_Mongolian.pdf)

<sup>14</sup> Brad Sherman; Lionel Bently (1999). The making of modern intellectual property law: the British experience, 1760–1911. Cambridge University Press. p. 207.

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

/нүүрсний салбарын жишээн дээр/



Монгол Улсын Их Сургуулийн  
ахлах багш, хуульч  
**С.БОЛОВСОН**



Монгол Улсын Их Сургуулийн  
багш, өмгөөлөгч  
**Л.БАНЗРАГЧ**

**1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн зохицуулалтын тухай:** 2008 онд батлагдсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н тухай хуулийн 2-р зүйлд, *Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө<sup>1</sup>* гэжээ. Хуулийн энэхүү заалт нь, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн зохицуулалт өргөн хүрээг хамарсан, нэн тэргүүнд уг харилцааг зохицуулахаар тогтоогдсон хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээ, конвенц зэрэг эрх зүйн хэм

<sup>1</sup> Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль.2008.2-р зүйл.2.1, 2.2 дахь хэсгийн заалт

хэмжээний тодорхой бүрдэл болохыг нотолж байна.

Тиймээс Үндсэн хууль болон холбогдох зарим хууль, хуульчилсан актуудад тусгагдсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зохицуулалтын талаар нэн тэргүүнд өгүүлэх нь зүйн хэрэг юм.

**А. Үндсэн хуулийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх үзэл баримтлал:** Хөдөлмөрийн харилцаан дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг Монгол Улс Үндсэн хуулиар иргэний үндсэн эрхийн хүрээнд авч үзсэн байна<sup>2</sup>.

Ажил эрхлэх явдал бол хүний амьдрах эрхийн үндсэн эх сурвалж

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 . “Иргэн нь ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах..... эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй.” –гэж заасан.

бөгөөд ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийн хэрэгжилт нь хүний хөдөлмөрөөр баталгааждаг учраас ардчилсан нийгэмд хүн хөдөлмөрийн шударга, аятай нөхцөлөөр хангуулах, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд хүн бүр ямар нэг ялгаваргүй адил тэгш эрх эдлэх асуудлыг хуульчлан баталгаажуулдаг. Хөдөлмөрийн шударга аятай нөхцлөөр хангуулах эрх нь гүйцэтгэж буй ажил мэргэжлийн онцлогт тохирсон цалин хөлс авах, ижил хэмжээний амралт эдлэх, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр<sup>3</sup> хангагдах зэргээр хэрэгжих учиртай.

Ийнхүү Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах эрхэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал зүй ёсоор хамаарч байгаа бөгөөд хөдөлмөр хамгааллын хүрээнд дэх энэ эрхийг хангах нь төрийн үүрэг юм. Төрийн эрх мэдлийн байгууллагаас тасралтгүй хэрэгжүүлдэг эрх зүйн үйл ажиллагааг (хууль тогтоох, биелүүлэх, хамгаалах) төрийн үндсэн чиг үүрэг гэдэг.<sup>4</sup> Эдгээр чиг үүргийн нэг нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал мөн.

Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр тунхаглан хуульчилсан хүний эрхийг төрийн зүгээс санаатай буюу болгоомжгүй аль нэг хэлбэрээр зөрчих нь зөвхөн ганц хүний эрхэд халдаад зогсохгүй нийтийг хамарсан зөрчилд хүргэж ноцтой хохирол учруулдаг тул түүнээс урьдчилан сэргийлэх нь ардчилсан төрийн үйл ажиллагааны нэг үндсэн чиг үүрэг түүний хүмүүнлэгийн гол агуулгыг илэрхийлдэг.<sup>5</sup> Иймээс хүний эрх, эрх чөлөөний бүх талын, тухайлбал: нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгаа болгож Үндсэн хуульд иргэн

хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй гэсэн заалтыг шигтгэж өгсөн. Ийнхүү хүний эрхийг хангаж, хамгаалах нь төрийн үүрэг учраас Монгол улсын иргэний үндсэн эрх болсон хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийг хангаж хамгаалах нь төрийн үүрэг юм.

Төр, дурдагдаж буй иргэний Үндсэн хуулиар тодорхойлсон эрхийг хангаж, хамгаалахын тулд 1999 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн хэд хэдэн зүйл хэсэгт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, түүний стандартад хамаарах зохицуулалтыг тусгасан<sup>6</sup>. Үүний дараа 2008 онд “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” бие даасан хуулийг баталсан. Тэрчлэн нийгмийн бусад салбар харилцааг зохицуулсан хэд хэдэн хуулиудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд холбогдох заалтууд тусгагдаж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим зүйл заалтыг нэг бүрчлэн хэрэгжүүлэх зорилгоор хуульчилсан актуудыг ч баталж мөрдүүлсэн байдаг.

**Б. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх Олон улсын эрх зүйн хэм хэмжээ:** Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаарх Олон улсын эрх зүйн хэм хэмжээ нь, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны бодлого боловсруулахыг ажил олгогчдоос шаарддаг ба эдгээр хэм хэмжээ нь эдийн засгийн бүх салбарыг хамардаг ажээ.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүн орон бүр өөрийнхөө үндэсний нөхцөлд тохируулан эзэд, хөдөлмөрчдийн хамгийн их төлөөлөлтэй байгууллагатай зөвшилцөн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажилчдын эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн орчны эрүүл ахуйн талаар нэгдмэл бодлого боловсруулан хэрэгжүүлж

<sup>3</sup> Б.Уранцэцэг. “Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль” (онол аргазүйн тайлбар), УБ, 2001.16-р талд. “...Үндсэн хуулийн 16-р зүйлд тунхаглагдсан: “**Иргэн хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх**” бол Хөдөлмөрийн тухай хуулийн 5-р зүйлд тусгагдсан ажилтан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцөлөөр хангуулах эрхтэй агуулга дүйцэх юм гэжээ.

<sup>4</sup> Лүндэндорж Н. Төрийн онол, УБ, 2005, 196 дахь тал

<sup>5</sup> Совд Г. “Үндсэн хуулийн тайлбар” УБ., 2000 он 134 дахь тал

<sup>6</sup> Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль. 1999.6-р бүлэг “Хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт” 81-99-р зүйл.

түүнийгээ шинэчилж байх үүрэгтэй болдог.

Манай улс Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар тус улсын нэгдэн орсон буюу соёрхон баталсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг зохицуулсан олон улсын дараах хэм хэмжээг голлон хэрэгжүүлж байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны тухай" 155 дугаар конвенц, 2006 онд шинээр батлагдсан "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дэмжих хүрээ бий болгох тухай" 187 дугаар конвенц, мөн тус байгууллагын "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн системийн удирдамж" /2001 он/ гэх мэт. Эдгээр эрх зүйн хэм хэмжээний гол зорилго нь үйлдвэрлэлийн осолд өртөж гэмтэхээс урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн орчны аюулыг боломжийн хэрээр бууруулах, хөдөлмөр хамгааллын харилцаанд үндэсний эрх зүйн бодлогын чиглэлийг тогтоохын зэрэгцээ түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх үүргийг холбогдох этгээдэд ногдуулжээ.

**В. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хувьд:** 2008 онд баталж мөрдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль нь энэ харилцааг зохицуулсан гол хууль юм.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуульд тусгагдсан дараах зохицуулалтыг хуулийн гол үзэл баримтлал гэж хэлж болно.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон

төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах асуудлыг уг хуулийн зорилт болгон тодорхойлсон.

- “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал”, “Хөдөлмөрийн эрүүл ахуй”, “Хөдөлмөрийн нөхцөл”, “Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл”, “Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл”, “Ажлын байран дахь эрсдэл”, “Эрсдэлийн үнэлгээ”, “Хурц хордлого”, “Тусгай хувцас”, “Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл”, “Хамтын хамгаалах хэрэгсэл”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент”, “Хөдөлмөрийн аюулгүй нөхцөл”, “Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт” гэсэн холбогдох нэр томъёоны эрх зүйн утгыг тайлбарласан.
- Хуулийн үйлчлэх хүрээг Хөдөлмөрийн тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан ажил олгогч, ажилтан; хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн; иргэд хоорондын гэрээгээр ажиллагчид; аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагч; цэргийн сургуулийн сонсогч; хугацаат ба гэрээт цэргийн жинхэнэ албан хаагч; дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн; хоршоо, нөхөрлөлийн гишүүд; ял эдэлж байгаа хоригдол; Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад ажилладаг Монгол Улсын иргэн, гадаадын болон харьяалалгүй иргэн байхаар өргөн хүрээг хамруулан нэг бүрчлэн заасан.

**Г. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг зохицуулсан бусад хуулийн тухайд:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцаанд хамаарал бүхий заалтыг өөртөө агуулсан олон хуулийг нэрлэн тоочиж болох ч нилээдгүй өргөн зохицуулалт бүхий дараах хуулиудын зарим агуулгын талаар авч үзье.

**Хөдөлмөрийн тухай хууль:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн эрүүл ахуйтай холбогдсон харилцааг 2008 он хүртэл үндсэндээ хөдөлмөрийн тухай хуулиар бүхэлд нь зохицуулж байсан. Харин Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай шинэ хууль батлагдаж улмаар хөдөлмөрийн хуулийн 6-р бүлгийн зарим зүйл хүчингүй болсон<sup>7</sup> хэдий ч хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн харилцаанаас уламжлан үүссэн зарим үр дагаврыг зохицуулсан хэд хэдэн зохицуулалт өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Тухайлбал, “Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйл нь, үйлдвэрлэлийн осолд орсон, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтанд өөрт нь болон эдгээр гурван шалтгааны улмаас нас барсан ажилтаны ар гэрт нөхөх төлбөрийг ажил олгогч хэрхэн ямар хэмжээгээр олгох тухай заалт юм.”<sup>8</sup> Хуулийн энэхүү заалттай холбогдуулан “Үйлдвэрлэлийн осол”, “Хурц хордлого”, “Мэргэжлээс шалтгаалах өвчин” гэдгийг хэрхэн ойлгож хэрэглэх асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл заалтыг тайлбарласан УДШ-ийн 2006 оны 33-р тогтоолд тодорхой заасан. Эл утгаараа Хөдөлмөрийн тухай хууль нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааны зарим үр дагаврыг зохицуулж, уг харилцаанд зохих чиг үүргийг гүйцэтгэж байна.

**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж,**

<sup>7</sup> Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль 1999.

<sup>8</sup> Төрийн мэдээлэл.1999.№ “Хөдөлмөрийн тухай хууль” 97 дугаар зүйл. “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлыг нөхөн төлөх”

**төлбөрийн тухай хууль;** Хөдөлмөрийн тухай хуулиар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого мэргэжлээс шалтгаалах өвчнөөс үүдэлтэй, ажилтаны хөдөлмөрийн чадвар алдалтын хохирлыг ажил олгогч нөхөх төлбөрийн харилцааг зохицуулсан бол энэ хуулиар үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилж тахир дутуу<sup>9</sup> болсон даатгуулагчид олгох тэтгэвэр<sup>10</sup>, тэтгэмж, төлбөрийн харилцаа, тэдний нийгмийн даатгалын шимтгэлийг хэрхэн төлөх асуудал, даатгуулагчийн өвчин эмгэг нь хүндрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор сувиллын газарт сувилах арга хэмжээний зардал түүний хэмжээ зэргийг зохицуулсан байна.<sup>11</sup>

**Эрүүгийн хууль:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал нь хүний амь нас, эрүүл мэндтэй шууд холбоотой тул хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангаагүйгээс хүний бие махбодод хүндэвтэр болон хүнд гэмтэл учирсан мөн түүнчлэн хүний амь нас хохирсон тохиолдолд түүнийг гэмт хэрэг гэж үзэж, Эрүүгийн хуульд “Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам зөрчих гэмт хэрэг”, “Аюулгүй ажиллагааны журам зөрчих гэмт хэрэг” хэмээн тус тус хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн 138 дугаар зүйл 138.1-д “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа сахин хангуулах үүрэг бүхий этгээд энэ үүргээ биелүүлээгүйгээс хүний бие махбодод хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.” Мөн хуулийн 138.2-т “Энэ

<sup>9</sup> Тахир дутуу хүн гэдэг ойлголтыг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэдэг нэр томъёогоор хэрэглэх болсон хэдий ч нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан багц хуульд “тахир дутуу” гэсэн нэршлээр хэрэглэгдсээр байна.

<sup>10</sup> Нийгмийн даатгалын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр гэсэн хоёр төрлийн тэтгэвэр олгогдож байна.

<sup>11</sup> “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хууль 1994он. 4-р зүйл.



хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусдад хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”-гэж заасан байна. Мөн хуулийн (183 дугаар зүйл)<sup>12</sup> “Аюулгүй ажиллагааны журам зөрчих гэмт хэрэг” –гэж үзэж түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын хэр хэмжээг хуульчилсан байна. Эрүүгийн хуулийн 138, 183 дугаар зүйлээр Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт **“Иргэн нь ... хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах эрхтэй.”** гэж заасан эрхийг ийнхүү хамгаалсан.

Улмаар “...аюулгүй ажиллагааны журам зөрчсөн...” гэдэгт юуг хамааруулан ойлгохыг Улсын Дээд Шүүхээс “Уулын болон уурхайн, барилгын, түүнчлэн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тэсэрч дэлбэрэх аюултай үйл ажиллагааг гүйцэтгэх явцад заавал дагаж мөрдвөл зохих хууль тогтоомжийг огт хэрэгжүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүйг хэлнэ.”<sup>13</sup> гэж тайлбарласан байна.

**Захиргааны хариуцлагын тухай хууль:** 1994 онд батлагдсан энэ хуульд эрүүгийн хуульд заасан хор уршиг учраагүй тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгагдсан байна. Тухайлбал: Захиргааны хариуцлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-г ... *олборлолт явуулах, зуух, даралтат сав, өргөх, тээвэрлэх механизмыг ашиглах; уул уурхай, барилга болон тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх явцад*

<sup>12</sup> Эрүүгийн хуулийн 183 дугаар зүйлд “Уул, уурхай, барилга, түүнчлэн тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй үйлдвэр бусад аж ахуйн нэгж, байгууллагад аюулгүй ажиллагааны журам зөрчсөний улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан.

<sup>13</sup> УДШ-ийн 2010 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 14-р тогтоол.

*техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, 47.2-т “Тэсэрч дэлбэрэх болон радио идэвхит, түүнчлэн хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх, борлуулах, олж авах, бэлтгэх журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил гаргасан иргэнд* захиргааны хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Мөн хуулийн 47<sup>1</sup>-р зүйлд “Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа эрхлэх аж ахуйд хөдөлмөр хамгааллын журмыг сахин хангуулах эрх бүхий этгээд энэ үүргээ биелүүлээгүй буюу хөдөлмөр хамгааллын журам зөрчигдөж буйг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ аваагүй үйлдэлд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, захиргааны хариуцлага хүлээлгэхээр заажээ.

**Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 12 дугаар зүйлд, Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодистой харьцахад тавих ерөнхий шаардлагыг зохицуулсан заалт тусгагдсанаас гадна Химийн хорт ба аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодис хэрэглэх, харьцах аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд тавигдах бусад шаардлагыг холбогдох хуулиар зохицуулна”<sup>14</sup> хэмээсэн нь энэхүү холбогдох хууль гэдэгт;

1. 2006 онд батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”<sup>15</sup>
2. 2004 онд баталж, 2013 онд шинэчилэн найруулсан “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд

<sup>14</sup> Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. 2008.12-р зүйл.12.4 дэх хэсэг.

<sup>15</sup> Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль. 2006, 10-р зүйл. Химийн хорт болон аюултай бодис хадгалахад тавих үндсэн шаардлага, 12-р зүйл. Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэхэд тавих үндсэн шаардлага, 13-р зүйл. Химийн хорт болон аюултай бодис ашиглахад тавих үндсэн шаардлага.

хяналт тавих тухай” тусгайлсан хуулиудыг нэрлэж болохоор байна.

Энэ хуулиар үйлдвэрлэлийн зориулалттай тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих, тэдгээрийн хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааг хангах, хууль бус хэрэглээг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

**Галын аюулгүй байдлын тухай хууль;** Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 13 дугаар зүйлд, Галын аюулгүй байдалд тавих шаардлагын талаар тусгагдсан. Уг хуулийн 13-р зүйлийн 13.3-д, галын аюулгүй байдлыг хангах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг “Галын аюулгүй байдлын тухай” хуулиар зохицуулна хэмээн заасан нь, 1999 онд батлагдсан Галын аюулгүй байдлын тухай хууль аливаа аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцаанд мөрдөх эрх зүйн хэм хэмжээний акт болох нь илэрхий байна.

**Д. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хуульчилсан актууд:** Улсын их хурал, Засгийн газар, бусад төрийн эрх бүхий байгууллагаас эрх хэмжээнийхээ хүрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим зүйл заалтыг нэг бүр ханган хэрэгжүүлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тодорхой асуудлыг зохицуулсан дараах дүрэм, журам, заавар, зөвлөмж, хөтөлбөр стандартыг баталсан нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

**Улсын Их Хурлын тогтоол:** Монгол Улсын Их Хурлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн биелэлтийг хангах, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбогдуулан 2013 онд багтаан авч хэрэгжүүлэх арга хэмжээ болгон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” нэртэй 13 заалт бүхий 20-р тогтоолыг 2013 оны 02-р сарын 07-ны өдөр баталж мөрдүүлсэн нь хөдөлмөрийн

аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 20-р зүйлд заасан Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудал юм.

**Засгийн газрын тогтоолоор батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд холбогдох доорх дүрэм, хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:**

1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм /Засгийн газрын 2009 оны 14-р тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан/
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний дөрөв дэх хөтөлбөр /Засгийн газрын 2012 оны 122-р тогтоолоор батлагдсан /
3. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 3,0 хувиар төлөх ажил олгогчийн жагсаалт, /Засгийн газрын 2008 оны 142-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан./
4. Эмнэлэг Хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм /Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан/

**Бусад төрийн эрх бүхий байгууллагаас баталсан нүүрсний салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд холбогдох дараах хуульчилсан актууд байна:**

1. “Бичил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” /Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 153-р тушаалын 5-р хавсралтаар батлагдсан./
2. “Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт 2013-2014 оны улсын хэлэлцээр”
3. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт үндэсний хорооны дүрэм” /Хөдөлмөр нийгмийн зөвлөлийн гурван талт үндэсний хорооны 2012 оны 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан/

4. “Бичил уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хорооны бүрэлдэхүүн, ажлын чиглэл” /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн гурван талт үндэсний хорооны 2013 оны 02 тоот тогтоолын 1, 2-р хавсралтаар батлагдсан./

**Е.Стандартууд:** Хөдөлмөрийн яам 2012 онд Монгол улсад мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой 129 стандартад улсын үзлэг хийсэн байна.<sup>16</sup> Эдгээр стандартын 103 нь нүүрсний салбарт олборлолт, тээвэрлэлт, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн мөрдвөл зохих хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйд хамаарах стандарт байна.

## 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний төлөв байдал

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчин зохих хэмжээнд төлөвшиж, ажилтны ая тухтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж байгаа хэдий ч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин төдийлөн буурахгүй ялангуяа уул уурхайн салбарт гарч байгаа осол, ослын улмаас амь насаа алдах явдал их байна. Тухайлбал, уул уурхайн салбарт 2008 онд 95, 2009 онд 77, 2010 онд 85, 2011 онд 76, 2012 онд 75<sup>17</sup> осол гарснаас хүний амь нас эрсэдсэн тохиолдол нийт ослын 21.2-44.2 хувь буюу дунджаар 33 орчим хувийг эзэлж байна. Ослыг шалтгаанаар нь авч үзвэл, уналт ба нуралтын улмаас гарсан осол 18.6% буюу дундажаар 26.1%, аюулгүй ажиллах

арга барилд хангалтгүй суралцсанаас үүдэн гарсан осол 22.0-41.3% буюу дунджаар 31.6% байгаа нь бусад шалтгаанаар үүссэн ослоос давамгайлж байна

Нүүрсний салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх ямар хэрэгцээ шаардлага эрх зүйн орчин байгааг судлах зорилгоор Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн судалгааны институтын захиалгаар “Нүүрсний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөв байдал”-ын судалгааны ажлыг 2013 оны 09-11 сард “Хөгжил дэвшлийн хөтөч” төрийн бус байгууллагын судалгааны баг гүйцэтгэсэн.<sup>18</sup> Уг судалгааны зорилго нь Монгол Улсын нүүрсний салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын төлөөллийг хамруулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох стандарт, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн түвшин, ерөнхий төлөв байдлыг тодорхойлоход оршиж байв.

Судалгааны хүрээнд төрийн болоод хувийн, хамтарсан хөрөнгө оруулалттай 7 томоохон компани, орон нутгийн 10 уурхай, бичил уурхайн төлөөлөл болгож 3 нөхөрлөлийг сонгон авч судалгаанд хамруулсаны зэрэгцээ 430 гаруй ажиллагчдаас асуулга, салбарын 10 гаруй экспертээс ярилцлага авч, улмаар хоёр удаа фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах замаар тоон болон чанарын мэдээлэл цуглуулж боловсруулалт хийсэн.

Судалгааны дүнгээс харахад, компанийн менежмент буюу өмчийн хэлбэр, хүчин чадал, санхүүгийн чадавхаас шууд хамааралтайгаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журам, стандартуудын хэрэгжилтийн түвшин харилцан адилгүй байв. Тухайлбал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, ажилтантай байх, ажлын байрны

<sup>16</sup> Хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо, Швейцарын хөгжлийн агентлаг. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн холбогдолтой хууль, тогтоол, журмын эмхэтгэл. УБ.2013.243-273-р тал. Хөдөлмөрийн яамнаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлчилгээний үндэсний стандартад хийсэн улсын үзлэгийн тайлан.

<sup>17</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газар., Үйлдвэрлэлийн осол, хөдөлмөр хамгаалал, мэргэжлээс шалтгаалал өвчний статистик мэдээлэл. 2012 он.

<sup>18</sup> Зохиогчид нь энэхүү судалгааны багт ажилласан тул зарим холбогдох тоон мэдээллүүдийг шууд хуулбарлан тавьсан болно.



эрсдлийн үнэлгээ хийлгэж, аюулыг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авах, сургалтын төлөвлөгөө хөтөлбөртэй байх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэсэн байх, байгууллагын дээд удирдлага Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлогоо тодорхойлж, баталж, хэрэгжүүлсэн байдал зэрэг асуудал хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай компаниудад дундаас дээш түвшний

хэрэгжилттэй байхад, төрийн өмчит хуулийн этгээдэд дунд зэрэг, харин ихэнх орон нутагдах нүүрсний уурхай болон бичил уурхайд хэрэгжилт хангалтгүй байлаа.<sup>1</sup>

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд тусгагдсан дээр дурьдагдсан зарим заалт хэрхэн хэрэгжиж байгааг судалгааны дараах хүснэгтэн өгөгдлүүдээс харж болно.

Хүснэгт №1. ХАБЭА-н зөвлөлтэй эсэх

Төрийн өмчит томоохон компаниуд Хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниуд			Компанийн хэлбэр			Нийт
			Орон нутгийн компаниуд			
ХАБЭА-н зөвлөлтэй эсэх	Үгүй	Давтамж	0	1	9	10
		Хувь	0.0	25.0	90.0	58.8
	Тийм	Давтамж	3	3	1	7
		Хувь	100.0	75.0	10.0	41.2
Нийт		Давтамж	3	4	10	17
Хувь		100.0	100.0	100.0	100.0	

Бичил уурхайгаас бусад, судалгаанд хамрагдсан нүүрсний компанийн 41 хувь нь л хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн

орон тооны бус зөвлөл байгуулан ажиллаж байв. Ялангуяа орон нутгийн компаниудын хувьд хуулийн энэ зүйл заалт хэрэгжээгүй байна.

Хүснэгт №2 ХАБЭА-н зөвлөл ажиллуулах журамтай эсэх

Төрийн өмчит томоохон компаниуд Хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниуд			Компанийн хэлбэр			Нийт
			Орон нутгийн компаниуд			
ХАБЭА-н зөвлөл ажиллуулах журам баталсан эсэх	Үгүй	Давтамж	1	0	10	13
		Хувь	33.3	0.0	100.0	68.4
	Тийм	Давтамж	2	4	0	6
		Хувь	66.7	100.0	0.0	31.6
Нийт		Давтамж	3	4	10	19
Хувь		100.0	100.0	100.0	100.0	

Төрийн өмчит компанийн 33 хувь нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөө томилсон шийдвэр гаргасан хэдий ч, тухайн зөвлөл хэрхэн ажиллах тухай журам боловсруулж мөрдөөгүй байна. Харин хувийн, хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниудын зарим нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл ажиллуулах журмаа баталсан ч зөвлөлөө байгуулж ажиллуулаагүй ба судалгаанд хамрагдсан орон нутгийн компаниуд бүгд

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл ажиллуулах журамгүй байлаа. Тэрчлэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулсан компаниудын хувьд зөвлөлийн гишүүдээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамруулдаггүй зэргээсээ хамаарч зөвлөлийн ажил нь үр нөлөөтэй байж чаддаггүй байдал ажиглагдсан.

<sup>1</sup> Хөдөлмөрийн судалгааны институт, "Хөгжил дэвшлийн хөтөч" ТББ Нүүрсний салбарын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөв байдлын судалгааны тайлан. УБ.2013

## Хүснэгт №3 ХАБЭА-н эрсдлийн үнэлгээ хийдэг эсэх

Төрийн өмчит томоохон компаниуд Хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниуд			Компанийн хэлбэр				Нийт
			Орон нутгийн компаниуд	Бичил уурхай			
Эрсдлийн үнэлгээ хийдэг эсэх	Үгүй	Давтамж	2	0	8	2	12
		Хувь	66.7	0.0	80.0	100.0	63.2
	Тийм	Давтамж	1	4	2	0	7
		Хувь	33.3	100.0	20.0	0.0	36.8
Нийт		Давтамж	3	4	10	2	19
Хувь		100.0	100.0	100.0	100.0		

## Хүснэгт №3 ХАБЭА-н эрсдлийн үнэлгээ хийдэг эсэх

Төрийн өмчит томоохон компаниуд Хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниуд			Компанийн хэлбэр				Нийт
			Орон нутгийн компаниуд	Бичил уурхай			
Эрсдлийн үнэлгээ хийдэг эсэх	Үгүй	Давтамж	2	0	8	2	12
		Хувь	66.7	0.0	80.0	100.0	63.2
	Тийм	Давтамж	1	4	2	0	7
		Хувь	33.3	100.0	20.0	0.0	36.8
Нийт		Давтамж	3	4	10	2	19
Хувь		100.0	100.0	100.0	100.0		

Хамтарсан хөрөнгө оруулалттай компаниуд эрсдэлийн үнэлгээг үр нөлөөтэй хийж хэрэгжүүлж чадаж байгаа бол төрийн өмчит томоохон компаниудад энэ ажил орон нутгийн компаниудаас ялгагдах зүйлгүй доогуур түвшинд байсан.

Судалгаанд хамрагдсан нүүрсний компаниудын 37 хувь нь буюу 7 компани ямар нэгэн байдлаар эрсдлийн үнэлгээг хийж байгаа бол 63 хувь буюу үнэмлэхүй олонхи нь эрсдэлийн үнэлгээ хийдэггүй гэсэн дүн гарсан.

## Бүдүүвч №1. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гаргадаг эсэх



Төр хэдийгээр иргэний хөдөлмөрлөх үйл ажиллагаатай холбогдсон эрхийг хамгаалах, хангах үүрэгтэй ч энэхүү үүрэг зорилт хэрхэн хангагдах нь ажил олгогч хуулийн этгээд ажилтаныхаа гүйцэтгэх ажил үүргийн онцлогт тохируулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөв дадлыг эзэмшүүлэх, нөгөөтэйгүүр ажилтан өөрөө хөдөлмөрийн аюулгүй байдлаа хангах эрх зүйн тодорхой мэдлэгтэй байх, хуульд заасан эрх, үүргээ танин мэдэхээс эхлэлтэй юм.

Гэтэл ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн мэдлэг тийм ч хангалттай бус байгаа нь судалгаанд оролцогчдын асуулгын анкетын **Та хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн өөрийн ажил үүрэгт холбогдох заалтыг мэдэх үү? Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх өөрийн мэдлэгээ үнэлнэ үү? гэсэн асуулгын үр дүнгээс харагдаж байна**

Хүснэгт 4. Та хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн өөрийн ажил үүрэгт холбогдох заалтыг мэдэх үү?

Төрийн өмчит томоохон компаниудын ажиллагсад	Уурхайн хэлбэр			Бичил уурхайн ажиллагсад	Дүн
	Хувийн хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниудын ажиллагсад	Орон нутгийн компаниудын ажиллагсад			
Сайн	53.8%	49.1%	43.0%	33.3%	49.5%
Дунд	34.6%	39.1%	41.9%	22.2%	37.4%
Муу	6.0%	3.1%	3.5%	22.2%	4.8%
Мэдэхгүй	4.9%	8.7%	11.6%	22.2%	8.0%
Хариулаагүй	.5%				.2%
100.0%	100.0%		100.0%	100.0%	100.0%

Дээрх асуулгад нийт оролцогчдын 51,5% нь дунд, муу, мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон байна.

Хүснэгт 5. ХАБЭА-н талаарх өөрийн мэдлэгээ үнэлнэ үү?

	Уурхайн хэлбэр	Total				
	Төрийн өмчит томоохон компаниудын ажиллагсад	хамтарсан хөрөнгө оруулалттай томоохон компаниудын ажиллагсад	Орон нутгийн компаниудын ажиллагсад	Бичил уурхайн ажиллагсад		
Та хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх өөрийн мэдлэгээ үнэлнэ үү?	Сайн	52.2%	49.7%	43.0%	55.6%	49.5%
	Дунд	43.4%	47.8%	51.2%	22.2%	46.1%
	Муу	4.4%	1.2%	5.8%	22.2%	3.9%
	Хариулаагүй		1.2%			.5%
		100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

### 3. Дүгнэлт

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээний олон актууд үйлчилж байгаа нь нүүрсний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэх боломжтой юм. Гэсэн хэдий ч эдгээр хэм хэмжээний актын зохицуулалтад дараах

зөрчилтэй асуудлууд байсаар байна. Үүнд:

1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль” болон хамаарал бүхий зарим хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, 1997 онд батлагдсан “**Статистикийн тухай хууль**”-ийг нэрлэж болох юм. Энэ хуулийн 2-р бүлэгт статистикийн

мэдээллийн тогтолцооны асуудлыг зохицуулсан ба уг бүлгийн 6-р зүйлд албан ёсны статистикийн мэдээлэл, түүнийг гаргах үндэслэлийг заасан. Мөн хуулийн 6 зүйлийн 6.2 дахь хэсэгт “Хүн ам, нийгмийн статистикт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг хамруулжээ. Гэтэл Үндэсний статистикийн хорооны албан ёсны мэдээлэлд одоог хүртэл үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөгсдийн талаар тоон мэдээллүүд тусгагдаагүй байна.

2. Зарим хууль, стандартад тусгагдсан ХАБЭА-н нэр томъёо өөр өөр байгаа нь үйлчилж буй хуулийн хэм хэмжээтэй зөрчилдөх, түүний агуулгад үл нийцэх байдлыг бий болгож байна. Тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн хуульд “аюулгүй ажиллагааны журам зөрчих, хөдөлмөр хамгааллын журам зөрчих, **хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа,**” гэсэн нэршил хэрэглэсэн байхад, мөн нилээдгүй стандартад Хөдөлмөрийн эрүүл ахуй гэсэн

нэр томъёог хөдөлмөрийн эрүүл мэнд, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн эрүүл ахуй гэх нэрээр, харин хөдөлмөрийн аюулгүй байдлыг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал гэж олон янзаар авч үзсэн нь холбогдох нэр томъёог нэг бүр болгох шаардлага байгааг харуулж буй явдал юм.

3. Ихэнх нүүрсний уурхай дэлхийн зах зээлд танигдсан өндөр хүчин чадал багтаамж бүхий, овор хэмжээ том уул уурхайн машин техник, багаж, тоног төхөөрөмжөөр ажил үүргээ гүйцэтгэх болсон нь нүүрсний салбарын техник, тоног төрөөрөмжийн технологийн аюулгүй ажиллагааг зохицуулж буй 2003 оны “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”, 1987 оны “Нүүрсний далд уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм” г.м хуульчилсан актын заалтыг шууд хэрэглэх боломжгүй нөхцөл байдлыг бий болгож байна. Иймээс түүний агуулгад өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулалт хийх цаг нь нэгэнт болжээ.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УУЛ УУРХАЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛД ЗАРДАЛ ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ



Судлаач, докторант

**Ц.ОДГЭРЭЛ**

### Хураангуй

Сүүлийн 10 гаруй жилд манай оронд уул уурхайн үйлдвэрлэл хурдацтай хөгжиж энэхүү салбарын өсөлт улс эх орны эдийн засагт үр ашиг авчрахын зэрэгцээ байгаль орчин, нийгэмд олон эерэг, сөрөг нөлөө үзүүлж байна. Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөлөл нь эерэг нөлөөллөөс давж байгаа өнөө үед уул уурхайн салбарын болон нэгж уурхайн байгаль орчин, нийгэм-эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн эдийн засгийн бодит үнэ цэнийг тогтоох, холбогдох арга зүй, загварыг боловсруулах зайлшгүй шаардлага тулгарч байна. “Уул уурхайн салбарын нийгмийн зардал үр ашгийн шинжилгээ” өгүүллээрээ “нийгмийн” гэх зэрэг гадаад хүчин зүйлс нь бодит мөнгөн зардал эсвэл мөнгөн дүнгээр орлого болж харагдахгүй байгаа хэдий ч хүмүүст эерэг болон сөрөг байдлаар хуримтлагдан нөлөөлсөөр байдаг

‘нийгмийн’ хүчин зүйлсийг зардал үр ашгийн шинжилгээгээр тооцов. Эдгээр нийгмийн гадаад хүчин зүйлс нь дээр дурьдсанаар тодорхой нэг зах зээлийн гүйлгээгээр хязгаарлагддаггүй. Жишээ нь уурхайн ажилчид, уул уурхайн ойр орчим амьдарч буй нутгийн иргэдийн эрүүл мэнд уурхайн үйл ажиллагааны улмаас чухам хэдэн төгрөгийн хохирол амсаж байгааг бид зах зээлийн үнэлгээнээс олж харахгүй. Тиймээс нийгмийн дам нөлөөлөл, байгаль орчны дам нөлөөллийн мөнгөн дүнг тодорхойлохын тулд зах зээлийн үнэлгээг ашиглахаас илүү дам зардлыг тооцох арга аргачлалыг ашиглан зах зээлийн үнийг төлөөлүүлэн тооцох замаар үр ашгийг тодорхойлдог. Х, Ү 2 уурхайн түвшинд уул уурхайн салбарын нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тооцон мөнгөн дүнгээр таамагласан зардал үр ашгийн дүн шинжилгээг танилцуулж байна.

**Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нийгэмд үзүүлж буй нөлөөлөлд зардал, үр ашгийн шинжилгээ хийх нь**

Уул уурхайн үйлдвэрлэл нь Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болон хөгжиж, нийт экспортын 90 орчим хувь, ДНБ-ний 20 хувийг эзэлж, уул уурхайн бүтээгдэхүүний орлого, үр өгөөж тогтмол өсч, улсын төсөвт 2010 онд уул 873.6 тэрбум төгрөг, 2011 онд 1015.9 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Хэдийгээр Монгол Улсын эдийн засаг уул уурхайгаас хамаарч байгаа ч бодлого боловсруулагч нар, олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар эрдэс баялгийн үйлдвэрлэл 2009 оноос байнга бууралттай явж ирсэн бөгөөд 2012 онд ДНБ-ны 15.9 хувь болсон, 2013 оны байдлаар уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 32 хувиар буурсан, нүүрсний үнэ унасан, нүүрсний өнөөгийн байдлаар эдийн засагт нь уул уурхайн салбарын нөлөөлөл ихтэй орнуудад экспортын орлого буурч, валютын ханш өсөх хандлага ажиглагдаж байгаатай холбон тайлбарлаж байна.

Харин уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн Монгол Улсын байгаль орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөлөлд зардал үр ашгийн шинжилгээ хийж, үнэлсний дараа улс орны эдийн засагт хэр зэрэг үр өгөөжөө өгч байгааг тооцох ёстой. Харамсалтай нь уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр байгаль орчин, нийгэм, хүнд мөнгөн дүнгээр илэрхийлбэл хэр хэмжээний хор хохирол үзүүлж байгааг үнэлсэн, мөнгөжүүлж тооцсон судалгааг уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж эхэлснээс хойш өнөө

хүртэл огт хийгээгүй байна. Эдүгээг хүртэл уул уурхай, эрдэс баялгийн үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжлийн жилүүдэд уул уурхайн үйлдвэрлэлийн бүсэд нутаглаж буй малчдын эдийн засаг болон амьжиргаа, бэлчээр, байгалийн нөөцөд тулгуулан мал аж ахуйгаа өсгөж үржүүлж үр шимийг нь хүртэж амьдардаг малчдын уламжлалт амьдралын хэв маяг, амьдралын чанар, бэлчээрийн мал аж ахуй оршин тогтнох үндэс болсон ус, бэлчээр гэх мэт байгалийн нөөц, уул уурхайн үйлдвэрлэлийн бүс дэх нутгийн иргэдийн эрүүл мэндэд уурхайн үйл ажиллагааны улмаас хэдэн төгрөгний хохирол учирч байгаа, ирээдүйд хэр зэрэг хохирол амсахуйц хэмжээний сөрөг нөлөөллийн хуримтлал бий болж байгааг зардал үр ашгийн дүн шинжилгээний аргыг хэрэглэн мөнгөжүүлэн тооцоогүй л байна. Зүй нь уул уурхайн салбарын нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, хор хохирлыг мөнгөжүүлж тооцсон тохиолдолд уул уурхайн салбар нь улс оронд үр ашигтай эсвэл үр ашиггүйг хэлж чадах юм.

Олон улсын түвшинд зардал үр ашгийн шинжилгээний аргыг ашиглан уул уурхайн үйлдвэрлэлийн нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөлөл, хор хохирлыг мөнгөжүүлэн тооцохдоо:

- Уул уурхайн үйлдвэрлэлийн дотоод зардалд шингэдэг нийгмийн үр ашгийг зах зээлийн бодит үнээр мөнгөжүүлэн тооцох,
- Нэг талаас нутгийн уугуул<sup>1</sup> иргэдийн

<sup>1</sup> Хуулинд тусгалаа олсон, хуулиар баталгаажсан уугуул иргэдийн газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбоотой ойлголт. Энэ эрх нь уугуул хүмүүсийн газар нутаг нь тэдний шашин, соёл уламжлал, сайн сайхан амьдралынх нь үндэс суурь болж байдагтай салшгүй холбоотой (Paul Burke (2002))



санал болгосон үнэ, нөгөө талаас уул уурхайн компани, иргэдийн харилцан зөвшилцсөн үнээр нийгэмд учруулж буй сөрөг нөлөө, хор хохирлыг тооцох (Австрали улсын туршлага) аргачлалыг ашиглаж байна.

Нийгмийн зардал үр ашгийн шинжилгээнд уул уурхайн үйлдвэрлэлийн нийгэмд үзүүлж буй нөлөөллийг мөнгөжүүлэхдээ зах зээлийн үнэ цэнэ болон Австрали улсын сайн туршлагад үндэслэн тооцов. Нийгмийн зардал үр ашгийн шинжилгээг Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй Х нүүрсний уурхай, Y алтны уурхайн жишээн дээр хийсэн ба тооцоололд шаардлагатай мэдээллийн эх үүсвэрийг социологийн судалгааны асуулга, ярилцлага, хоёрдогч эх үүсвэрийн баримт бичгийн шинжилгээний аргуудыг ашиглан цуглуулсан болно.

Нийгмийн зардал, үр ашгийн шинжилгээний загварт уул уурхайн үйл ажиллагаа ба гэр бүл салалт, архидалт, биеэ үнэлэлт зэрэг нийгмийн асуудлуудыг нийгмийн зардал үр ашгийн загварт оруулж мөнгөжүүлэн тооцоолоогүй бөгөөд энэ нь нийгэмд гарч буй нийгмийн асуудлуудад уул уурхайн үйл ажиллагаанаас гадна өөр бусад хүчин зүйлс нөлөөлж байдгаар тайлбарлагдана. Жишээ нь гэр бүл салалтад уул уурхайгаас гадна олон хүчин зүйл нөлөөлж байдаг тул гэр бүл салалтын бодит нийгмийн зардлыг нь нэг бүрчлэн тогтоох боломжгүй байлаа.

Энэхүү загварт ашиглагдсан нийгмийн зардал, үр ашгийн тооцоо нь нийгмийн ашиг ба нийгмийн зардал гэсэн хэсгээс бүрдэнэ.

**Нийгмийн зардал** нь улс оронд учирч буй

нийгмийн бүх зардал. Хоёр уурхайн жишээн дээр тооцсон нийгмийн зардлын загварт соёл уламжлалын хохирлын зардал, үйлдвэрийн осол, гэмтэлд өртсөн ажилтны аж амьдралын болон нийгмийн халамжийн зардлыг \нөхөн олговор, тэтгэвэр тэтгэмж\ ойлгоно. Өөрөөр хэлбэл уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах нийгмийн сөрөг нөлөөллийг илэрхийлэн харуулсан зардал. Жишээ нь Монгол Улсын хувьд соёл уламжлалын хохирол нь уул уурхайн нөлөөгөөр нутгийн иргэд, малчид 4 улирлын онцлогтойгоор бэлчээрийн мал аж ахуй эрхлэх газар нутаггүй болох, бэлчээрийн газраа ашиглан мал аж ахуйгаа өсгөж үржүүлэх, үр шимээр нь амьжиргаагаа үргэлжлүүлж хангаж чадахгүйд хүрэх, үе уламжлан амьдарч ирсэн газар нутгаасаа дайжих, түүх соёлын үнэт өв, олдворууд үрэгдэх, байгалийн нөөц хомсдох, суурин амьдралын хэв маягтай болох зэргээр өөрчлөлт гарч байгаа ба энэ нь соёл уламжлалын алдагдлыг илэрхийлсэн үзүүлэлт юм. Австрали улсын туршлагаар соёл уламжлалын алдагдалд дээр дурьдсан асуудлыг нийгмийн хор хохирол гэж үзэн мөнгөжүүлэн тооцож нийгмийн зардлаар илэрхийлдэг.

**Нийгмийн үр ашиг** нь улс орны нийгмийн нийт үр ашиг. Хоёр уурхайн жишээн дээр тооцсон нийгмийн үр ашгийн загварт нийгмийн татвар, нийгмийн хөтөлбөр ба хандив, дотоод сургалтын хөтөлбөрүүдийг багтаан ойлгоно.

Дараах хүснэгтэд нийгмийн зардал үр ашгийн шинжилгээнд ашигласан нийгмийн зардлын болон нийгмийн үр ашгийн жагсаалтыг харуулж байна.

*Хүснэгт 1. Уул уурхайн салбарын нийгэмд үзүүлж буй нөлөөллийн зардал, үр ашгийг тооцоход ашиглагдах үзүүлэлтүүд*

Үзүүлэлтүүд	Үзүүлэлтүүдийн задаргаа	Тооцох аргачлал	Мэдээллийн эх үүсвэр
<b><i>Нэг. Нийгмийн зардал</i></b>			
<b>1.1 Үйлдвэрлэлийн осол, гэмтэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэлийн осол гэмтлийн тоо</li> <li>- Үйлдвэрлэлийн осол гэмтэлд өртсөн хүний тоо</li> <li>- Нас барсан хүний тоо</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болсон хүний тоо</li> <li>- Хөдөлмөрийн чадвараа түр алдсан хүний тоо</li> <li>- Өөр ажилд шилжсэн хүний тоо</li> </ul>	- Бүртгэл, мэдээллийн сан	<ul style="list-style-type: none"> <li>- Статистик мэдээлэл</li> <li>- Уурхайн уулын ажлын тайлан</li> </ul>
<b>1.2 Нөхөн олговор</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэнд олгох тэтгэвэр</li> <li>- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр</li> <li>- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж</li> <li>- Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр</li> <li>- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл</li> <li>- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийг сувилах үйлчилгээний хувьсах зардал</li> </ul>	- Хуульд заасан үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- НДС-гаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хууль</li> <li>- Уулын ажлын тайлан</li> </ul>
<b>1.3 Соёл уламжлалын алдагдал</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Малчид, нутгийн иргэдийн газар ашиглах, эзэмших, өмчлөх</li> <li>- Газар нутаг болон орон нутаг өөрчлөгдөж буй нөхцөл байдал</li> <li>- Малчид, нутгийн иргэдийн амьдралын хэв маяг, эрхлэх аж ахуй, уламжлалт мэдлэг, туршлагад гарч буй өөрчлөлт</li> <li>- 4 улирлаар бэлчээрийн газраа ашиглан МАА-гаа өсгөж үржүүлэх боломж нөхцөл</li> </ul>	-	<ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын сайн туршлага \Австрали, Канад улс\</li> </ul>
<b><i>Хоёр. Нийгмийн үр ашиг</i></b>			
<b>2.1 Улсын төсөвт төвлөрүүлж буй нийгмийн татвар</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Нийгмийн даатгалын шимтгэл</li> <li>- Эрүүл мэндийн даатгалын шимтгэл</li> </ul>	- Улсын төсөвт төвлөрч буй бодит орлого	<ul style="list-style-type: none"> <li>- Статистик мэдээлэл</li> <li>- Уулын ажлын тайлан</li> </ul>
<b>2.2 Хандив</b>	- Хандивын задаргааны мэдээлэл байхгүй	- Улсын төсөвт төвлөрч буй бодит орлого	- Статистик мэдээлэл

<b>2.3 Нийгмийн хөтөлбөр</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол</li> <li>- Эрүүл мэнд</li> <li>- Дэд бүтэц, зам харилцаа</li> <li>- Жижиг дунд үйлдвэрлэл, ажлын байр бий болгох үйл ажиллагаа</li> <li>- Санхүүгийн дэмжлэг</li> <li>- Хандив</li> <li>- Соёл урлагийн арга хэмжээ</li> <li>- Баяр ёслол, тэмдэглэлт ойн үйл ажиллагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл ажиллагааны бодит зардал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Уулын ажлын тайлан</li> <li>- Судалгаа</li> </ul>
<b>2.4 Нийгмийн дэд бүтэц</b>	-	-	-

### Үйлдвэрлэлийн осол

<b>Үйлдвэрлэлийн осол гэж юуг хэлэх вэ?</b>
Ажиллагсад хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг үйлдвэрлэлийн осол гэнэ.
<b>Мэргэжлээс шалтгаалах өвчин гэж юуг хэлэх вэ?</b>
Ажиллагсад хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан өвчилсөнийг мэргэжлээс шалтгаалах өвчин гэнэ.
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр
<ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй болсон ажиллагчид олгох тэтгэвэр</li> <li>• Тэжээгчээ алдсаны тэтгэвэр</li> <li>• Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж</li> <li>• Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр</li> <li>• Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон ажиллагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл</li> <li>• Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардал</li> </ul>

Нийгмийн зардал, үр ашгийн тойм хүснэгтэд харуулснаар нийгмийн зардлыг Ү алтны уурхайн жишээн дээр үйлдвэрлэлийн ослын тоо, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, ажиллагсад олгосон нөхөн олговор гэсэн 3 параметраар авч үзнэ.

Хүснэгт 2-г харуулснаар 2005-2011 онуудад Ү алтны уурхайд гарсан үйлдвэрлэлийн ослын тоог тус уурхайн уулын ажлын тайлангийн маягт 1.16.3-ын дагуу үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийн судалгааны дүнг ашигласан. Хүснэгтээс харахад Ү алтны уурхайн үйлдвэрлэлийн

осолд өртсөн хүний тоо болон үйлдвэрийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилчны тоо, үүнээс хөдөлмөр чадвар алдалтын хувь тогтоолгосон ажилчдын тоог 2005-2011 онуудаар үзүүллээ. 2005, 2010 онд үйлдвэрлэлийн ослын мэдээлэл Ү алтны уурхайн уулын ажлын тайланд тэмдэглэгдээгүй байна. Уул уурхайд гарч байгаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчний судалгааны маягтууд дахь статистик мэдээлэл зөрөх, бүрэн бус мэдээлэлтэй байдаг явдал нь нийгмийн зардал үр ашгийг тооцоход хүндрэл учруулж байна.

*Хүснэгт 2. Ү алтны уурхайд гарсан үйлдвэрлэлийн осолд өртсөн болон хөдөлмөрийн чадвараа алдсан хүний тоо (онуудаар)*

Үйлдвэрлэлийн осол	Нэгж	Оноор						
		2005	2006	2007	2008	2009	2010	2011
Үйлдвэрлэлийн осолд өртсөн хүний тоо	Хүн		3	2	2	2		2
Үүнээс: Хөдөлмөрийн чадвараа алдсан ажилчны тоо	Хүн			2	1	1		2
Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь	Хувь			10-49	70	70		10-49

Уул уурхайн үйлдвэрлэлийн ослын улмаас нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан хүнд нөхөн олговрыг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг тус тус үндэслэн олгодог.

<b>Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний нөхөн олговор олгох хуульд заасан үндэслэл</b>	
<b>1. Тахир дутуугийн тэтгэвэр</b>	- Сарын дундаж хөдөлмөрийн хөлснөөс хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувь алдсан бол 10%-иар, 10-аас дээш хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтоох - Хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн тахир дутуугийн тэтгэврийн хэмжээ нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.
<b>2. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр</b>	- Нас барсан даатгуулагчийн авч байсан хөдөлмөрийн хөлснөөс доорх хэмжээгээр тогтооно. Үүнд o Хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 3 ба түүнээс дээш бол 100% o Хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2 бол 75% o Хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 1 бол 50%
<b>3. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж</b>	- Ажилласан хугацаа харгалзахгүйгээр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 100 хувиар бодож олгоно. - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцно - Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж олгох хугацааны дээд хязгаар нь дараалсан 12 сарын дотор 180 хоногоос хэтрэхгүй
<b>4. Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр</b>	- Хөгжлийн бэрхшээлтэй болж хиймэл эрхтэн, засал эмчилгээ / протез, ортопеди/ хийлгэсэн бол үнийг эхний удаад 100 хувь, цаашид нийгмийн даатгалын шимтгэл үргэлжлүүлэн төлж байгаа бол протез, ортопедийн эдэлгээний хугацаа дууссан тохиолдол бүрт үнийг бүрэн, нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй бол хоёр дахь удаа үнийн 50 хувийг нийгмийн даатгалын байгууллага тус тус нөхөн төлнө. - Зайлшгүй шаардлагаар мэргэжлийн /гэмтлийн/ эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ /протез, ортопед/-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан олгож болно - Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас рашаан сувилалд эмчлүүлж сувилуулбал рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний сувилалд ирэх, очих унааны зардлыг галт тэрэг, автомашины тухайн үед мөрдөж буй тарифыг үндэслэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас жилд нэг удаа төлбөр гаргуулж болно
<b>5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал</b>	- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын хэмжээ, санхүүжүүлэх журмыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

Ү алтны уурхайд үйлдвэрлэлийн ослын мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, улмаас 6 ажилчин Нийгмийн даатгалын тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу сангаас олгох үйлдвэрлэлийн осол, 17.6 сая төгрөгний нөхөн олговор авчээ.

*Хүснэгт 3. Ү алтны уурхайд үйлдвэрлэлийн ослоор нөхөн олговор авсан хүний тоо болон олгосон нөхөн олговрын хэмжээ*

Үйлдвэрлэлийн осол	Нэгж	Оноор						
		2005	2006	2007	2008	2009	2010	2011
Нөхөн олговор авсан ажилчны тоо	Хүн			2	1	1		2
Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь	Хувь			10-49	70	70		10-49
Олгосон нөхөн олговор	Сая төг			6.1	1.4	8.1		1.9

*Эх сурвалж: Уулын ажлын тайлан, 2005-2011, Ү алтны уурхайн хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн судалгаа, бүртгэл, 2012 (хөдөлмөр хамгааллын инженер)*

#### Жишээ

- 2005-2011 онуудад Ү алтны уурхайн нийт 6 ажилчин үйлдвэрлэлийн осолд орсон
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг 10-49 ба 70 хувиар тус тус тогтоосон
- Хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжийг Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох тухай хуулийг 4-р бүлгийн 14-р зүйлийг үндэслэн хөдөлмөрийн хөлсийг 100 хувиар тооцож олгосон.
- Тэтгэмжийг тооцоходоо цалингийн дунжийг 100 хувиар бодож тус бүр 36 сарын тэтгэмж олгосон.
- Үйлдвэрлэлийн осолд орсон 6 ажилчин нийт 17.6 сая төгрөгний тэтгэмжийг Ү алтны уурхайн компаниас олгожээ.

*(Эх сурвалж: Ү алтны уурхайн уулын ажлын тайлан, 2007)*

Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар ажил олгогч нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу ажилтныг үйлдвэрлэл, ажил, үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт ажилтнаа хамруулах ба шаардагдах зардлыг гаргах, ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангах үүрэгтэй гэж заасан байдаг. Иймээс уурхайн ашиглалтын хугацааны дотоод зардалд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал багтана. Ингэснээрээ үйлдвэрлэлийн осол гэмтэл, эрүүл мэндэд учирч болзошгүй нийгмийн нөлөөлөлд зарцуулж байгаа зардлыг үйлдвэрлэлийн дотоод зардалд шилжүүлж мөнгөжүүлэн тооцох боломжтой юм.

Хүснэгт 4-т Ү алтны уурхайн 2005-2011 онуудад хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг харуулж байна.

*Хүснэгт 4. Ү алтны уурхайн ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд зарцуулсан зардал*

Үйл ажиллагаа	Нэгж	Жилээр						
		2005	2006	2007	2008	2009	2010	2011
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн арга хэмжээ	сая.төг		31.5	67.8			123	87
Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл	сая.төг		85	60	183.7	188.5	68	56.3
А хүрээний ханиадны эсрэг вакцин	сая.төг		0	2.5				
Эрүүл мэндийн үзлэг	сая.төг	0.2	1.5	3.5	5.2	5.2	1.7	10
Үйлдвэрлэлийн ослын шалтгаан, хор уршгийг арилгах, судлан бүртгэх	сая.төг		0.5					
<b>Бүгд</b>		<b>0.2</b>	<b>118.50</b>	<b>133.80</b>	<b>188.90</b>	<b>193.70</b>	<b>192.70</b>	<b>153.30</b>

**Нийгмийн татвар**

Нийгмийн зардал, үр ашгийн дүн шинжилгээний хүснэгтэд “Нийгмийн татвар”-ын үзүүлэлтийг оруулсан ба нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хандиваас бүрддэг. Уул уурхайн компанийн үйлдвэрлэлийн орлогоос нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хандивт зарцуулсан зардлын мэдээллийг уурхайн уулын ажлын тайлан, холбогдох мэргэжилтнүүдээс гаргуулан авч ашиглана.

**Нийгмийн татварт юуг ойлгох вэ?**

Нийгмийн татвар нь иргэн, түүний ажил олгогч нь хуульд заасан нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын

шимтгэлийг урьдчилан төлж нийгмийн даатгалын сан бүрдүүлснээр өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, өвчлөх, хөгжлийн бэрхшээлтэй болох, нас барсан тохиолдолд гэр бүлийн гишүүдэд нь тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх, шаардлагатай үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахаар зохицуулсан нийгэм эдийн засгийн цогц арга хэмжээ юм.

**Жишээ:**

Ү алтны уурхай 2005-2011 онуудад Ү алтны уурхайн дотоод зардлаас улсын төсөвт эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 168.5 сая.төг, нийгмийн даатгалын шимтгэлд 2 тэрбум 261 сая.төг, хандивт 109.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ. (Хүснэгт 5)

*Хүснэгт 5. Ү алтны уурхайн улсын болон орон нутгийн төсөвт оруулсан нийгмийн татварын хэмжээ,*

Нийгмийн татвар	Хаана	Нэгж	Жилээр						
			2005	2006	2007	2008	2009	2010	2011
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Улсын төсөв	сая.төг	0.0	0.0	0.0	90.0	0.0	0.0	78.5
Нийгмийн даатгалын шимтгэл	Улсын төсөв	сая.төг	83.0	103.2	4.9	210.1	312.6	1.037.5	510
Хандив	Улсын төсөв	сая.төг	0.0	8.4	2.6	28.7	12.7	0.0	57.3
<b>Бүгд</b>	Улсын төсөв	сая.төг	<b>83</b>	<b>112</b>	<b>8</b>	<b>329</b>	<b>325</b>	<b>1.038</b>	<b>646</b>



Нийгмийн үр ашгийн тооцоог Ү алтны уурхайн түвшинд авч үзсэн ба тус уурхайн улсын төсөвт оруулж буй нийгмийн татвар, хандив, орон нутагт зориулсан нийгмийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хэмжээг мөнгөжүүлэн үзүүлэв.

*Хүснэгт 6 Ү алтны уурхайн жишээн дээр тооцсон нийгмийн үр ашиг: Улсын төсөвт төвлөрүүлсэн нийгмийн татварууд*

Нийгмийн зардал	Уурхайн ашиглалтын жилүүдээр				Нийт
	2005	2006	2007	2011	
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	0₮	0₮	0₮	78 460 000₮	168 500 000₮
Нийгмийн даатгалын шимтгэл	83 000 000₮	103 200 000₮	4 900 000₮	510 000 000₮	2 261 300 000₮
Хорогдуулсан нийгмийн татварын шимтгэл	83 000 000₮	99 230 769₮	4 530 325₮	465 068 486₮	2 038 614 111₮
Хандив	0₮	8 400 000₮	2 600 000₮	57 330 000₮	109 750 000₮
Хорогдуулсан хандив	0₮	8 076 923₮	2 403 846₮	45 308 732₮	92 176 806₮
Нийт нийгмийн ашиг	83 000 000₮	111 600 000₮	7 500 000₮	645 790 000₮	2 539 550 000₮
Хорогдуулсан нийгмийн ашиг	83 000 000₮	107 307 692₮	6 934 172₮	510 377 218₮	2 130 790 917₮
Нийгмийн хорогдуулалтын хувь	4%				

Ү алтны уурхай 2005-2011 онуудад эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 168 500 000 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 2 261 300 000 төгрөг, хандивт 109 750 000 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

ойлгож болно. Жишээлбэл ажлын байр бий болгох, орон нутаг болон улсын төсөвт татвар төлөх, зам, дэд бүтцийн хөрөнгө оруулалт, тэтгэлэгт хөтөлбөр, орон нутагт бизнесийн таатай орчин бүрдүүлэх, орон нутгийн худалдан авалт хийх

**Нийгмийн хөтөлбөр**

Нийгмийн хөтөлбөр
Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчин, нийгэмд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн хөгжлийг дэмжих, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор уул уурхайн компаниас санаачлан хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хандив, тусламжийг нийгмийн хөтөлбөр гэж

Нийгмийн хөтөлбөр, түүний хэрэгжилт, үр өгөөжийг тооцсон энэхүү хүснэгтэд орон нутгийн хөгжил, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, өв соёл, орон нутгийн иргэдийн бизнесийг дэмжихээс гадна орон нутгийн оюутан сурагчдын сургалтын төлбөр зэрэг тэтгэлэгт хөтөлбөр, хандив тусламж, хөрөнгө оруулалтыг багтаасан болно.

*Хүснэгт 7 Х нүүрсний уурхайн жишээн дээр тооцсон нийгмийн үр ашиг: нийгмийн хөтөлбөр*

Зориулалт	Хаана	Үйл ажиллагаа	Сая төг	Нийт ашиглалтын жил		Нийт
				1 дэх жил	2 дахь жил	
Санхүүгийн дэмжлэг	Сум	Санд зориулсан хандив	сая төг	206.20₮	-	215.60₮
Санхүүгийн дэмжлэг	Аймаг	Хөгжлийн сангийн хандив	сая төг	-	64.00₮	66.30₮
Санхүүгийн дэмжлэг	Аймаг	Хөгжлийн сангийн хандив	сая төг	-	-	500.60₮
Санхүүгийн дэмжлэг	Аймаг	Зудын хандив	сая төг	-	243.60₮	243.60₮
Санхүүгийн дэмжлэг	Аймаг	Зудын хандив	сая төг	-	39.70₮	44.70₮
Санхүүгийн дэмжлэг	Аймаг	Зудын хандив	сая төг	-	-	25.00₮
<b>Нийт</b>				<b>206.20₮</b>	<b>347.30₮</b>	<b>1 095.80₮</b>

**Жишээ:**

Х нүүрсний уурхайн орон нутагт зориулсан нийгмийн хөтөлбөр нь боловсрол, эрүүл мэнд, хүнс тэжээл, төрийн байгууллагуудын ойн баяр, шагнал урамшуулалд зориулсан санхүүгийн дэмжлэг, дэд бүтэц \зам\, ойн арга хэмжээний хандив зэргээс бүрдэж байгаа ба уурхай нээгдсэнээс эхлэн 7 жилийн туршид 9 531.48 төгрөгийг зарцуулжээ. Дээрх хүснэгтэд харуулснаар уурхайн ашиглалтын эхний жилд 206.20₮, хоёрдахь жилд 347.30₮, 7 жилийн туршид 1 095.80₮-ийг санхүүгийн дэмжлэг хэлбэрээр зарцуулсан нь нийгмийн үр ашиг болж байна. Ү алтны уурхайн 2009-2012 онуудад хэрэгжүүлсэн нийгмийн хөтөлбөрийн агуулга, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг авч үзье. Ү алтны уурхай хүнс тэжээл, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, санхүүгийн дэмжлэг, соёл урлаг, тэмдэглэлт ойг тэмдэглэхэд зориулсан хандив тусламжаас бүрдсэн нийгмийн хөтөлбөрт нийт 94.08 сая төгрөг зарцуулсныг Хүснэгт 3.7.2-оос харж болно.

*Эх сурвалж: Х нүүрсний уурхайн хэрэгжүүлсэн нийгмийн хөтөлбөр, Уулын ажлын тайлан, 2005-2012*

Ү алтны уурхай нийгмийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд жилд дунджаар 23.52 сая төгрөг зарцуулж байна. Ү алтны уурхай нийгмийн хөтөлбөрт орон нутгийн нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжил, зам, дэд бүтцийг дэмжсэн томоохон хөрөнгө оруулалт байхгүй байна. Хандив тусламжийн хүрээнд орон нутгийн засаг захиргааны байгууллагыг шатахуунаар хангах, байгууллагуудын ой, баяр ёслолын арга хэмжээнд хандив өргөх, цаг үеийн шинжтэй үйл явдалд (зуд) хүнсний бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийх зэрэг үйл ажиллагаа багтжээ.

*Эх сурвалж: Ү алтны уурхайн хэрэгжүүлсэн нийгмийн хөтөлбөр, Уулын ажлын тайлан, 2009-2012*

Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөгөөр нийгэмд үзүүлж буй хор хохирлыг бууруулахад уул уурхайн компаниуд нийгмийн хөтөлбөр хэлбэрээр багагүй мөнгө зарцуулдаг. Өөрөөр хэлбэл нийгмийн дам нөлөөг бууруулахад уул уурхайн компанийн хандив тусламж, эрүүл мэнд, боловсрол, зам, дэд бүтцэд оруулж байгаа хөрөнгө оруулалт нь нийгмийн үр ашиг болно.

**Соёл, уламжлалын алдагдлаар нийгмийн зардлыг илэрхийлэх нь**

Нийгмийн аливаа зардлыг мөнгөн хэлбэрээр илэрхийлэхэд дараах 2 шалтгааны улмаас ихээхэн хүндрэл учирдаг. Үүнд:

- Уул уурхайн үйл ажиллагаа болон архидалт, эсвэл биеэ үнэлэлт зэрэг янз бүрийн нийгмийн асуудлын хооронд уялдаа холбоог тогтоон нийгмийн зардлыг тооцох нь их хүндрэлтэй учир нь олон төрлийн өөр бусад хүчин зүйлс шууд бусаар нөлөөлж байдаг
- Нийгмийн зардлыг мөнгөжүүлэх нь нарийн төвөгтэй, зарим тохиолдолд боломжгүй, жишээ нь уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөгөөр нийгэмд учруулж буй нөлөөллийн бодит үнэ цэнийг хангалттайгаар олж тогтоох нь үгүй юм. Жишээ нь гэр бүл салалт. Гэр бүл салалтын бүх бодит нийгмийн зардлыг нь нэг бүрчлэн тогтоох боломжгүй юм.

Нийгмийн судалгаа болон статистик мэдээлэл, нийгэмд гарч буй тулгамдсан асуудлуудад уул уурхай нөлөөлдгийг тогтооход тусалдаг хэдий ч уул уурхайн үйлдвэрлэл явагддаг орон нутагт биеэ үнэлэх үзэгдэл өндөр хувьтай байгаад уул уурхай нөлөөлж байна гэж үнэлэх боломжгүй юм. Үүний нэгэн адилаар уул уурхай үйлдвэрлэлийн бүс дэх орон нутагт архидалтын түвшин өндөр, уул уурхайн ажилчид цалингаа аваад уурхайгаас өөр газар архидаж буй явдалд уул уурхайн компани бүрэн хариуцлага хүлээнэ гэж үзэх боломжгүйд хүргэж байгаа билээ. Түүнчлэн, уул уурхайн үйлдвэрлэл нь нэг төрлийн нийгмийн асуудалд өөр өөр төрлийн маргаантай үр нөлөө үзүүлдэг. Жишээ нь уул уурхайн салбарын эргэн тойронд амьдарч буй хүмүүсийн гэр бүл салалтын түвшинг авч үзэхэд уул уурхайн салбар нь гэр бүлийн салалтад нөлөөлж байгаа ч нөгөө талаас харахад тэд өндөр цалин авдаг учир ядуурлыг бууруулж байна.

Нийгмийн маш өргөн хүрээтэй асуудлуудыг авч үзэхэд жишээ нь боловсрол, гэр бүл, хөдөлмөрийн мөлжлөг, хөдөлмөрийн аюулгүй байдал, уул уурхайг тойрсон нийгмийн гаж үзэгдэл \архидалт, биеэ үнэлэлт гэх мэт\ нийгмийн асуудлууд бүс нутаг, орон нутаг бүрт харилцан адилгүй ялгаатайгаар илэрч байдаг. Мөлжлөг, аюултай байдал зэрэг нийгмийн асуудлууд орон нутаг бүрт ялгаатайгаар илэрч байдаг. Өөрөөр хэлбэл эдгээр нийгмийн асуудлууд орон нутагт ялгаатай илэрч байгаа тэр хэмжээгээр нийгмийн зардал нь харилцан адилгүй байна. Энэхүү ялгааны улмаас орон нутаг болон нийгмийн асуудал нэг бүрт нь тохируулж ямар нэгэн томъёо, аль эсвэл баримттай эх сурвалж тогтооход их бэрхшээлтэй.

Үндэсний хэмжээний статистик мэдээлэл уул уурхайн компаниудын ашигтай талыг үзүүлсэн байдаг. Жишээ нь уул уурхайн компани нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл болон уул уурхайн үйлдвэрлэлд гардаг байнгын ослоос үүдэж гарах хохирлыг нөхөн төлдөг, харин бусад салбарууд тэр болгон уул уурхайн салбарын адил байнгын осолтой холбоотой зардал мөнгийг төлдөггүй байна. Өөрөөр хэлбэл үндэсний хэмжээний статистик нь уул уурхайн компанийн нийгэмд үзүүлэх нөлөөллийн зөвхөн тодорхой нэг хязгаарлагдмал хэсэг буюу улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлж буй ерөнхий ашгийг хамарч харуулдаг, харин осол гэмтлийн нөхөн олговор, тэтгэмж, нийгмийн хөтөлбөрт зарцуулсан зардлыг тэр хамарч харуулдаггүй.

Харин зардал үр ашгийн дүн шинжилгээ нь олон улсын түвшинд хэрэглэдэг хамгийн сайн туршлага. Энэ зардал үр ашгийн дүн шинжилгээгээр Монгол дахь нийгмийн нөхөн төлбөр өөрөөр хэлбэл нөхөн төлбөр гарна гэж төлөвлөсөн зардал болон бодитойгоор гарсан нөхөн төлбөр хоёрын хоорондын ялгааг хэмждэг. Канад, Австрали зэрэг уул уурхай өндөр хөгжсөн улс орнуудад нийгмийн зардал үр ашгийн шинжилгээг хийж тэр болгон

мөнгөөр илэрхийлж чаддаггүй нийгмийн зардлыг \external cost\ мөнгөжүүлсэн сайн туршлагатай. Тухайлбал Австрали улс зардал үр ашгийн дүн шинжилгээний аргаар уурхайг хөгжүүлэхээс үүдэн гарсан бүх соёлын алдагдлыг нийгмийн зардал гэж үзэн мөнгөжүүлэн тооцож, тэрхүү зардлыг уул уурхайн компаниуд нөхөн төлдөг байна.

Австрали улсад уул уурхайн компани уурхайн үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө орон нутгийн иргэдтэй уулзан эрх ашгаа тохиолцон ярилцдаг. Учир нь уул уурхайн компани нь уурхайн үйл ажиллагааны улмаас орон нутгийн иргэдийн үл хөдлөх хөрөнгийн эрхийн \газар, бэлчээр, газар дээрх байгууламж\ алдагдал болон нийгмийн хохирлыг нөхөн төлөхөө харилцан зөвшилцдөг.

#### **Нийгмийн хор хохирлын жишээ нь:**

- Уламжлалт ёсоор тухайн газрыг хэрэглэж байсан орон нутгийн хүмүүсийн мэдлэг өөрчлөгдөнө. Жишээ нь улирлын чанартайгаар малаа оторлуулж өвөлжүүлж аль эсвэл зусдаг газар нь уурхайн ашиглалтын мэдлийн газар болж хувирахад орон нутгийн иргэд тэрхүү газраа бэлчээрийн зорилгоор хэрэглэхээ больсноор отор хийх, өвөлжих, зусах нөхцөлгүй болсоноор соёл уламжлалын алдагдал гэж үздэг байна.
- Бэлчээрийн газраа ашиглан мал сүргээ өсгөж үржүүлэн үр ашгийг нь үргэлжлүүлэх нөхцөл байдал алдагдсанаар энэ нь уугуул нутгийн иргэд, малчдын хувьд бас хохирол болж байна.
- Үе дамжуулан ашиглаж байсан газар нутаг болон орон нутаг нь өөрчлөгдөх нөхцөл байдал нь мөн соёл уламжлалын алдагдал буюу хохирол болж байна. Яагаад гэвэл тэдний хүрээлэн буй хөрш зэргэлдээ зүйлс болон тэдэнд хамааралтай зүйлс

нь өөрчлөгдсөнөөр сэтгэл зүйн стресс уялдан гардаг.

Австрали улсын туршлагаар уул уурхайн компани нь үнэт олдвор бүхий газрыг олоод орон нутгийн иргэдтэй зөвшилцөн зөвшөөрөл хүлээн авах хүртэл үйл ажиллагаагаа эхлэх ёсгүй юм. Хэрвээ тэд хоорондоо зөвшилцөлд хүрэхгүй бол шүүхээр шийдэгддэг.

Сүүлийн 15 жилийн туршид өөрөөр хэлбэл Австралийн туршлагаас харахад нэг талаас уул уурхайн компани нөгөө талаас орон нутгийн иргэд соёл уламжлалын алдагдлыг нөхөн төлүүлэхэд үнэ хаялцан зөвшилцөхөд гарсан түүхэнд ойролцоогоор дундчилж төлөх төлбөрийн хэмжээг тухайн уурхайг ашиглаж эхлэхээс хаагдах хүртэл тооцон гаргасан нийт бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.5 хувиар бодож тогтоодог байна. Мэдээж энэ нь бүдүүвчилсэн тооцоо бөгөөд ингэж тооцсоноор соёлын алдагдалд төлөх нийгмийн төлбөрийг тогтооход бас нэг баримжаа болж өгч байгаа юм.

**Соёл уламжлын алдагдлын зардал үр ашгийн шинжилгээ**

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй соёл уламжлалын алдагдлыг нийгмийн зардал хэмээн үзэж мөнгөжүүлэн тооцсоныг Х нүүрсний уурхайн жишээн дээр Хүснэгт 9-д харууллаа. Соёл уламжлалын алдагдал нь ихэвчлэн тоогоор илэрхийлэх боломжгүй дам зардал болж байдаг. Өөрөөр

хэлбэл уул уурхайн компаниуд дотоод зардалдаа соёл уламжлалын алдагдалд нөхөн төлөх зардлыг суулгадаггүйгээс дам зардал хэвээр үлдэж энэ нь орон нутгийн иргэд, малчдад нийгмийн хор хохирол болж үлддэг. Олон улсын түвшинд уул уурхайн компаний ашиглалтын үйл ажиллагааны туршид олборлох нийт бүтээгдэхүүний хувь ба энэхүү хувь хэмжээ нь нийт олборлосон бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.5 хувь нь юм. Соёл уламжлалын алдагдлын зардал =0.5% буюу уурхайн ашиглалтын туршид гаргасан нийт бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.5 хувиар бодсон үнэлгээгээр тооцоолдог.

Нийгмийн зардлын хүснэгтэд харуулснаар Х, Y 2 уурхайн жишээн дээр соёл уламжлалын алдагдлыг тооцоходоо Австрали улсад тухайн уурхайг ашиглаж эхэлснээс хаагдах хүртэлх хугацаанд уул уурхайн компанийн үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож тогтоодог аргачлалыг ашиглан тооцов.

Хүснэгтэд харуулсанаар Х нүүрсний уурхайн жишээн дээр соёлын алдагдлын нийт үнэ цэнийг тооцоход Х нүүрсний уурхайн нийт ашиглалтын хугацааг 19 жилээр авсан ба тухайн жилүүдэд олох орлогын 0.5 хувиар тооцсон болно. Жишээ нь уурхайн ашиглалтын эхний жилд 306028800 төгрөгийг соёл уламжлалын алдагдалд төлөх

*Хүснэгт 9 Х нүүрсний уурхайн жишээн дээр тооцсон нийгмийн зардал: Соёл уламжлалын алдагдал*

Нийгмийн зардал	Уурхайн ашиглалтын жилүүдээр				Нийт
	1дэх	2дахь	3дах	19 дэх	
Соёл уламжлалын алдагдал	306 028 800₮	1 901 143 200₮	3 102 792 000₮	3 087 612 000₮	81 685 401 600₮
Хорогдуулсан соёл уламжлалын алдагдал	306 028 800	1 828 022 308₮	2 868 705 621₮	1 524 132 110₮	56 712 162 192₮

Нийт бүтээгдэхүүнд эзлэх нөхөн төлбөрийн харьцаа	0.50 хувь
Нийгмийн хорогдуулалтын харьцаа	4 хувь

нийгмийн төлбөр, уурхайн ашиглалтын хоёрдахь жилд 1901143200 төгрөг гэх мэтээр 19 жилийн туршид 81 орчим тэрбум төгрөгийг соёлын алдагдалд төлөх нийгмийн төлбөр гэж тооцов. \Хүснэгт 9\

Х нүүрсний уурхайн жишээн дээр соёлын алдагдлын нийт үнэ цэнийг тооцоохдоо Х нүүрсний уурхай нийт ашиглалтын жилүүдэд 81 тэрбум төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба үүнээс 42.3 тэрбум төгрөгийг соёл уламжлалын алдагдалд төлөх тооцоо гарч байна. Энэ нь тухайн уурхайн хувьд нийт нийгмийн зардлын 52 хувь нь уурхайн дотоод зардалд шингэж байгааг харуулж байна.

Уул уурхайн салбарын нийгэмд үзүүлж буй нөлөөллийн зардал үр ашгийн шинжилгээг хийснээрээ нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, нийгмийн хор хохиролыг мөнгөжүүлэн тооцож, хэн хэдээр яаж хохирч

байгааг харьцуулж харах боломж олгодог. Мөн үр ашгийн хувьд ямар төрлийн үр ашиг эдийн засагтаа юу эсвэл нийгэмдээ юу эсвэл байгаль орчинд хэдий хэмжээгээр хэнд үр өгөөж оруулж байгааг харьцуулж харах боломжтой. Цаашид уул уурхайгаас хамааралтай эдийн засагтай орны хувьд энэ төрлийн судалгааг өргөжүүлж, үр дүнг нь бодлого боловсруулагчид, бодлогын яамны мэргэжилтэн, уул уурхайн компаниудад танилцуулж, зардал үр ашгийн шинжилгээний үр дүнд тулгуурлан тухайн уурхайг ажиллуулах эсэх шийдвэр гаргахад ашиглаж байх хэрэгтэй юм. Аливаа уурхайн төсөл урт хугацаанд үргэлжлэхийн тулд уурхайд хөрөнгө оруулагч, улс орон, орон нутгийн иргэдийн аль алинд нь ашигтай байх ёстой. Уул уурхайн үйлдвэрлэлийн үр ашиг нь зөвхөн уул уурхай компанид ашигтай бол уг уурхайг хаах хүртэл арга хэмжээг авахад энэхүү зардал үр ашгийн дүн шинжилгээний арга тусална.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ӨӨРИЙН ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ, ТҮҮНИЙГЭЭ ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ – FREEDOM OF OPINION AND EXPRESSION



Санхүү, эдийн засгийн дээд  
сургуулийн Хүмүүнлэгийн ухааны  
тэнхмийн багш

**Ж.ХУЛАН**



Санхүү, эдийн засгийн дээд  
сургуулийн Хүмүүнлэгийн ухааны  
тэнхмийн багш

**Б.МӨНГӨННАХИА**

*Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал 19-р зүйл:*

*Хэн боловч өөрийн үзэл бодолтой байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй”*

Та энгийн нэгэн иргэн, улс төрийн зүтгэлтэн хэн боловч ямар ч хорио саадгүйгээр өөрийн үзэл бодолтой байж түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрх нь хүний бусад эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл төдийгүй ардчилсан нийгмийн үндэс суурь болдог.<sup>1</sup> Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүн өөрийгөө хүндэтгэх, өөрийгөө хөгжүүлэх, нийгэмд эзлэх байр суурьтай байх нөхцөл юм. Хувь хүний тухайд үзэл бодол, мэдээллээ бусадтай чөлөөтэй хуваалцах нь хүмүүний ертөнц, орчин тойрноо танин мэдэхэд тусалдаг бөгөөд хүн бүрийг төр хүндэтгэж, хамгаалж байгаагийн нэг илрэл юм. Төрийн хувьд хүн бүр ямар ч хорио саадгүйгээр өөрийн үзэл

бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь шударга, зөв удирдлагыг тогтоох, цаашлаад эдийн засгийн болон нийгмийн дэвшилд хүргэнэ. Энэ эрх нь төрийг удирдах ажилд шударга, нэр хүндтэй хүмүүсийг татан оролцуулах, иргэдийн зүгээс тулгамдсан асуудлуудаа дэвшүүлэх, аливаа шинэ хууль гаргахад хэлэлцүүлэг өрнүүлснээр уг хуулийн хэрэгжилтийн баталгааг бүрдүүлж, бусад эрхүүдийг хэрэгжүүлэх үндэс суурь нь болно.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19-р зүйлд “Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад

<sup>1</sup> Хүний эрхийн товч тайлбар. 2012



аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана” гэж заасныг задалж үзвэл:<sup>2</sup>

- “Хүн бүр.....эрхтэй”. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүн бүрт хамаатай бөгөөд боловсролын түвшин, арьс өнгө, яс үндэс, хүйс, шашин шүтлэг, хэл, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахыг хориглоно.

- “...мэдээлэл....эрж хайх, хүлээн авах, түгээх...” ойлголт нь сонин, сэтгүүл унших, олон нийтийн мэтгэлцээнийг сонсох, нэвтрүүлэг үзэх, интернет ашиглах, төрийн албанаас мэдээлэл авах боломжоор хангагдахыг хэлнэ. Энэ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй нягт холбоотой.

- “...төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг...”. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь зөвхөн хэрэгтэй, ашиг тустай, зөв мэдээлэлд хамаатай бус маргаан дагуулсан, худал, аягүйрхүүлсэн мэдээлэл, үзэл санаа байхыг ч үгүйсгэхгүй юм. Аливаа үзэл санаа нь хэн нэгэнд таалагдахгүй, буруу гэж байгаа нь түүнийг хянан шалгах явдал болохгүй.

- “...улсын хил хязгаарыг үл харгалзан...”. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь аль нэг улсын хилээр хязгаарлагдахгүй. Төр нь иргэддээ мэдээллийг хайх, олж авах, түгээх боломжоор хангах ёстой.

- “...өөрийн сонгосон бусад аргаар...”. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх арга нь уламжлалт болон бусад хэлбэрээр байж болно гэж тайлбарласан байна.

2008 оны 12-р сарын 11, 2009 оны 2-р сарын 23-24-ны өдрүүдэд Лондон хотод Нэгдсэн Үндэсний Байгууллагын төлөөлөгчид, хүний эрхийг хамгаалах асуудлаар мэргэшсэн экспертүүд цугларч, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлүүдийг бататгасан

“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх ба тэгш эрхийн Кемдений зарчим”-ыг (XIX ARTICLE 19 Global campaign for free expression) тунхаглан баталжээ. Зарчим нь улс орнууд, байгууллага, хувь хүмүүсийг хүний эрхийг дээдэлж, энэхүү зарчмуудыг үйл ажиллагаандаа баримтлахыг уриалжээ.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдад түгээх аргын нэг нь интернет орчин билээ. Дэлхийг хэрсэн аалзны шүлс буюу интернэтийн хэрэглээ нь<sup>3</sup> бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг бодвол компьютертэй, интернэт сүлжээнд холбогдсон хэн боловч энэ орчинд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүссэн мэдээллээ, хүссэн цагтаа дэлхийн аль ч газраас хүлээн авах, ямар ч улсын иргэнтэй харилцаа холбоо тогтоох боломжийг олгодог гэх мэт сайн талтай. Мөн интернэт нь хүн бүрт аливаа мэдээлэл, оюуны өмчийн болон урлагийн бүтээлийг бий болгож, түгээх боломжийг өгдөг. Ийнхүү өргөн тархсан, өндөр хурдтай хөгжиж буй цахим ертөнцийн хэрэглээг улс орнууд хянах гэж оролдож байна. Учир нь цахим орчинд сайн зүйлүүд олон ч сайны хажуугаар саар байдагтай адил ёс суртанхуунд үл нийцсэн сөрөг зүйлүүд ч байна. Улс орнуудад тодорхой агуулга бүхий мэдээллийг интернетэд байршуулах, түгээхийг хориглосон хууль гаргаж энэхүү хуулийг зөрчиж буй түгээгч, хэрэглэгч нарт хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох гэж хичээж байна. Мөн дундын серверийг ашиглан хууль зөрчсөн тодорхой агуулга бүхий мэдээллийг хянах, хариуцлага тооцох, цаашлаад веб хуудсуудын үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг авч байна. Үүнтэй холбогдуулан эх сурвалжуудад дурдагддаг дараах жишээнүүдийг авч үзье.

1. Yahoo компанийн Хонконг дахь охин компанитай холбоотой маргаан.

<sup>2</sup> www.article19.org

<sup>3</sup> Хүний эрхийн товч тайлбар. 2012

Хятадын сонины газрын редактор сэтгүүлч Ши Тао нь Yahoo-гийн хэрэглэгч бөгөөд өөрийн үзэл бодлоо илэрхийлэн Yahoo-гийн групп, формууд дээр нийтлэл бичсэнийхээ хариуд 10 жилийн хорих ял сонсчээ. Энэ тухай Хонконг дахь Yahoo-гийн охин компанийн гүйцэтгэх захирлын мэдэгдсэнээр “Бид мэдээллийг Хятадын Засгийн газарт өгсөн нь үнэн. Гэвч тэдэнд яагаад энэ мэдээлэл хэрэгтэй болсныг мэдэхгүй. Гэлээ ч бид Хятад улсын газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа учир тэдний хууль тогтоомжийг дагаж мөрдөх учиртай” гэжээ. Мөн энэ хэргээр улс төрийн зүтгэлтэн Ванг Сионинг эхнэрийн хамт хорьсон байна. Ванг нь Хятадын ардчилал, шинэчлэлт, олон намын тогтолцоот системийн талаар Yahoo-н групп, формууд дээр нийтлэл бичдэг нэгэн. Тэрээр Yahoo нь “Хонконгийн Цагдаагийн газрын хүсэлтийн дагуу миний нийтэлж буй мэдээлэлд хяналт тавьж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхэд маань халдсан” хэмээн гомдол гаргасан. Учир нь Yahoo түүний нийтэлж буй мэдээлэлд хяналт тавих системийг yahoo-н серверт холбох боломжийг цагдаагийн газарт олгожээ. Yahoo “Хятадад үүссэн энэ байдал бидэнд ахадсан зүйл бөгөөд Америкийн Засгийн Газрын оролцоогүйгээр шийдэх боломжгүй” хэмээн мэдэгджээ.

Хүмүүс yahoo, google, facebook-ийг ашиглаж өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, түгээх эрхээ хэрэгжүүлдэг. Харин ийм эрхтэй болохын тулд тухайн компанийн цахим гэрээтэй танилцаж, гэрээний нөхцлийг хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатай ч энэхүү гэрээний утга, агуулгыг уншилгүйгээр зөвшөөрөх буюу **agree** товчийг дардаг нь ирээдүйд бий болох аливаа нэгэн үр дагаврыг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл болж байна.

Yahoo компани<sup>4</sup> нь хэрэглэгчиддээ 25 хуудас бүхий хэрэглэгчийн хувийн нууц болон бусад холбогдох мэдээллийн нууцлалын тухай гэрээг хэрэглэгч болох үед танилцуулдаг байна. Тухайлбал:

Гэрээний “Мэдээлэл дамжуулах болон задруулах тухай” гэх хэсэгт *Yahoo* нь таны хувийн мэдээллийг доор дурдсанаас бусад тохиолдолд бусдад дамжуулахгүй. Үүнд нь:

- Таны мэдээллийг хамтран ажилладаг байгууллагууддаа гэрээний дагуу *Yahoo-гийн* өндөр нууцлалтайгаар */privacy policy/* өгнө. Дээрх байгууллагууд нь таны мэдээллийг цааш задруулахгүй байх үүрэгтэй.
- *Yahoo* нь хүний зөрчигдсөн эрхийг хамгаалах зорилгоор шүүхээс ирүүлсэн хүсэлтийн дагуу таны мэдээллийг шүүхэд өгнө.
- *Yahoo* нь мэдээлэл солилцох нь хууль бус үйл ажиллагаа болон залилангаас урьдчилан сэргийлэх, мөн гэмт хэргийг мөрдөн шалгах, хэн нэгнийг айлган сүрдүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чухал хэрэгтэй гэж үзнэ.
- Хэрэв *Yahoo* нь өөр компанийн мэдэлд очих эсвэл өөр компанитай нэгдэх тохиолдолд таны мэдээллийг тухайн компанид дамжуулна. Энэ тохиолдолд *Yahoo* нь өөр компанийн мэдэлд очих эсвэл өөр компанитай нэгдэхээс өмнө таны мэдээлэл өөр компанид шилжиж байгаа тухай мэдэгдэнэ гэж заасан байдаг байна.

Энэ нь “...мэдээлэл нь аль хэдийнэ таваарын шинжтэй болж, түүнийг цуглуулах, хадгалах, боловсруулах, ашиглах зэрэгтэй холбоотой гэрээний харилцааны объект болж ... хуулиар хориглоогүй аргаар олж авсан эзэмшигчид нь түүнийг ашиглах, захиран

<sup>4</sup> <https://www.yahoo.com/>

зарцуулах боломжийг олгосныг<sup>5</sup> харуулж байна.

2. АНУ-ын интернетийн харилцааг зохицуулсан хоёр хууль Үндсэн хуулийн нэгдүгээр нэмэлттэй зөрчилдөж байгаа тухай маргаануудыг товч өгүүлэе.

1997 оны алдартай Reno болон ACLU (The American Civil Liberties Union буюу Америкийн иргэний эрх чөлөөний Холбоо)-ийн<sup>6</sup> хоорондын маргаан. 1996 онд батлагдсан Communications Decency Act буюу Харилцаа холбооны ёс суртахууныг зохицуулах тухай хуулийн зорилго нь хэний боловч аливаа мэдээллийг нийтлэх, түгээх, хүлээн авах эрхийг хангах, тэр дундаа насанд хүрээгүй хүмүүсийг цахим ертөнцийн хор уршигтай мэдээллээс хамгаалахад оршино. Тус хуулийн 223(a)-д 18-аас доош насны хүмүүс нь садар самуун, ичгүүргүй аливаа мэдээлэл хүлээн авсан эсвэл түгээсэн бол, мөн 223(d)-д илтэд доромжилсон, зохимжгүй үг хэллэг нийтэлсэн эсвэл садар самуун дүрслэл, зургийг илгээсэн бол гэмт хэрэгт тооцох тухай заажээ. Америкийн иргэний эрх чөлөөний холбоо нь конгрессоос баталсан энэхүү хуулийн дээрх хоёр заалт нь Нэгдсэн улсын Үндсэн хуулийн “Конгресс ямар нэг шашныг албан ёсны болгон тунхаглах буюу түүнийг чөлөөтэй шүтэх, үг хэлэх эсвэл хэвлэлийн эрх чөлөөг хориглосон, Засгийн газарт хандаж санал гомдлоо барагдуулах тухай өргөх бичиг барьж тайван жагсаал, цуглаан хийх ард түмний эрхийг хязгаарласан нэг ч хуулийг Конгресс гаргах ёсгүй”<sup>7</sup> гэх нэгдүгээр нэмэлттэй зөрчилдөж байна хэмээн тойргийн шүүхэд гомдол мэдүүлсэн. Тойргийн шүүх дээрх хоёр заалт нь Нэгдсэн улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэрийг гаргажээ. Гэвч энэ

<sup>5</sup> Д.Бат-Өлзий “Иргэний эрх зүй I” УБ., 2003

<sup>6</sup> <http://www.infoplease.com/us/supreme-court/cases/ar33.html#ixzz2uUQZxkFr>

<sup>7</sup> Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль. Хян. Доктор С.Нарангэрэл., 2000

шийдвэрийг ерөнхий прокурор Жанет Рено эсэргүүцэж, Нэгдсэн улсын Засгийн газрын нэрийн өмнөөс дээд шүүхэд давж заалдсан боловч дээд шүүхийн нийт шүүгчдийн 9-ний 7-гийн саналаар тойргийн шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Дээд шүүхийн ерөнхий шүүгч Жон Паул Стевенс хэлэхдээ “Интернэт хэрэглэгчийг хянахад хэцүү тэр тусмаа насыг хянахад хүндрэлтэй. Гэхдээ үүнийг ёс суртахуунаар болон эцэг эхийн хараа хяналтан доор хэрэгжүүлэх боломжтой юм. Үнэндээ интернэт дэх ёс суртахуунд үл нийцсэн, садар самуун материалууд нь компьютерийн дэлгэц дээр өөрөө шууд гараад ирэхгүй шүү дээ, үүнийг хэрэглэгч өөрөө идэвхтэй ирж хайсан л байж таарна” гэжээ.

2000 оны 12-р сард Children’s Internet Protection Act буюу Интернетэд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль батлагджээ. Тус хуулиар нийтэд үйлчилдэг номын сангуудын компьютер нь насанд хүрээгүй хүмүүсийг садар самуун агуулсан мэдээллээс хамгаалах “шүүлтүүр” програмуудтай байхыг шаардсан байна. АНУ-ын Дээд шүүхэд энэ хуулийн заалт нь Үндсэн хуультай зөрчилдөж байгаа эсэх талаар авч хэлэлцээд, 2003 оны 6-р сарын 23-нд Үндсэн хуулийн үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан нэгдүгээр нэмэлтийг зөрчөөгүй гэсэн шийдвэр гаргажээ. Шүүх үзэхдээ “насанд хүрсэн хүний хүсэлтээр “шүүлтүүр” программыг зогсоох боломжтой тул нэгдүгээр нэмэлттэй зөрчилдөхгүй” гэжээ.

3. Өөр нэг жишээ бол CompuServe-Germany компаний эсрэг Баварийн хэрэг.<sup>8</sup> CompuServe гэх америкийн компани Баварийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 1995 оны 11-р сард прокурорын байгууллагын мөрдөх ажиллагааны явцад

<sup>8</sup> <http://www.ukrreferat.com/index.php?referat=175&p-g=73&lang=book>, <http://www.cdt.or>

хүүхдийн садар самуун, Гитлер болон нацизм, хүчирхийлэл сурталчилсан компьютерийн тоглоомуудтай 300 гаруй “мэдээний групп” олжээ. CompuServe даруй арга хэмжээ авч хүүхдийн садар самуун бүхий мэдээллүүдийг хаасан байна. Харин хэрэглэгчдийг хүүхдийн үзэж болохгүй мэдээллүүдийг хаадаг хамгаалалтын программаар хангажээ. Гэвч хэдхэн сарын дараа хувь хүмүүс тус компанийн сервер дээр садар самуун агуулсан мэдээллүүдийг дахин тавьжээ. 1998 оны 5-р сард Мюнхен хотын шүүх CompuServe компанийг Залуучуудыг хамгаалах тухай хуулийг зөрчиж, садар самууныг олон нийтэд түгээсэн гэж үзээд тус компанийн захирал Феликс Зоммаад 2 жилийн тэнсэн харгалзах ял оноож, 100.000 маркаар торгожээ.

1999 оны 11-р сард давж заалдах шатны шүүх “CompuServe нь өөрийн зүгээс шалтгаалах бүх арга хэмжээнүүдийг авсан учраас хариуцлага хүлээхгүй” гэж үзээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгосон байна.

Дээр дурдсан жишээнүүдэд интернет орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл олж авах, түгээх эрхүүдээ хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудлууд байгаа нь харагдаж байна. Тийм ч учраас 2011 оны 6-р сарын 1-нд “Интернет орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тунхаг”<sup>9</sup> бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын холбооны аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллага (Organization for Security and Co-operation in Europe), Америкийн улсуудын байгууллага (Organization of American states), Африкийн холбоо (African Union Authority) зэрэг байгууллагуудын хүний эрхийн асуудал хариуцсан төлөөлөгчид болон “Артикль 19”

<sup>9</sup> [www.osce.org](http://www.osce.org), [www.eliberator.ru/normative-base/ELEMENT-10=57](http://www.eliberator.ru/normative-base/ELEMENT-10=57)

байгууллагын санаачлагаар баталсан байна.

Энэхүү тунхаг бичиг нь ерөнхий зарчим, техникийн талаас интернетийн үйлчилгээ үзүүлдэг субъектүүдийн хариуцлага, мэдээллийг хянах, хаах, эрүүгийн болон иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх, интернет ашиглах боломжоор хангах зэрэг асуудлуудыг тусгасан хэсгүүдээс бүрдэнэ. Тухайлбал, ерөнхий зарчим гэсэн хэсэгт хүн бүрийн интернетийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарахыг чухалчилсан бол мэдээлэл түгээх техникийн үйлчилгээ үзүүлдэг субъектүүдийн хувьд бусдын бүтээсэн контентийн төлөө хариуцлага хүлээхгүй байх, үйлчлүүлэгчдийнхээ контентийн талаар мониторинг хийх үүрэг хүлээхгүй байхаар тусгажээ. Энэ нь дээр дурдсан CompuServe-Germany компанийн эсрэг Баварын маргаантай холбоотой жишээнээс харагдаж байна.

Мэдээллийг хянах, хаах талаар веб хуудас, IP- хаяг, олон нийтийн сүлжээг хүчээр хаах нь яг л сонин, радио телевизийн нэвтрүүлгийг хааж байгаатай адил бөгөөд энэ адагтаа авч буй арга хэмжээ юм. (жишээ нь хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хааж болно)

Хамтарсан тунхаг бичигт дэлхийн олон зуун сая хүн дуу хоолойгоо бусдад хүргэх, мэдээлэл авах өргөн боломжоор хангагдах, олон ургальч үзэл, ил тод байдлыг бататгахад интернетийн ач холбогдлыг тэмдэглээд улс орнууд олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд интернетийн хэрэглээг хязгаарлах арга хэмжээ авч болохыг тусгажээ. Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл олж авах, түгээх эрхийг бусдын нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгоор хязгаарлаж болохыг заасан хэдий ч зарим улс орнууд хууль тогтоомжиндоо энэхүү томъёоллыг бүрхэх,

тодорхойгүй байдлаар тусгадаг байна.

Хэдийгээр улс орнууд интернет орчинг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх гэж хичээж байгаа боловч бүгдийг төрөөс хянах боломжгүй гэдэг нь харагдаж байна. “Цахим ертөнц бол 21 дүгээр зууны олон нийтийн индэр, дэлхий даяараа хуран цугладаг “хотын төв талбай”<sup>10</sup> болсон нь факт юм.

Интернетийн хэрэглээ буюу өөрийн бодлоо бусадтай хуваалцах, мэдээлэл олж авах, түүнийгээ түгээх эрхийг төр засгийн зүгээс нийгмийн сайн сайхныг бодож хуулийн хүрээнд хязгаарладаг ч, энэхүү хязгаарыг зүй зохистой түвшинд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хатуу баримтлан тогтоох нь зүйтэй болов уу.

Интернетийн орчинг алан хядах ажиллагаа, бослого үймээнд уриалан дуудах, ёсзүйд үл нийцэх мэдээ материалуудыг тарааж бусдын эрхэнд халдах зэргээр ашиглаж байгаа нь нууц биш. Арабын орнуудын тогтворгүй байдал “арабын хувьсгал” нэртэй Тунис, Египтээс

эхэлсэн ба үүнд интернет багагүй үүрэг роль гүйцэтгэсэн гэдгийг хэн хүнгүй мэдэх биз. Дээр өгүүлсэн жишээнүүдэд Хятад улс иргэдийнхээ сэжигтэй гэж үзсэн захидал харилцааг хянах, Америк, Герман садар самууныг сурталчлахыг хориглох гэж хүчин чармайлт гаргаж байгааг харж байна.

Монгол Улсад Эрүүгийн хууль, Иргэний хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиуд үйлчилж байна. Эдгээр хуулиуд нь төр, аливаа нэгэн байгууллагын тухай мэдээллийг олж авах, нууц мэдээлэл гэдэгт юуг ойлгох талаар зохицуулсан. Харин интернетийн орчинд оролцогч субъектүүд болох хувь хүний эрх, техникийн үйлчилгээ үзүүлж байгаа түгээгч компаниудын эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль эрх зүйн актууд дутагдалтай бөгөөд энэ асуудлыг анхаарч ажиллах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

<sup>10</sup> “Интернэтийн эрх чөлөө” Элчин сайд Эдлтоны нийтлэл. [http://mongolian.mongolia.usembassy.gov/oped\\_22212.html](http://mongolian.mongolia.usembassy.gov/oped_22212.html)

## ХҮНИЙ ЭРХИЙН ОНОЛЫН ЭЛЕМЕНТҮҮД

## АМАРТҮЯ СЕН

## 1. Онолын хэрэгцээ

Орчин үеийн улс төрд хүний эрх гэхээр цөөн хэдэн ойлголтыг дурддаг. Дэлхий дээр иргэний харьяалал, хууль тогтоомжоос хамаарахгүй хүндэтгэвэл зохих суурь эрх хүн бүрт бий гэдэг санаанд туйлаас сэтгэл татам нэг зүйл байдаг. Хүний эрхийн талаарх ёс суртахууны шаардлагыг эрүү шүүлт, дур зоргоор баривчлах зэргийг эсэргүүцэхээс эхлээд өлсгөлөнг зогсоох, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхгүй байгааг таслан зогсоохыг шаардах зэрэг маш олон янзын зорилгоор хэрэглэж ирсэн билээ.

Түүнчлэн хүний эрх нь хүмүүст заавал байх, тэр бүү хэл тодорхой хууль тогтоомжгүйгээр хүмүүст байх ёстой гэдэг гол санааг үндсээрээ тодорхойгүй, маргашгүй нотолгоо дутмаг гэж олон хүн үздэг. Эндээс эдгээр эрх хаанаас үүдэлтэй вэ гэдэг асуулт уялдан гарна. Хүний эрхийн төлөө уриалга улс төрөөс дэмжлэг бага авдаг гэдэг нь их төлөв маргаангүй үнэн юм. Харин гол асуудал нь хүний эрхийн ойлголтын үндэслэлд байх “уян хатан шинж” (зарим хүн “туйлбаргүй шинж” гэж хэлдэг) гэх ойлголттой холбогдоно. Олон сэтгэгч, эрх зүйн онолч хүний эрхийн гоёмсог томъёоллыг дэл сул яриа гэж хардаг. Магадгүй эелдэг бөгөөд өвөрмөц хэллэгийн аятайхан хэлбэр боловч дэл сул яриа л гэсэн үг.

Хүний эрхийн тухай ойлголтын өргөн дэлгэрсэн хэрэглээний утга болон түүний үзэл баримтлалын тогтвортой байдлын

хоорондын эсрэгцэл нь шинэ зүйл бишээ. АНУ-ын 1776 оны Тусгаар тогтнолын тунхаглалд хүн бүрт “бүтээгч эзнээс салгаж болшгүй эрх заяасан” хэмээн нотолсон бол арван гурван жилийн дараа Францын Хүний ба иргэний эрхийн тунхаглалд “Хүмүүс төрөхөөсөө эхлээд эрх чөлөөтэй бөгөөд бүгд эрх тэгш” хэмээн баталгаажуулсан байна. Үүнээс хойш удалгүй Жереми Бентам 1791, 1792 онд бичсэн “Эмх замбараагүйн төөрөгдлүүд” (Францын хүний эрхийн ойлголтын эсрэг чиглэсэн) бүтээлдээ тэр бүх нотолгоонуудыг үгүйсгэв. Жереми Бентам “жам ёсны эрх гэдэг бол ердөө утгагүй зүйл: жам ёсны бөгөөд салшгүй эрх (Америк хэлц), хоосон дэмийрэл, модон хөлтэй дэмийрэл” гэж үзсэн байна. Тэр өвөрмөц өнгө аяс өнөөдөр ч амь бөхтэй бөгөөд өдөр тутмын хэрэгт хүний эрхийн талаар тогтмол хэлж ярьсаар байгаа ч “цаасан дээр буулгасан чарлаан” төдий зүйл гэж үздэг, жам ёсны эрхийн талаарх Бентамын егөөтэй тодорхойлолтыг хэрэглэх хүмүүс байсаар.

Хүний эрхийн тухай санааг үгүйсгэх хандлага ихээхэн өргөн хүрээтэй, олныг хамарсан шинжтэй бөгөөд хүмүүс ямар ч тохиолдолд, хүн болохынхоо хувьд л (болзол нөхцөл заахаасаа илүүтэйгээр, иргэний харьяалал буюу хуулиар олгосон эрх ямба зэрэг тодорхой шалгуур буюу мэргэшил дээр үндэслэн) эдлэх эрх гэх аливаа үзэл бодлын эсрэг чиглэдэг байна. Харин зарим шүүмжлэгч ялгавартай хандахыг санал болгодог: хүний эрхийн ерөнхий ойлголтыг



хүлээн зөвшөөрөх боловч хүлээн зөвшөөрч болох эрхийн жагсаалтаас зарим эрхийн тодорхой бүлгийг хязгаарлах, тодруулбал эдийн засаг, нийгмийн гэх эрхийг, эсвэл нийгмийн хангамжийн эрхийг хязгаарлахыг зөвлөх ажээ. Амин зуулгаар хангагдах буюу эрүүл мэндийн үйлчилгээ авах зэрэг хоёрдугаар үеийн эрхийг харьцангуй сүүл үеэс хүний эрхийн өмнөх үеийн томъёололд нэмж оруулснаар тогтсон хүрээг тэлсэн байна. Энэхүү нэмэлт нь хүний эрхийн талаарх орчин цагийн зохиол бүтээлд тусгалаа хэдийнээ олж, халдашгүй чөлөөтэй байх эрх, улс төрийн эрх чөлөө зэрэг “хүний эрх”-ийн илүү явцуу бүлэгт төвлөрсөн арван наймдугаар зууны үеийн тунхаглалуудын хүрээнээс давж гарчээ. Ийнхүү шинээр олон эрх нэмэгдсэн нь илүү нарийн эсэргүүцлийн бай болж, шүүмжлэгчид тэдгээр эрхийн биелэх боломж хийгээд байж ч болох, байхгүй ч байж болох тодорхой нийгмийн байгууллаас хамааралтай шинжид илүүтэй анхаарал хандуулж байна.

Ихэнх хүний эрхийн зүтгэлтэн иймэрхүү шүүмжлэлт байр суурийг хүлээн зөвшөөрдөггүй. Хүний эрхийг тунхаглан уриалах нь ихэнхдээ түүнийг тайлбарлах гэсэн хүмүүс гэхээсээ илүү ертөнцийг өөрчлөх санаа тээгчдээс гарах хандлагатай байдаг (хачирхалтай нь сонгодог ялгааг алдарт онолч Карл Марксын томъёолсноор хэрэглэх хандлагатай). Дэлхийн өнцөг булан бүрт гарч байгаа зовлон шаналалыг шийдвэрлэх шаардлага тулгамдаж байгаа үед үзэл баримтлалын үндэслэл гаргах гэж санаа зовох эрмэлзэл гаргахгүй байгааг нь ойлгоход тийм ч хэцүү биш. Ийм санаачилгатай хандлагад асар их дарангуйлал буюу гаслан зүдгүүрийг сөрөн зогсох даруйдаа хүний эрхийн үзэл ойлголтыг уриалан дуудах боломжтой байдаг тул онолын орчин нөхцөл тодорхой болтол хүлээх шаардлагагүй

байдгаараа практик үр нөлөөтэй юм. Гэхдээ хүний эрхийн ойлголт нь үндэслэл бүхий нотолгоо гаргаж, оюун санааны найдвартай үндэс суурь тавихыг шаарддаг юм бол үзэл баримтлалын эргэлзээтэй асуудлуудад хангалттай анхаарал хандуулах ёстой болж байна. Нэг талаас хүний эрхийг хүчлэн тулгах, уриалах, нөгөө талаас тэдгээрийн учир зүйтэй үндэслэл болон нухацтай хэрэглээ хоорондын харьцаа, холбоог авч үзэх нь шийдвэрлэх ач холбогдолтой.

Тиймээс ямар нэг онол зайлшгүй хэрэгтэй, мөн цаашилбал шинэ тутам ямар нэг онолыг хамгаалах хэрэг гарна. Энэ нийтлэлийн зорилго чухам үүнд чиглэх бөгөөд сэдвийн хүрээнд хүний эрхийн ерөнхий ойлголтын үндэслэл, мөн хүний эрхийн өргөн ангилалд эдийн засаг, нийгмийн эрх хамаарах боломжийг авч үзэх юм. Тийм онол хэрэгжих боломжтой байхын тулд хүний эрхийг тунхагласнаар юуг нотолдог, тэр нотолгоогоо хэрхэн хамгаалж болох, цаашилбал хүний эрхийн шүтэлцээ, маргашгүй бөгөөд зүй ёсны байх чанарын талаар олон янзын шүүмжийг хэрхэн зүй зохистойгоор авч шийдвэрлэх вэ гэдгийг тодруулах шаардлагатай. Чухам ингэснээр энэ нийтлэлийн зорилго биелнэ.

Гэхдээ судалгаандаа орохын өмнө нэг тодруулга хийх нь зүйтэй. Хүний эрхийн хэлийг заримдаа хүний эрхийн үзэл санаанаас сэдэвлэсэн тодорхой хууль тогтоомжуудад хэрэглэх нь бий. Эдгээр хэдийн хуульчилсан баримт бичгүүдийн илэрхий ойлгомжтой шүүхийн статусыг олж харахад үнэндээ онцын бэрхшээл үгүй юм. Тэдгээрийг (хүний эрхийн хуулиуд буюу бусад нэршлүүд) юу гэж нэрлэдэг байлаа ч гэсэн тэд бусад батлагдсан хууль тогтоомжтой зэрэгцэн оршдог. Хүний эрхийн хуулиуд нь нэгэнт хуульчлагдсан байдаг тул, хүний эрхийн суурь үндэс, маргашгүй чанарын талаарх

өнөөгийн судалгаа шинжилгээ нь эдгээр “хүний эрхийн хуулиуд”-ын эрх зүйн илт статустай ямар нэг шууд холбоо байхгүй юм. Эдгээр хуулиудын тухайд энэ судалгааны учир холбогдол нь тиймэрхүү хуулийг батлан гаргахад хүргэсэн сэдэлд оршдог байсан нь эдгээр шаардлагын хуульчлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал дээр гарч ирдэг юм.

Мэдээж маш олон тооны эрх зүйн акт, конвенц (Хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах тухай Европын Конвенц зэрэг)-ууд хүн төрөлхтний өмнө нь байсан зарим эрхэд итгэх итгэл үнэмшлээс үүдсэн байдаг. Энэ нь АНУ-ын Тусгаар Тогтнолын Тунхаглалын хэм хэмжээ тогтоосон алсын хараатай холбоотойгоор (өмнө нь тэмдэглэж байсанчлан) Хүний эрхийн билл болон АНУ-ын Үндсэн хуулийг баталсантай ч нэгэн адил хамаатай юм. Тийнхүү хуульчлахаас өмнөх хүний эрхийн статус болон үндэс суурийн талаарх хүнд асуултууд үзэл санааны хүрээнд урган гардаг. Бид хууль тогтоомж хүний эрхийг баримтлахад эн тэргүүний буюу зайлшгүй хэрэгтэй эсэхийг шалгаж үзэх шаардлагатай.

## II. Хариулт шаардсан асуултууд

Хүний эрхийн онол дараах асуудалд тухайлан анхаарах ёстой юм. Үүнд:

- 1) Хүний эрхийн тунхаглал ямар илэрхийлэл агуулдаг вэ?
- 2) Хүний эрх юугаараа чухал вэ?
- 3) Хүний эрхээс ямар үүрэг, хариуцлага бий болдог вэ?
- 4) Ямар хэлбэрийн үйл ажиллагаагаар хүний эрхийг хөхиүлэн дэмжиж болох вэ, хууль тогтоомж нь хүний эрхийг хэрэгжүүлэх гол, чухал шаардлагатай арга хэрэгсэл мөн үү?
- 5) Эдийн засаг, нийгмийн эрх (хоёрдугаар үеийн гэх эрхүүд)-ийг хүний эрхэд зохистойгоор хамааруулж болох уу?

- 6) Эцэст нь хүний эрхийн талаарх саналуудыг хэрхэн хамгаалах буюу үгүйсгэж болох вэ? Мөн тэдгээрийн түгээмэл статустай гэсэн нотолгоог ялангуяа соёлын олон төрөл зүйл, маш олон янзын ялгаатай практик үйлчилдэг ертөнцөд хэрхэн үнэлж болох вэ?

Эдгээр асуултад ээлж дараалан хариулна. Гэхдээ энэ нь гэмт хэргийн зохиол биш учраас энэхүү урт, тийм ч ээдрээ багатай гэж хэлэх аргагүй нийтлэлийг уншихад тус болууж хэмээгээд (Хэдийгээр ямарваа тойм хувилбарт хэт хялбарчлал үүсэх эрсдэл байдаг боловч) би боломжит хариултын тойм, бүдүүвчийг өгч болох юм.

1) Хүний эрхийг үндсэндээ ёс зүйн шаардлага хэмээн харж болно. Тэдгээр нь зарчмын хувьд “эрх зүйн”, “анхдагч эрх зүйн”, “туйлын эрх зүйн” дуудлага биш юм. Хүний эрх нь ихэнхдээ хууль тогтоомжийн үүсгэл болдог ч энэ нь хүний эрхийн үндсэн шинж гэхээсээ илүү нэмэлт шинж чанар юм.

2) Хүний эрхийн ач холбогдол нь эдгээр эрхийн сэдвийн голыг бүрэлдүүлж буй эрх чөлөөний ач холбогдолтой уялдаа, холбоотой. Эрх чөлөөний боломжийн шинж, үйл явцын шинжийн аль аль нь хүний эрхэд биелж болно. Хүний эрхийн үндэс суурь болох шалгуур хангахын тулд хамгаалах, дэвшүүлэх эрх чөлөө нь (i) “тусгай ач холбогдлын” болон (ii) “нийгэмд нөлөөлөх нөлөөний” “зарим босго нөхцлийг” хангах ёстой.

3) Хүний эрхээс үүдэн суурь эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, сахин хамгаалахад туслах байр суурь бүхий этгээдүүдэд үйл ажиллагаа явуулах шалтгаан үүсч бий болдог. Үүдэн гарсан үүрэг хариуцлага нь хувь хүний асуудлын холбогдох хүрээг харгалзан үзэх байдлаар голчлон арга хэмжээ авах шалтгаан, тэдгээрийн практик учир

холбогдолд зохистой анхаарал хандуулах үүргийг хамаардаг. Арга хэмжээ авах шаардлага нь нэн тодорхой үүрэг хариуцлагад ч, харьцангуй бүдүүн тойм тодорхойлсон нэн тодорхой бус үүрэг хариуцлагад ч аль алинд нь дэмжлэг болдог байна. Хэдийгээр тэд агуулгын хувьд адилгүй боловч нэн тодорхой бус үүрэг хариуцлага нь нэн тодорхой үүрэг хариуцлагын нэгэн адилаар хүний эрхтэй харилцан хамааралтай байдаг. Ялангуяа, нэн тодорхой бус үүрэг хариуцлагыг хүлээн зөвшөөрөх нь сайн дураараа буян үйлдэх буюу өөрийн хүслээр сайн үйл хийхээс хэтийдсэн хэрэг юм.

4) Хүний эрхийг хэрэгжүүлэх нь хууль тогтоомжоор хязгаарлагдахгүй бөгөөд хүний эрхийн онолыг байнгын баригдмал хууль цаазны загвараар хазаарлаж болохгүй юм. Жишээ нь нийтийн хүндэтгэл хүлээх, ухуулан уриалах нь (зөрчилд хяналт үнэлгээ хийхийн хамтаар) хүний эрхийг хүлээн зөвшөөрснөөс үүдсэн ихэнхдээ нэн тодорхой бус үүрэг хариуцлагын нэг хэсэг байж болно. Мөн зарим хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг бүхэлдээ хуульчлаагүй ч олон нийтийн хэлэлцүүлэг, дэмжлэг, нөлөөллийн зэрэг бусад арга хэрэгслээр илүү хөхиүлэн дэмждэг талтай (Гол санааг нь Мари Волстонекрафт 1792 онд хэвлүүлсэн “Эмэгтэйчүүдийн эрхийг нэхэх нь: Улс төрийн болон ёс суртахууны субъектуудын талаарх шүүмж” бүтээлдээ тусгасан).

5) Хүний эрхийн хүрээнд томоохон, нөлөө үзүүлэхүйц эдийн засаг, нийгмийн эрх чөлөө орно. Институцилээгүйгээс болж эдгээр эрх чөлөө хэрэгжих боломжгүй бол институцийн өргөжилт, шинэтгэл эдгээр эрхийг хүлээн зөвшөөрснөөр үүссэн үүрэг хариуцлагын нэг хэсэг болон хэрэгжиж болно. Институцийн буюу улс төрийн өөрчлөлтөөр хөхиүлэн дэмжиж болох хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх нь одоогоор

хэрэгжихгүй байгаа эдгээр эрхийг эрх биш гэсэн нотолгоо болохгүй.

6) Хүний эрхийн түгээмэл чанар үндэсний хил хязгаараас хамаарахгүй ч оролцоход нээлттэй хэлэлцүүлгийг даван гарах бололцоотой эсэхээс хамаарна. Дэлхийн өнцөг булан бүрийн олон янзын нийгэмд (маш дарангуй дэглэмийг оролцуулаад) зонхилох талын илэрхийлж буй үзэл бодолтой нэгдэх буюу огтлолцох замаар хэт өрөөсгөл хандлагаас тэр бүр зайлсхийдэггүй боловч идэвхтэй харилцан ажиллагааны үйл явцад ялангуяа мэдээллийн чөлөөтэй урсгал, өөр өөр үзэл бодлын талаар хэлэлцэх хязгаарлалтгүй боломж байгаа тохиолдолд олон нийтийн хэлэлцүүлгээр юу гарч ирж болохыг судалж үзэх замаар зайлсхийх боломжтой юм. Адам Смитийн ёс зүйн шүүмжид ёс суртахууны итгэл үнэмшлийг “тодорхой зайнаас” судлах хэрэгтэй гэсэн нь олон нийтийн бодомж эргэцүүлэлд хүний эрх шууд учир холбогдолтой.

### III. Хүний эрх: Ёс зүй ба эрх зүй

Хүний эрхийн тунхаглал ямар баталгаа гаргадаг вэ? Би хүний эрхийн тунхаглалыг ёс зүйн шаардлагуудын ойлгомжтой тодорхойлолт гэж үзэх нь зөв гэсэн санааг илэрхийлсэн билээ. Үүгээр нь тэдгээрийг утилитарист ёс зүй дэх мэдэгдэлтэй харьцуулж болох ч тэдгээрийн тус тусын агуулга илт ялгаатай байна. Хүлээн зөвшөөрөхийг шаардсан ёс зүйн бусад шаардлагын адилаар ёс зүйн үндсэн шаардлагууд нээлттэй, мэдээлэл бүхий шүүмжлэлийг давж гарах хүний эрхийн мэдэгдэл хийх далд утгатай таамаглал бий. Мэдээж мэдээлэлд ч, мөн хол ойрын алинаас ч гарч ирэх маргаанд ч нээлттэй шүүмжлэлт хэлэлцүүлгийн ийм идэвхтэй харилцан ажиллагааны үйл явцыг өдөөн үүсгэх нь энд санал болгож буй хүний эрхийн онолын

гол шинж юм. Энэ нь хүний эрхийн ёс зүйг хамтын бөгөөд хэдийн тогтсон шинжтэй түгээмэл үнэт зүйлсийн хувьд зөвтгөхөөс ч (i) (ойлгоход хялбар “өрөөсгөл бус” үзэл бодол), орчин цагийн ертөнцөд тохирсон тодорхой нэг улс төрийн концепцийн төлөө түгээмэл үнэт зүйлсийг баримтлах аливаа шаардлагаас татгалзахаас ч (ii) (энэ тохиолдолд “өрөөсгөл бус” байхын аливаа шаардлагаас татгалзах) ялгаатай юм.

Ёс зүйн шүүмжийн суурь дэг жаягтай холбогдох эдгээр асуудлыг дараа нь IX хэсэгт (б)-р асуултын хариуг авч үзэх болно. Гэхдээ эхний асуултын хариуд одоо тэмдэглэх санаа бол хүний эрхийн мэдэгдэл нь ёс зүйн нэгдэл бөгөөд энэ санааны талаар нилээд төөрөгдөл гардаг ч тэдгээр нь ялангуяа эрх зүйн хэт санаархал гэж үзсэн зүйлдээ хэнээрхэн дайсагнасан Жереми Бенхамын бий болгосон хуурамч эрх зүйн нотолгоо биш билээ. (Би энэ хэсэгт хожим энд гарч байгаа төөрөгдлийн шинж чанарыг эргэн ярих болно.)

Хүний эрхийн мэдэгдлийн нэг нь тухайн нэг эрхийг томъёололд тодорхойлон баталгаажуулсан холбогдох эрх чөлөө нь чухал болохыг баталсан баталгаа орох бөгөөд мэдээж тэрхүү ач холбогдлоос үндэслэдэг байна. Жишээ нь эрүү шүүлтэд өртөхгүй байх хүний эрх нь бүх хүн эрүү шүүлтээс ангид байх нь чухал гэсэн санаанаас урган гардаг. Цаашилбал, бусад хүн ямар нэг хүнийг эрүү шүүлтээс ангид байлгахын тулд юу хийж болох вэ гэдгээ эргэцүүлэх шаардлага хамаардаг байна. Эрүү шүүлт үйлдэж болзошгүй этгээдийн хувьд энэ шаардлага нь таньж ойлгож, түдгэлзэж, татгалзахад мэдээж нилээн илэн далангүй байна. Уг шаардлага Иммануэл Кантын нэрлэсэн нэн тодорхой үүрэг хариуцлагын илт ойлгомжтой хэлбэрээр илэрдэг. Харин бусдын хувьд (энэ нь эрүү шүүлт тулгагчаас

өөр этгээд байна) харьцангуй бүрхэг бөгөөд нэн тодорхой бус үүрэг хариуцлагын ерөнхий шинжээр (Кантын дэвшүүлсэн өөр нэг үзэл санааг гаргаж) илэрдэг ч мөн л хүлээх хариуцлага байдаг юм.<sup>1</sup> Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх арга замыг авч үзэж, тийнхүү хүн юуг учир зүйтэйгээр хийж болохоо шийдэхийн тулд хэн нэгнийг эрүүдэн шүүхгүй байх тухай төгс тодорхойлсон шаардлагыг яв цав бус тодорхойлсон бөгөөд харьцангуй ерөнхий шинжтэй шалгуураар хүч нэмдэг. Хүний эрх, эрх чөлөө, үүрэг хариуцлагын хоорондын харилцааг IV-VI хэсэгт дэлгэрүүлэн шинжлэх болно.

Хэдийгээр хүний эрхийг хүлээн зөвшөөрөх нь ёс зүйн баталгаа мөн боловч тэд дангаараа үнэлгээ агуулсан тооцоо хийж болох бүрэн төгс зураг төсөл үзүүлэх албагүй юм. Хүний эрхийн гэрээ нь тухайлбал ёс зүйн хувьд баталгаажсанаас үүдэн гарсан үүргийг зохистой анхаарах гуйвшгүй хүчин чармайлтыг агуулдаг. Гэвч эдгээр баталгаатай нийцэх хэдий ч ялангуяа нэн тодорхой бус үүрэг хариуцлагын тохиолдолд (i) хүний эрхэд хандуулах ёстой анхаарлыг хэрхэн тавьбал хамгийн зохистой эсэх, (ii) хүний эрхийн олон төрлийг хооронд нь хэрхэн харьцуулан үнэлэх ёстой тухайд, (iii) хүний эрхийн эрмэлзлийг ёс зүйн анхаарал татаж болох үнэлгээний бусад асуудалтай хэрхэн хослуулах зэрэг нилээд маргаантай асуудал байсаар байна. Хүний эрхийн онолд цаашид ч хэлэлцүүлэг, маргаан, мэтгэлцээн гарч болно. Энд ярьж буй хүний эрхийн ойлголтод хамгийн чухал үүрэгтэй нээлттэй олон нийтийн бодомж эргэцүүллийн хандлага нь хамрах хүрээ, агуулгын талаарх (зарим илэрхий тогтвортой эрхүүд болон

<sup>1</sup> Би өмнөх нийтлэлүүддээ Кантын нэн тодорхой ба нэн тодорхой бус үүрэг хариуцлагын хоорондын ялгааны учир холбогдлыг бүр нилээн шалтгаан дагалдал бүхий тогтолцооны хүрээнд ярьж байсан билээ. “Логик дараалалт үнэлгээ ба практик шалтгаан”, Философийн сэтгүүл 97, 2000 он, 477-502 дахь тал

тогтвортой болгох амаргүй байж болох бусдын нь тодорхойлолтыг оруулаад) зарим маргааныг шийдвэрлэж чадах ч үлдсэн заримыг нь эргэлзээтэй, шийдэлгүй үлдээж магад. Цаашид маргаантай асуудал байгааг хүлээн зөвшөөрөх нь хүний эрхийн онолын хувьд ичиж эрээлхээд байх зүйл биш.

Мэдээж хүний эрхийн практик хэрэглээнд тиймэрхүү маргаан нь ялангуяа хүний эрхийн идэвхтнүүдийн дунд маш нийтлэг, бүхэлдээ хэвшил болсон зүйл юм. Энд юу хэлэх гээд байна вэ гэвэл, маргаан байнга гарах болдог нь хүний эрхийн ач холбогдлыг бууруулалгүйгээр хүний эрхийн туршлага гээч зүйлийн нэг шинж байх төдийгүй тэдгээр нь үндсэн онолыг оролцуулаад хүний эрхийн ерөнхий дэг суруулийн нэг жинхэнэ бүрэлдэхүүн (уг дэг сургуулийн хувьд ичгүүр болдог гэхээсээ илүүтэй) хэсэг болдог. Иймэрхүү эргэцүүллийн хэрэгцээг ор тас үгүйсгэхийн оронд хүний эрхэд (түүнд холбогдох эрх чөлөө, үүрэг хариуцлагад) анхаарал хандуулах хэрэгцээг хүлээн зөвшөөрч байгаа нь хэрэг дээрээ үүнийг хөгжөөдөг байна. Тиймээс хүний эрхийн онол хүний эрхэд бодитой ач холбогдол өгөх, мөн хэрхэн зохистойгоор тийн ач холбогдол өгвөл зохихыг нухацтай бодолцох тухай зарчмаа алдалгүйгээр дотроо үлэмж тооны хувилбар өөрчлөлт байх боломжийг агуулдаг.

Энэ төрлийн хувьсах чанар нь санаа зовох зүйл биш гэхээс гадна материаллаг ёс зүйн сургаалийн бүхий л ерөнхий онолд нийтлэгээр илэрдэг. Мэдээж иймэрхүү өвөрмөц шинжтэй хэрэгцээнд төвлөрсөн ёс зүйн хүрээнд тааралдаж болох ч тэрхүү ёс зүйн томоохон дэг сургуулийн шинжийг ихэнхдээ хүлээн зөвшөөрөхгүй талдаа байдаг юм. Хэрэгцээнд суурилсан бодомжийн хувьд хувилбар өөрчлөлтүүд нь хэрэгцээг тайлбарлаж болох өөр өөр арга замуудаас

төдийгүй (тааламж, хүслээ гүйцээх, сонголт биелэх зэргээр) хэрэглээний нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ялгаа, төрлөөс ч гарч ирж болно (Аристотель, Жон Стюарт Милл хоёр хүлээн зөвшөөрсөн). Тэд мөн ашиг тусыг хэрхэн хэрэглэж буй аргын өвөрмөц шинжээс нэмэх үйлдлээр л, эсвэл үржих үйлдлээс (тохиромжтой журамд оруулан тохируулсны дараа) эсвэл хэрэгцээний функцийн хотгор хувьсагчийн нэмэх үйлдлээс хэрэгцээнд суурилсан үнэлгээний дэг сургуулийн хүрээнд илэрч болох бөгөөд эдгээрийн аль алийг нь гарган тавьж, ярилцсан. Цаашилбал хүмүүсийн хоорондын харилцаанд ашиг тусыг хөндсөн харьцуулалтын арга нь өөрөө хэрэгцээний тооцоо гаргах өөр журам хэрэглэх бололцоо олгож, “заримдаг харьцуулалт”-ын тодорхой нэг ангилал дотор зөвшөөрөгдөх хувьсагчийг багтааж болдог. Хэрэгцээнд суурилсан эргэцүүлэл болон хувилбарт прагматик аргуудыг хэрэглэх өөр өөр арга замууд байгаа нь ашиг тус төвтэй ёс зүйн ерөнхий хандлагыг үгүйсгэж, хэрэглээнээс гаргахгүй. Мөн түүний адилаар хүний эрхийн ёс зүй дотоод хувиралдаа уусан алга болохгүй.

Тиймээс хүний эрхийн томъёолол болон прагматик мэдэгдлүүдийн хоорондын төстэй байдал нилээд нэвтэрхий чанартай. Харин орчин цагийн утилитаризмыг үндэслэгч Жереми Бентам жам ёсны эрхийн тухай болон ялангуяа хүний эрхийн тухай сонгодог дайралтдаа тэр холбоог мартчихсан юм. Бентам хүний эрхийн тунхаглал болон бодитоор хуульчилсан эрх хоёрын хооронд зохистой харьцуулалт болно гэж үзсэн. Тэр хүний эрхийн тунхаглал нь хуульчилсан эрх шиг хууль зүйн статусгүй гэж тодорхойлжээ. Эрх, тэр дундаа бодит эрх бол эрх зүйн хүүхэд. Жинхэнэ эрх зүйгээс л жинхэнэ эрх гарна. Харин төсөөллийн эрх зүйгээс буюу “жам ёсны эрх зүйгээс” “төсөөллийн л эрх”



үүснэ.

Бентам хүний жам ёсны эрхийг үгүйсгэж байгаа нь эрх нэр томъёог тодорхой эрх зүйн тайлбарт харсан учир давуу тал олгох хэрэглээний гоёмсог нэршлээс шалтгаалсан байна. Гэхдээ хүний эрх ёс зүйн бодитой шаардлага байсаар буй цагт түүнд хууль зүйн болон институцийн хүчин чадал байхгүй гэсэн утга ойлгомжтой боловч хүний дэг сургуульд тун ч хамаарах зүйл биш юм. Тохиромжтой харьцуулалтыг дараах ухагдахууны хооронд хийх нь мэдээж. Үүнд:

1) Хэрэгцээнд суурилсан ёс зүй (Бентам өөрөө тэргүүлдэг асан). Энд хүний эрх, хүний эрх чөлөөн дэх биш, хэрэгцээн дэх ёс зүйн дотоод ач холбогдлыг олж хардаг (Тиймээс утилитарист тогтолцоон дахь хүний эрх, эрх чөлөөний гүйцэтгэх үүрэг бүхэлдээ туслах шинжтэй).

2) Хүний эрхийн суурь ач холбогдлыг харгалзан үзэх ёс зүй (“Хүний эрхийн” талыг баримтлагчдын адилаар). Энэ нь хүний эрхийн үндсэн ач холбогдлын нарийн тодорхойлолт болон түүгээр үүсгэсэн үүрэгтэй холбогдоно.

Утилитарист ёс зүйн эргэцүүлэл тодорхой хүмүүсийн хэрэгцээг юу хийх шаардлагатай болохоо шийдэхдээ харгалзан үзэх ёстой гэсэн хэлбэрээр илэрсний адилаар хүний эрхийн хандлага нь хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхэд ёс зүйн зөвшөөрөл олгохыг шаарддаг (Зөвшөөрлийн илрэх хэлбэр, мэдээллийн үндсийг дараагийн хоёр бүлэгт дэлгэрэнгүй өгүүлнэ). Холбогдох харьцуулалт нь хуульд буулгасан эрхийн эрх зүйн хүчин чадлыг эрхийг хүлээн зөвшөөрснөөр үүсдэг эрх зүйн үндэслэл (хууль буюу хуулийн эрх зүйн тайлбаргүйгээр) байхгүй байхаас ялгахад оршихгүй гэсэн энэхүү харшуулалтад оршино. Мэдээж Бентамыг 1792, 1792 онд “хүний эрхийг” үгүйсгээд завгүй байх зуур

1791-1792 онд хэвлэгдсэн Томас Пэйний “Хүний эрх”, Мари Волстонекрафтын “Эмэгтэйчүүдийн эрхийг нэхэх нь: Улс төрийн болон ёс суртахууны субъектуудын талаарх шүүмж”-д эрхийн ёс зүйн тайлбарын хамрах хүрээг авч үзэж байлаа (аль нь ч Бентамын сонирхлыг татаагүй бололтой).

Хүний эрхийн ёс зүйн ойлголт дан ганц эрх зүйн шаардлага гэж үзэхийн эсрэг байгаад зогсохгүй (Бентамын үзсэнээр эрх зүйн хэт санаархал гэж авч үзэхийн эсрэг), мөн цаашлан хүний эрхийг хуулийн суурь нөхцөл буюу “хуулийн бараа бологч” мэт үздэг хүний эрхэд чиглэсэн хууль төвтэй хандлагаас ялгарна. Ёс зүйн болон хууль зүйн эрх нь мэдээж үндэс сэдлийн холбоотой. “Жам ёсны эрх гэж бий юу?” хэмээх нэрд гарсан өгүүлэлдээ Херберт Харт хүмүүс “эрх зүйн тогтолцоонд оруулахыг дэмжих болсон үедээ л ёс суртахууныхаа эрхийн талаар ярьдаг” гэсэн нь бий. Тэр мөн эрхийн тухай ойлголт нь “нэг хүний эрх чөлөө нөгөө хүнийхээр хэзээ хязгаарлагдаж болох, цаашилбал ямар үйл ажиллагаа албадлагын шинжтэй эрх зүйн дүрэм болохыг тогтооход чиглэсэн ёс суртахууны зарчмын салбарт хамаарна” хэмээн нэмсэн байна. Бентам эрхийг хуулийн хүүхэд гэж үзсэн байхад Хартын бодлоор зарим жам ёсны эрх хуулийн эцэг эх болж байна. Тэдгээр нь тодорхой хуулийн эхлэл, сэдэл болдог. Хэдийгээр Харт энэ өгүүлэлд хөндсөн ямар нэг эрхэд хамааруулаагүй боловч жам ёсны эрх хуулийн сэдлийн үүрэг гүйцэтгэх тухай бодомжийг хүний эрхийн ойлголтод ч холбогдуулан харж болох юм.

Үнэн хэрэгтээ ёс суртахууны эрхийн тухай ойлголт нь шинэ хуулийн суурь болж чаддаг буюу практикт их төлөв болсоор ирсний тухайд эргэлзэх зүйл бага. Түүнийг байнга ийм аргаар ашиглаж ирсэн бөгөөд энэ мэдээж хүний эрхийн тун чухал хэрэглээ



юм. Жишээ нь АНУ-ын Тусгаар тогтнолын тунхаглалд орж, дараа нь Эрхийн Биллд туссан нь дэлхийн олон оронд хууль тогтоох ажиллагааны түүхэнд хэвшиж туулсан замнал билээ. Хууль гарах сэдэл өгөх нь гарцаагүй хүний эрхийн ёс зүйн хүчийг бүтээлчээр хөдөлгөж ирсэн нэг арга зам мөн юм.

Гэхдээ тийм холбоо байгаа гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухам юу “хуулийн албадлагын тохиромжтой субъект болох” ёстойг тодорхойлохын тулд л хүний эрхийн учир холбогдол оршиж байгаа байдлаар авч үзэхтэй адилгүй юм. Хүний эрхйн тухай ойлголтыг хэд хэдэн өөр байдлаар хэрэглэж болох буюу тэгж хэрэглэдгийг харж үзэх нь чухал. Мэдээж хүний эрхийг ёс суртахууны хэрэгцээ, эсвэл ёс суртахууны эрх гэж (Хартын хэлцийг ашиглахад) үзвэл бидэнд эдгээр хэрэгцээг хөхиүлэн дэмжихийн тулд хэрэглэх өөр өөр арга замын талаар бодолцоо өргөн хараатай байх шалтгаан бий болно. (Энэ асуултыг VII бүлэгт ярих болно) Тиймээс хүний эрхэд ахиц гаргах, түүнийг хэрэгжүүлэх арга зам нь шинэ хууль гаргах төдий хязгаарт багтахгүй юм (хууль тогтоомж гаргах нь заримдаа дэвшил гарах зөв арга болдог хэдий ч). Жишээ нь Хүний эрхийн Хяналт, Эмнести Интернейшнл, Оксфам, эсвэл Хил Хязгааргүй Эмч нар гэх мэт байгууллагын үзүүлсэн мониторингийн болон бусад төрлийн дэмжлэг нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн бодит хамрах хүрээг тэлэхэд ихээхэн тус болж чадна. Янз бүрийн нөхцөлд хууль тогтоомжийн оролцоо байхгүй ч байх нь бий.

#### IV. Эрх, эрх чөлөө, нийгмийн нөлөө

Хүний эрх яагаад чухал вэ? Хүний эрхийн тунхаглал нь (өмнөх хэсэгт дурдсанаар) хүний эрхийн томъёололд нягт холбогдсон эрх чөлөөний ач холбогдолд

зохих ёсоор анхаарах ёстой гэсэн ёс зүйн шаардлага тул эхлэх цэг нь хүн төрөлхтний эрх чөлөөний үнэ цэнэ байж таарна. Эрх гэдэгт шаардлага хамаарч байхад (тухайлан хэлбэл өөрчлөлт хийх байр сууринд байгаа хүмүүсийн тухай шаардлага), эрх чөлөө бол эсрэгээрээ хүмүүсийн нөхцөл байдлыг эн тэргүүнд тодорхойлох өвөрмөц шинж гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Хэрэгцээн дээр гэхээсээ илүү анхаарал төвлөрөх шаардлагатай хүний зохистой нөхцөл гэдгээр эрх чөлөөний ач холбогдлоос эхэлж, бид өөрсдийн эрх, эрх чөлөөг тэмдэглэх төдийгүй, зөвхөн таашаал авч байгаа болон хүслээ биелүүлж байгаадаа (утилитарист үзлийн дагуу) биш, бусдын эрх чөлөөг анхаарч байгаагийнхаа төлөө сэдэл шалтгаантай болдог. Хэрэгцээг ёс зүйн үнэлгээний үндэс суурь гэж сонгосон Бентамын санаа нь эрх чөлөөг анхаарах шалтгаантай авцалдахгүй байж болно. Өөр хаа нэгтээ би эдгээр шалтгаанууд яагаад жинтэй байдаг, яаж эрх чөлөөнд анхаарал хандуулснаар таашаал авах, хүслээ биелүүлэхийн тулд зөвхөн хэрэгцээнд төвлөрөхийн гол аюулаас зайлсхийж болох тухай ярьсан. Жишээ нь байнгын ядуу зүдүү байдаг боловч нөхцөл байдлын үр дүнд бяцхан энэрэл нигүүлсэл болон хүслээ “бодит хувь хэмжээгээр” хязгаарласнаар (таашаал авах, хүслээ биелүүлэх тусгай хэмжүүрээр тухайлан эрхээ хязгаарлуулж байгаа мэт) сэтгэл ханадаг хүмүүсийн эрх зөрчигдөхийг үл хайхарснаас үүдсэн үнэлгээний гажуунаас болж утилитарист тооцоо үр дүнгүй болж болно.

VI хэсэгт өгүүлэх эрхтэй холбоотой үүрэг хариуцлагын адармаатай асуудал руу орохын өмнө эрх болон эрх чөлөөний хоорондын холбоог бага сага шинжлэн үзэх нь зүйтэй гэж санаад би энэ бүлгийн үлдсэн хэсгийг болон V бүлгийг тухайлан

зориулж байна. Эрх чөлөө бол ач холбогдол болон нийгмийн дэмжлэг авах боломж зэргээрээ харилцан адилгүй байдаг. Эрх чөлөөг хүний эрхийг үнэлэх тогтолцооны нэг хэсэг гэж тоолох юм бол эрх чөлөөнд ахиц дэвшил гаргахын тулд яг юу хийх вэ гэдгээ шийдэхдээ нухацтай хандахыг бусад хүмүүсээс шаардахад энэ нь хангалттай чухал байх ёстой. Мөн бусдаас тийнхүү сонирхол татах байдлаар бодит, материаллаг ялгаа харагдахуйц үнэмшил төрүүлэх шаардлагатай юм.

Эрх чөлөөний хувьд хүний эрхийн олон талын, хүмүүс хоорондын хүрээнд тодорхойлох (i) ач холбогдол, (ii) нийгэмд үзүүлэх нөлөөний босго нөхцлүүд байх ёстой. Хүний эрхийн ойлголт нь, өмнө миний хэлсэнчлэн, олон нийтийн хэлэлцүүлэг, оролцоо шаардлагаас хайх хариулт нь тодорхой нэг хүний ямар нэг эрхэд ёс зүйн ач холбогдол байна уу гэдгээс төдийгүй (уг нөхцөл нь хялбархан нийцэхээр), мөн түүний ач холбогдол, нийгмийн нөлөө нь нийгмийн анхаарал хандвал зохих хүний эрхийн шалгуур хангах босго нөхцөл болж байгаа эсэх тухай байх юм.

Босго нөхцөл олон янзын шалтгаанаар тодорхой нэг эрх чөлөөг хүний эрхийн жинхэнэ судлах сэдэв болоход саад болж болно. Үлгэрлэвэл заримдаа ач холбогдол нь дараах дөрвөн эрх чөлөөний төрөлд бүгдэд нь хамаарч байх ёстой гэж маргах нь тийм ч хэцүү биш. Үүнд:

- (1) Халдлагаас ангид байх эрх чөлөө,
- (2) Эрүү мэндийн ноцтой асуудлаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх чөлөө,
- (3) Үзэж чаддаггүй хөршөөсөө байн байн дуудлага хүлээн авахгүй байх эрх чөлөө,
- (4) Тайван амгалан байх эрх чөлөө.

Гэтэл эдгээр нь дөрвүүлээ ямар нэг

байдлаар чухал байж болох ч яг эхнийх нь (халдлагаас ангид байх эрх чөлөө), хоёр дахь нь (шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрх чөлөө) хүний эрхийн сэдэв мөн, харин гурав дахь нь (Үзэж чаддаггүй хөршөөсөө дуудлага авахгүй байх эрх чөлөө) ерөнхийдөө хүний эрх байх нийгмийн ач холбогдлын босгыг давахаар чухал биш гэж үзэхэд огт үнэмшилгүй байна. Мөн дөрөв дэх нь хэдий хүний хувьд магадгүй онцгой чухал байгаа ч хүний эрхийн сэдэв болоход зохимжтой гэхэд хэтэрхий дотогшоо хандсан буюу бусдаас нөлөөлнө гэхэд дэндүү хүндрэлтэй байна. Тайван амгалан байх эрхийг үүнээс хасаж байгаа нь тайван амгалан байхын болон тийм байдалд хүрэх боломжтой байхын ач холбогдлын эсрэг шүүмжлэлтэй төдийгүй, нийгмийн дэмжлэгийн ачаар үүнийг баталгаажуулахад хэцүү гэдэгтэй ч мөн холбогдоно.

Босго нөхцлүүд болон тэдгээрийг хэрхэн ашиглах тухай, тэр дундаа эрх чөлөөний хэлбэрийн тодорхой тохиолдол босго нөхцөлд нийцэж байгаа тухай маргавал үр өгөөжтэй байж болох юм. II, III бүлэгт товч өгүүлсэнчлэн тиймэрхүү хэлэлцүүлэг нь хүний эрхийн дэг жаягийн нэг хэсэг юм. Хэрэгцээ ач холбогдол болон нийгмийн нөлөөлөх чанартай хоёулангтай нь холбогдох босго нөхцлүүдэд хийх дүн шинжилгээ хүний эрхийн мэдлэгийн салбарт чухал байр суурь эзлэх нь гарцаагүй.

## V. Үйл явц, боломж, чадамж

Одоо харин эрх чөлөө болон түүний олон янзын шинжийн агуулгыг авч үзье. Хаа нэгтэй би “боломж”, “үйл явц” хоёр бол аль аль нь талархал хүлээх ёстойн хувьд хүндэтгэл шаардсан эрх чөлөөний хоёр тал мөн гэсэн санагдана. Материаллаг боломж болон үйл явцын эрх чөлөөний аль алиных нь тусдаа холбоог жишээ татвал ойлгомжтой байж болох юм.

Насанд хүрсэн Рима гэх нэг хүн байжээ гэж бодъё. Рима орой гадагшаа гарахаар шийджээ. Энд ярьж байгаа асуудлуудад тийм ч ач холбогдолтой биш (гэвч энэ яриаг илүү цогц болгох юм) зарим зүйлсийг ойлгомжтой болгохын тулд, түүний гадагшаа гарч байгаад нь ямар нэг аюулгүй байдлын эрсдэл байхгүй бөгөөд тэр энэ шийдвэрээ нухацтайгаар авч үзээд гадагшаа гарах нь ухаалаг бөгөөд хүсүүштэй зүйл гэж дүгнэсэн хэмээн төсөөлье. Одоо хэрэв нийгмийн захиргаадальтын шинжтэй хамгаалагчид түүнийг оройн цагаар гадагш гарч болохгүй гэж үзвэл, мөн түүнийг ямар ч аргаар хамаагүй гэрт нь үлдээх гэж хүчилвэл энэ эрх чөлөөг хөндөж байгаа зөрчлийн үзүүлж байгаа аюул заналыг тунгааж үз. Энэ эрхийн зөрчилд ярьж байгаа хоёр онцлог асуудал гаргахын тулд захиргаадагч этгээд түүнийг заавал гаргахаар (Та өнөө оройн хувьд битгий эргэж ир: даруй биелүүл) шийджээ гэж үзье. Хэдий Рима ямар ч тохиолдолд хийх байсан зүйлээ л хийх болсон ч энд илэрхий эрх чөлөөг нь зөрчсөн байх бөгөөд “чөлөөтэй гарах”, “албадлагад орж гарах” гэсэн хоёр хувилбарыг харьцуулахад хялбархан харагдаж байна. Сүүлийн хувилбарт түүнийг албадсан үйлдэл хийснээрээ Римагийн эрх чөлөөний үйл явцын талыг шууд зөрчсөн байна (Хэдий түүний өөрийнхөө хүслээр хийж болох үйлдэл байсан ч).

Боломжийн үнэмшилтэй тайлбар олон янзаар илэрч болохоос үүнд мөн гадна чөлөөт сонголтыг үнэлэх ч хамаарч болох тул боломжийн талд ч бас нөлөөлж болно. Гэхдээ хэрэв тэр өөр хэн нэгний сонгосон зүйлийг хийх болоод зогсохгүй хэрэг дээрээ тэр өөрөө бол огт хийхийг хүсэхгүй байсан зүйлээ хийх болсон бол боломжийн талыг зөрчсөн нь илүү бодитой бөгөөд илэрхий болж байна. “Хүчинд автан гарах болсон” (боломж олгосон бол өөрөө гарах байсан

ч), мөн “гэртээ өөр хүний гутлыг өнгөлөх болсон” (дургүй зүйл нь) хоёрын хооронд харьцуулбал ялгааг нь харах бөгөөд энэ нь гарцаа байхгүй үйл явцын гэхээсээ илүү боломжийн тал юм. Гэртээ үлдэж, хүний гутал өнгөлснөөр Рима сонголт хийх эрх чөлөөгүйгээр албадлагад орсноор, хийхийг хүсээгүй зүйлээ хийх болсноор гэсэн хоёр янзаар эрх чөлөөгөө алдаж байна.<sup>2</sup>

Үйл явц, боломж аль аль нь хүний эрхийг тодорхойлж байна. “Хуульд заасан арга хэмжээ”-г авалгүйгээр, мөн зохих шүүн таслах ажиллагаагүйгээр (шударга шүүхээс гарах үр дүн нь ямар байх байсан ч хамаагүй) хорих нь хүний эрхийн асуудал болж болно. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах буюу эсвэл халдлагад өртөх аюулаас ангид аж төрөх боломжийг өгөхгүй байх нь (эдгээр боломжийг бодитоор хэрэгжүүлэх үйл явцаас хэтэрч) мөн хүний эрхийн асуудал мөн.

Эрх чөлөөний боломжийн хувьд чадамжийн (энэ нь хүний үйл ажиллагаануудын үнэ цэнэтэй нэгдэлд хүрэх боломж: хүн юу хийж, эсвэл юу байж чадах эсэх) тухай ойлголтоос нэгэн ашигтай хандлага олж авч болно.<sup>3</sup> Үүний тусламжтай бид хүний юу хийхийг буюу байхыг хүсч байгаа болон хүсч байгаа зүйлдээ хүрэхийн тулд хэрэглэх арга замын хооронд зохистойгоор ялгаж чаддаг. Ялангуяа юу хийх, хэн байх гэдэгт нь анхаарлаа хандуулснаар чадамжид чиглэсэн хандлага зарим хууль зүйн онолуудад тааралддаг (жишээ нь Ролзын Difference Principle) хэрэглэгдэхүүнд хэт анхаарах (орлого, анхдагч баялаг зэрэг) шинжтэй сөргөлддөг юм. Чадамжийн хандлага нь хоёр хүн яг адилхан төрлийн

<sup>2</sup> Эрх чөлөөний боломжийн тал болон үйл явцын талын илүү цогц шинжүүдийг Arrow Lectures-ийн (Эрх чөлөө ба нийгмийн сонголт) Rationality and Freedom 20-22 дугаар эссендээ өгүүлсэн.

<sup>3</sup> Чадамжийн тухай ойлголтын хувьд Tanner Lectures on Human Values, I дэвтэрт хэвлэгдсэн миний “Equality of What”-ыг үзнэ үү (Cambridge: Cambridge University Press and Salt Lake City).

хэрэглэгдэхүүнтэй байсан ч маш ялгаатай, харилцан адилгүй боломжтой байж болно гэсэн үнэнийг иш татаж болно. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүн, яг адилхан орлого болон баялагтайгаар эрүүл саруул хүний хийж чадахаас тун зөрүүтэй зүйл хийж чадах юм. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие махбодын хувьд бүрэн бүтэн хүнтэй яг адил хэрэглэгдэхүүнтэйгээр тэнцүү хэмжээнд үнэлж болохгүй юм. Чадамжийн төлөв байдал нь хүнд байгаа хэрэглэгдэхүүнд биш, харин түүнд ямар жинхэнэ боломж байна вэ гэдэгт төвлөрдөг. Бүр нарийн ярьвал чадамжийн өнцгөөр бид нэг талаас хэрэглэгдэхүүн, нөгөө талаас жинхэнэ боломжийн хоорондын холбоон дахь параметрийн хувьсах чанарыг олж харах боломжтой болдог.<sup>4</sup>

Чадамжийн чиг баримжаа нь мөн хувь хүний давуу тал болон тулгарах бэрхшээлийг нээлттэй үнэлгээний шүүмж хийх хэрэгцээг илрүүлэхэд тусладаг. Учир нь өөр өөр үйл ажиллагааг хоорондох нь холбоонд нь үнэлж, цэгнэх шаардлагатай байдгаас гадна үйл ажиллагаануудын өөр өөр нийлэмжийн боломжийг мөн үнэлэх хэрэгтэй болдог байна. Нилээн өргөн хүрээтэй тайлбарласан чадамжийн өнцгийн баялаг шинжид түүний нийгмийн шийдэл гаргахад нээлттэй үнэлгээний шүүмж хийх шаардлагыг байнга гаргаж тавьдаг нь хамаарах бөгөөд үүгээрээ олон нийтийн бодомж эргэцүүллийн ач холбогдолтой яг тохирч байгаа юм. Нээлттэй үнэлгээний энэхүү илэн далангүй байдал нь үнэлэх дасгалуудыг зарим механик шинжтэйн дээр тодорхойлолтын хувьд ойлгомжтой бус дүрмүүдэд бүрхэгдүүлдэгээс ялгаатай (жишээ нь зах зээлийн үнэлгээтэй орлогыг хувийн ашгийн үл хувьсах стандарт гэж үзсэнээр адилхан тодорхойлсон зах

зээлийн үнүүдэд далдуур адил зэрэглэлийн ач холбогдол өгнө).

Гэхдээ “эрх чөлөө” гэх бодит боломжийн тухай тодорхойлолтыг (аль нэг хэлбэрээр аж төрөх) нилээд ноцтой шүүмжилдэг тал бий бөгөөд үүгээр эрх чөлөөний тухай санаа хэт хамарсан шинжтэй болж байна гэж маргадаг. Жишээ нь, Сюзан Окин миний бичсэн “Хөгжил бол эрх чөлөө”-д сэнхрүүлсэн, эелдэг шүүмж өгөхдөө намайг “эрх чөлөөний санааг хэт дэлгэрүүлэх” хандлагатай байна гэх санаа илэрхийлжээ. Тэр “хүн төрөлхтний үнэ цэнийн төвд байх бүх зүйлийг хэлээд байгаа мэт санагдтал энэ нэр томъёог дэлгэлгүйгээр, хүний зарим үйлдлийг, эсвэл эрүүл мэнд, амин зуулга зэрэг хэрэгцээ шаардлагаа хангахыг эрх чөлөө гэж ойлгох хэцүү” гэжээ. (292 дахь тал)

Эрх чөлөөний тухай ойлголтыг хэрхэн дэлгэрэнгүй хэрэглэх талаарх маргаанд хүрээ бий. Гэвч Окины сөрөг тайлбар дахь тодорхой жишээ нь миний санахад чадамжийн тухай ойлголтод суурилсан эрх чөлөөний ойлголтын талаарх эндүү тайлбар дээр үндэслэсэн байна. Үйлдлийг (жишээ нь эрүүл чийрэг байх, хоол тэжээл сайн авах зэрэг) ямар нэг эрх чөлөөний хэлбэр гэж үзэх нь зөв гэж огт хэлээгүй. Харин эрх чөлөө нь чадамжийн хэлбэрээр үйлдлүүдийн нийлэмжийг биелүүлэх гэсэн боломжид (Жишээ нь тухайлан энэ тохиолдолд цатгалан, эрүүл байх боломж) төвлөрч байгаа юм. Энэ боломжийг хүн яаж ашиглах нь өөрийнх нь хэрэг билээ. Чадамж нь хүн бодит эрх чөлөөтэйгөөр сонгож хийх үйлдлүүдийн хувилбар нийлэмжийг тусгадаг.

Тиймээс энэ нь цатгалан буюу эрүүл чийрэг байхыг эрх чөлөө гэж үзнэ гэсэн үг биш. Чадамж нь нэг төрлийн эрх чөлөө болохын хувьд хүн үнэндээ юу хийхээр сонгосноос хамаагүй, нийлмэл үйлдэл хийж (цатгалан байх зэрэг) чадаж байгаа

<sup>4</sup> Хууль зүйн онолын энэ хувьсах чанарын ач холбогдолыг Philosophy and Public Affairs 19 (1990) дээр 111-121 дүгээр талд гарсан "Justice: Means versus Freedoms"-д авч үзсэн.

цар хүрээнд нь л хамаарна. Махатма Ганди Энэтхэг дэх Британийн бодлогыг эсэргүүцэн мацаг барих замыг сонгохдоо, энэ цагталан байх боломжийг ашиглаагүй билээ. Тэжээлээр сайн хангагдах үйл ажиллагааны хувьд мацаг барьж байгаа Ганди өлсгөлөнд нэрвэгдсэн хүнээс ялгарах юмгүй байсан боловч тэдэнд байсан эрх чөлөө, боломж хувьд тун чиг өөр байлаа. Ямар нэг зүйлтэй байх эрх чөлөөг яг тухайн юмтай байх гэдэг ойлголтоос ялган салгаж болно. Хүнд чухам юу байгаа нь биш, харин юмтай байх эрх чөлөөтэй байх нь шударга ёсны онолд холбоотой гэж би хэлэх гээд байгаа юм. Иймэрхүү санааг хүний эрхийн онолд материаллаг эрх чөлөөний учир холбогдлын тухайд хэлж болно.

Дэлхий дээрх аймшигтай зовлон шаналалын олонх нь тэрхүү шаналаас зайлсхийх эрх чөлөө дутсанаас болсон мэт санагддаг нь (түүхийн зохиолууд дээр ядуурлын талаарх сонгодог асуудал бодог залхуу байх сонголт хийх зэрэг сонголт буюу шийдвэр гаргах гэсээсээ илүү) эрх чөлөөний гүйцэтгэх үүргийг онцлох нэг чухал шалтгаан юм. Чухам энэ л Марксыг “хүнийг нөхцөл байдал, боломж завшаан ноёлдогийг, нөхцөл байдал, боломж завшааныг хүн ноёлдог ёсоор” солих шаардлагатай гэж маргахад хүргэсэн байна. Эрх чөлөөний талаарх ерөнхий ойлголт нь янз бүрийн олон бүрэлдэхүүн хэсгийнхээ хамт хэвшсэн нийгмийн сонголтын онолтой ерөнхийдөө, шударга ёсны онолтой тусгайлан холбоотой мэт санагддаг. Энд хэлэх гэсэн санаа бол хүний эрхийн хэвшсэн сууринд хүчтэйгээр тогтож болно.

Өөр нэг төрлийн жишээ татахын тулд Баруун Европ буюу АНУ руу гарч байгаа цагаачдын орхиж гарсан улс орноосоо өвөг дээдсийнхээ соёл, зан заншил, аж төрөх ёсыг хадгалах эрх чөлөөг авч үзье.

Ямар нэг юм хийх ба тухайн зүйлийг хийж чадахаар чөлөөтэй байх хоёрын хоорондын ялгааг гаргалгүйгээр энэ цогц ээдрээтэй асуудлыг оновчтой үнэлэх боломжгүй билээ. Цагаачдын өвөг дээдсийнхээ аж төрөх ёсыг хэсэгчлэн авч үлдэх эрх чөлөөтэй байхын тулд нэг хүчтэй ойлголтыг гаргаж ирж болох ч үүнийг өөрөө шийдсэн эсэхээс шалтгаалахгүйгээр өвөг дээдсийнхээ аж төрөх ёсыг авч явах ёстой гэсэн санаа гэж үзэж таарахгүй. Энэ санаан дахь гол асуудал нь өвөг дээдсийнхээ зан заншлыг авч явах боломж гэх мэтчилэн хэрхэн амьдрах вэ гэдгээ өөрөө шийдэх эрх чөлөө бөгөөд тухайн эмэгтэйн тэдгээр зан заншлыг тухайлан хэрэглэх эсэхээс нь хамаараад түүний хийх олон янзын сонголтыг харгалзалгүйгээр маргааны асуудал болгож чадахгүй юм. Чадамжийн ач холбогдол боломжийн тусгал болохын хувьд энэ ялгаанд энэ өвөрмөц онцлогт гол байр суурьтай. Би өмнөх хэсэгт чадамжаас үүдэлтэй баримжаа хүний эрхийн онолын хувьд ямар хувь нэмэр оруулж болохыг ярьсан бол одоо түүний гүйцэтгэж чадахгүй зүйлийн тухай авч үзье. Чадамжийн тухай ойлголт нь эрх чөлөөний боломжийн талыг үнэлэхэд ихээхэн ашиг тустай боловч эрх чөлөөний үйл явцын талыг үнэлэхэд тийм ч оновчтой байж чадахгүй болов уу. Учир нь чадамж бол хувь хүний давуу талын шинж бөгөөд бидэнд яригдаж байгаа үйл явцын шударга буюу тэнцвэртэй байдлын талаарх, эсвэл тэнцвэрийг хангаж болох үйл явцыг гарган ирж, хэрэглэх иргэдийн эрх чөлөөний талаар хангалттай мэдээлэл өгч чадахгүй юм.

Харах өнцгийн эрс ялгаатай байдлыг зарим талаар хатуу ширүүн ч гэж болох жишээ татаж тодруулъя. Одоо бол тэгш хэмнэлийн арчилгаа сувилгаатай нөхцөлд эмэгтэй хүн эр хүнээс илүү урт наслах хандлагатай байдаг нь нэгэнт тодорхой



болсон зүйл. Хүн зөвхөн чадамжид анхаараад бусдыг нь эс хайхарвал, ялангуяа урт наслах адил чадамж эрх тэгш байх ёстой гэх аваас байгалиас эрчүүдэд заяасан энэ дутуу чанарыг нөхөхийн тулд эрчүүдэд эмнэлгийн сувилгаа илүү үзүүлэх тухай үзэл санаа гарч ирэх байлаа. Эрүүл мэндийн яг адил нөхцөл байдалд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд эрчүүдийнхээс бага анхаарал хандуулах нь үйл явцын тэнцвэрийн тухай чухал шаардлагыг илт зөрчсөн хэрэг болох бөгөөд ийм тохиолдолд үйл явцын эрх чөлөөнд тэнцвэрийг хангах шаардлага эрх чөлөөний боломжийн талд нэг талыг (ялангуяа чадамж тэг байх шаардлагыг) барьж анхаарахаас давуу талтай байх болно гэж үзэх нь зохистой билээ. Хүмүүсийн бодит боломжийг үнэлэхэд чадамжийн өнцгийн учир холбогдлыг онцлон үзэх нь (ялангуяа ашиг орлого, үндсэн хэрэгцээний хэрэглэгдэхүүн, буюу нөөц хөрөнгө зэрэгт анхаардаг боломжит хандлагатай харьцуулбал) чухал боловч энэ нь ямар нэг байдлаар хүний эрхийн онолд, эс бөгөөс тухайн тохиолдолд шударга ёсны онолд эрх чөлөөний үйл явцын талын хам учир холбогдлыг харахад саад болохгүй юм.

Асуудалтай холбогдуулан завшааныг ашиглан би шударга ёсны онол дахь чадамжийн өнцгийн эзлэх байр суурийн талаарх ташаа ойлголтод залруулга хийх нь зүйтэй байх. Холбогдох үйл явцын шударга байдал болон хүмүүст ашиглаж болох материаллаг боломжийн тэнцвэртэй байдал, үр өгөөжид аль алинд нь шударга ёсны онол буюу илүү ерөнхийлвөл адил тэгш хамтын шийдлийн онол гэвэл онох онол амилж биелэх ёстой юм. Сүүлийнх нь хувьд жишээ нь Ролзын анхдагч хэрэглэгдэхүүнд анхаарал тавьсантай харьцуулбал чадамж тун чухал чиг баримжаа бий болгодог. Гэхдээ чадамж үйл явцтай холбоотой тэгш хамтын шийдлийн онолд агуулагдах ёстой бусад

хэлэлцэж байгаа асуудалд мэдээллийн цор ганц үндэс суурь болж бараг чадахгүй.

Магадгүй Ролзын шударга ёсны онолын янз бүрийн бүрэлдэхүүнийг харгалзан үзсэнээр энэ санааг хамгийн хялбар харах боломжтой юм. Түүний шударга ёсны “эхний зарчимд” чөлөөт байдлын тэргүүнд тавьдаг бөгөөд “хоёр дахь зарчмын” эхний хэсэгт “албан тушаал, ажлын байр бүгдэд нээлттэй” байх шаардлагаараа үйл явцын шударга байдалтай холбогддог. Ролзыг эдгээр тодорхой томъёоллыг гаргахад хүргэсэн асуудлуудыг өөр арга замаар шийдэж болох ч Ролз өөрөө үүнийг шийдвэрлэж байгаа арга зам нь төдийгүй чадамжийн мэдээллийн үндэс суурьт зөвхөн найдсанаар Ролзын эдгээр асуудлын хүч, маргашгүй байдлыг хайхрахгүй орхих ч, оновчтой шийдэх ч боломжгүй юм.

Эсрэгээрээ чадамж нь “Ялгааны зарчим” зэрэг (“анхдагч хэрэглэгдэхүүнд” төвлөрснөөрөө) “хоёр дахь зарчмын” өөр нэг хэсгийг ярих үед өөрөө гарч ирнэ. Анхдагч хэрэглэгдэхүүнийг тооцох гэж Ролзын үлдээсэн орон зайг ялгааны зарчимд хэрэглэсэнээр бол чадамжийн чиг баримжааг илүү сайн гүйцэтгэж чадна. Гэхдээ тэр нь чөлөөт байдал ба үйл явцын тэнцвэр зэрэг үйл явцын хэлэлцүүлэг өрнөдөг шударга ёсны орон зайн бусад хэсгийн учир холбогдлыг ямар нэг байдлаар алдуулахгүй. Мэдээллийн суурь үндсийн ийм олонлог нь хүний эрхийн онолд гарч ирж болох хэлэлцүүлгийн олон янз хувилбартай холбогдоно. Чадамж ба эрх чөлөөний боломжийн талд ач холбогдлынх нь хувьд шударга байх үйл явцыг харгалзан үзэж, тэдгээрийг хөндөж, хэрэглэх хувь хүний эрхийг зөрчих боломж бага байдаг зэргээр нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай.



## VI. Үүрэг, зүй ёсны анхаарал, нэн тодорхой бус үүрэг хариуцлага

Одоо харин эрхийн тухай ярианаас хамтын эрхийн тухай яриа руу шилжье. Бид эрх чөлөө ба түүний өөр өөр талуудын ач холбогдлоос цааш яриагаа дахин үргэлжлүүлж болно. Эрх чөлөө их чухал зүйл учир хүмүүст эрх чөлөөгөө хамгаалахад бие биедээ туслахын тулд явал зохих вэ гэж асуух шалтгаан байдаг. Тодорхой эрхүүдийн үндэс суурь болсон эрх чөлөөг зөрчих, хэрэгжүүлэхгүй байх нь энэхүү үнэлгээний тогтолцоонд тохиолдож болохгүй зохисгүй зүйл болох тул зөрчил гарахад хариуцлага хүлээхгүй хүмүүст ч гэсэн энэ тохиолдолд яаж тусалж болох талаар бодох шалтгаан бий. Гэтэл үр дагаврын мэдрэмжтэй ёс зүйн тогтолцоонд авч үзвэл ойлгомжтой байж болох хүнд туслах үйлдэл хийх шалтгаанаас тийм үйлдэл хийхэд нухацгай бодолцох үүрэгт шилжих нь ядаж анх харахад зэгсэн том үсрэлт байж болох юм.

Харин ийм ялгааны мэдрэмж тун хуурмаг байдаг. Хэрэв ярьж байгаа үүрэг боломжит үйлдэл хийх шийдэл гаргахад чиглээгүй, харин өөр ямар үнэ цэнэ байгаа болон харгалзан үзэх шалтгаантай ямар ч чармайлт байлаа гэсэн үйлдэл хийх гарцаагүй үүрэг хариуцлага байгаа тохиолдолд ялгаа нь үлэмж тооцоо шаардах нь мэдээжийн хэрэг юм. Үүргээ хэрхэн ухамсарлаж байгаа буюу зайлшгүй хийх үүрэг хэмээн үзэж байгаа тэр байдал нь үйлдэл хийх шалтгааныг хүлээн зөвшөөрөхөөс зарим хэмжээнд ялгаатай төдийгүй үнэмшил багатай, тэр ч бүү хэл уялдаа муутай байна. Ямар нэг шалтгаантай олон сайн үйл байдаг ч тэдгээр үйлийг бүгдийг нь гүйцэлдүүлэх боломж байхгүй. Ач холбогдлынх нь дэс дарааллаар үнэлэх болон ухаалаг үйлдэл хийхээсээ өмнө нилээд тунгаан бодох үүрэгтэй байгаа байдалд нь ялгаа олох шаардлага бий.

Хүн өөр өөр төрлийн олон үйлдэл хийхдээ сайтар бодож үзэх үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь өөрийгөө тайлагдашгүй зангилаанд оруулахыг зөвшөөрч байгаа хэрэг биш юм. Энэ агуулгын хүрээнд практик эргэцүүллийн эргүүлэгт орж явчихгүй гэсэн шийдэл нь бусдын эрх болон суурь, нөлөө үзүүлэхүйц эрх чөлөөний төлөө хийх үйлдлийн талаар сайтар бодож үзэх үүрэгтэй гэдгийг үгүйсгэх үндэслэл болохгүй гэсэн бодомжид ач холбогдол өгөх нь тухайлан чухал байна. Сайтар бодолцох шаардлага хүний практик эргэцүүлээс хамаараад маш олон янз байх параметруудийн хувьд харилцан адилгүй байдаг.<sup>5</sup> Тодорхой эрх чөлөө хүний эрх байх шалгуур хангаж байгааг хүлээн зөвшөөрөх тэдгээрийн ерөнхий ач холбогдол, боломжит нөлөөллийг үнэлсний (IV бүлэгт үзсэн) тусгал боловч ийм өргөн хүрээний шинжүүдээс хэтэрч илүү нарийн тодорхой нөхцөл байдал руу шилжин, ялангуяа тодорхой нэг тохиолдолд юу хийвэл зохих вэ гэдэгт зохистой анхаарал хандуулах болдог байна.

Тухайн хүн жишээ нь хийж болох үйл ажиллагааны тухайд бусад шаардлагатай (Бусад эрх, эрх чөлөөг хамрах боловч тухайлбал хүнд байж болох өөр асуудлууд) харьцуулбал хүний эрх, эрх чөлөө хэр их чухал болохыг шийдэх хэрэгтэй болно. Цаашилбал тухайн хүн энэ тохиолдолд ганцаараа ч бай, бусадтай хамтдаа ч бай ямар хэмжээнд өөрчлөлт хийж чадах вэ гэдгийг дүгнэх ёстой. Энд мөн өөр хүн бол юу хийж болох вэ, өөр боломжит талуудтай хэрхэн хамтарвал зүйтэй бол гэдгийг бодолцож үзвэл зүйтэй байх болно.

Тиймээс бүх хүн төрөлхтний эрх, чөлөөтэй холбоотой үүрэг хариуцлагыг

<sup>5</sup> Параметрийн хувьсах чанарт анхаарал хандуулах нь рациональ үнэлгээний ерөнхий шинж бөгөөд зөвхөн тухайлан ёс зүйн эргэцүүлэлд байдаг онцлог биш. Энэ асуудлыг би "Rationality and Freedom"-д өгүүлсэн (Cambridge, Mass.: Harvard University Press, 2002). 1-5

хүлээн зөвшөөрөхийг утга учиргүй шаардлага гэж тайлбарлах нь зохисгүй юм. Харин учир зүйтэй тунгаалтын хамрах хүрээ, хүчин чадлын параметрийн хувьсах чанарыг үл харгалзан тийм тийм анхаарал тавих шаардлага нь ямар ч нөхцөлд үр дүнгүй дэмий зүйл биш билээ. Суурь ерөнхий үүрэг хариуцлага бол хүн ярьж байгаа тохиолдолд холбогдох параметрийг тэмдэглэвэл, юу хийх нь зөв, оновчтой вэ гэдгийг нухацтайгаар анхаарахад бэлэн байх хэрэгтэй. Тэр асуултыг асуухын (бид бусдад хохирол учруулаагүй бол өгөх ямар ч өр байхгүй гэсэн бодол дээр цаашид урагшлахаасаа илүүтэй) хэрэгцээ бол ёс зүйн эргэцүүллийн илүү цогц дэлгэрэнгүй шинжтэй мөрийн эхлэх байж болно.<sup>6</sup> Хүний эрхийн орон зай энд хөдөлбөргүй оршдог. Эргэцүүлэл харин энд дуусна. Хүний хязгаарлагдмал чадвар, далайцынхаа хүрээнд, мөн олон төрлийн үүрэг хариуцлагыг оролцуулсан тэргүүлэх ач холбогдлын дарааллын хэрэгцээ болон ёс суртахууны бусад асуудлын шаардлагыг харгалзан үзвэл практик эргэцүүллийн нухацтай дасгал явуулах бөгөөд түүнд нь хүний олон янзын үүрэг хариуцлага (төгс бус хариуцлагыг оруулаад) ил далд ямар нэг хэлбэрээр илрэх ёстой юм.

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх нь хүн бүр хаа сайгүй хүний эрхийн зөрчил гарах тоолонд түүнээс урьдчилан сэргийлэхэд туслах ёстой гэсэн үг биш. Харин тийм эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд ямар нэг зүйл хийж болохоор байр сууринд байгаа бол түүнийгээ хийх гэж чармайх үүрэгтэй гэсэн үг юм. Бусад үүрэг хариуцлага болон үүрэг хариуцлагын шинжгүй асуудлуудад тухайн нэг үйлдэл хийх учир шалтгаан дарагдаж болох ч тэр шалтгааныг “хэнд ч падгүй юм” шиг баллуурдчих боломжгүй.

<sup>6</sup> Тэрхүү ерөнхий асуултын төвлөрөлийг Томас Сканлон “Бидний бие биедээ өгөх ёстой зүйлс”-дээ өгүүлсэн. (Cambridge, Mass.: Harvard University Press, 1998).

Үүрэг хариуцлагыг сулхан зааж өгөхийг огт зааж өгөөгүй байхтай андуурч болохгүй. Харин өмнө хэлсэнчлэн тэдгээр нь Иммануэль Кантын нэн тодорхой бус үүрэг хариуцлага гэж нэрлэсэн (тэр үүнд маш их ач холбогдол өгсөн байдаг) үүргүүдийн ухагдахуунд хамаарна.

Энэ ойлголтын хүрээнд нэн тодорхой бус үүрэг хариуцлага бол тодорхой хүмүүс тусгай үйлдэл гүйцэтгэх шаардлагатай болдог “нэн тодорхой үүрэг хариуцлага” хэмээгч бүрэн тодорхойлсон үүргийн хүрээнээс давж гарсан ёс зүйн шаардлага гэж тэмдэглэх хэрэгтэй. Тэдгээр нь эрх зөрчигдөх аюул заналд байгаа хүнд зохих тусламж үзүүлэх байр сууринд байгаа хүнээс нухацтай анхаарал хандуулахыг шаарддаг. Эдгээр “нэн тодорхой бус үүрэг хариуцлага” нь бүрэн тодорхойлогдсон “нэн тодорхой үүрэг хариуцлагын” нэгэн адилаар эрхийг хүлээн зөвшөөрөх гэдэг ойлголттой хөдөлбөргүй хамааралтай байна. Ялгаа нь төгс болон нэн тодорхой бус үүрэгт адилхан үйлчилдэг эрх үүргийн ерөнхий харилцаанд биш, харин үүргийн мөн чанар, илэрч байгаа хэлбэрт оршино.

Агуулгын хувьд ялгаатай боловч ө хүний эрхтэй адил төстэй байдлаар холбогддог өөр өөр төрлийн үүрэг хариуцлагын онцлогийг бодит жишээгээр тодруулбал тустай байх. 1964 онд Нью-Йоркийн Күйнст болсон бодит явдлаар жишээ татъя. Китти Женовезэ хэмээх нэгэн эмэгтэйд гэрийнхээ цонхоор харж байсан олон хүний нүдэн дээр аюултай халдлагад өртөхөд хэн нь ч ирж туслаагүй байна. Энд хоорондоо адилгүй боловч харилцан уялдаатай гурван ноцтой зүйл болжээ гэхэд буруутахгүй. Үүнд:

- 1) Тэр эмэгтэйн халдлагаас болон аминд халтай аюулаас ангид байх эрх чөлөө буюу эрхийг зөрчжээ. (Энэ бол тухайн тохиолдолд гол асуудал)

- 2) Алуурчин бусдын гэмт халдлага, аллагад өртөхийн эсрэг халдашгүй байдлыг зөрчсөн байна. (нэн тодорхой үүрэг хариуцлагын зөрчил)
- 3) Хохирогчид туслах гэж юу ч хийгээгүй хүмүүс зүй нь тусламж үзүүлэх ёстой байсан ч энэ талаар бодох ёстой байсан ерөнхий/нэн тодорхой бус үүрэг хариуцлагаа хөсөрдүүлсэн байна.

Эдгээр ялгаатай зөрчлүүдээс нарийн бүтэцтэй ёс зүй дэх эрх үүргийн харилцааны цогц хэлбэрийг харж болно. Ингэснээр төгс болон нэн тодорхой бус үүрэг хариуцлагын урган гардаг хүний эрхийн үнэлгээний тогтолцоо тодорхой болоход тус дөхөмтэй.<sup>7</sup>

Хуулийн эрхийн таамагласан тодорхойлолтуудыг ихэнхдээ хүний эрхийн ёс зүйн шаардлага дахь зайлах аргагүй мухардалтай харшуулж үздэг. Гэхдээ норматив эргэцүүлэл бүрэн тодорхойлогдсон эрх зүйн шаардлагуудад тийм ч хялбар суухааргүй хувьслуудыг зөвшөөрдөг тул энэ харьцуулалт өөрөө нэн тодорхой бус үүрэг хариуцлага зэрэг ёс зүйн шаардлагын хувьд тийм ч ичмээр юм биш. Аристотель Никомаheyн ёс зүй бүтээлдээ тэмдэглэсэнчлэн бид “сэдвийн мөн чанартай тохирч л байгаа бол зүйлсийн анги бүрт нарийн тодорхой чанарыг хайх” ёстой юм.<sup>8</sup>

Гэхдээ зарим улсын хууль тогтоомжид тааралддагаар гуравдагч этгээдэд туслах тодорхой байдал агуулаагүй шахуу хууль зүйн шаардлага байдаг. Жишээ нь Франц

улсад тодорхой төрлийн халдлагад хохирч байгаа хүнд зохих тусалцаа үзүүлээгүй тохиолдолд “эс үйлдэхүйн эрүүгийн хариуцлага” хүлээлгэх заалт байдаг. Тийм хуулийн хэрэглээн дэх мухардмал байдал нь нилээн гүн гүнзгий бөгөөд сүүлийн жилүүдэд хууль зүйн ихээхэн яриа, хэлэлцүүлгийн сэдэв болоод байгаад гайхах зүйл байхгүй юм.<sup>9</sup> Энэ төрлийн үүргийн мухардмал байдал ёс зүй, эрх зүйн алинд ч бай гуравдагч талын үүрэг хариуцлагыг харгалзан үзвэл зайлахад хэцүү болох бөгөөд хүний эрхийн зохистой онолоор бол зайлах ямар ч аргагүй билээ.

## VII. Хүлээн зөвшөөрөх, ухуулан уриалах, хууль тогтоомж

Өмнөх шинжилгээ бусдын хүний эрхийг хамгаалах буюу дэмжихэд хүмүүсийн авч хэрэгжүүлэх үйлдлийг ерөнхийд нь анхаарч үзэх тухай өгүүлсэн бол энэ талбарын онолын бүтээл туурвилд арслангийн анхаарлыг өөртөө татах хандлагатай зүйл бол хүний эрхийн хууль тогтоомж болон түүний институтчилагдсан байдал юм. Мөн хууль тогтоомжийн энэ төлөв л хүний эрхийн байгууллын ойлголтын ихэнхэд нь бат сууж ирсэн болно. Гэхдээ хууль тогтоомж олон нийтийн үйл ажиллагааны нэгэн чухал салбар байхын хажуугаар хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн үйл хэргийг урагшлуулахад чухал бөгөөд үр дүнтэй бусад арга замууд бас бий.

Эн тэргүүнд “хүлээн зөвшөөрөгдөх зам” хэмээгчийн дагуу бол (хууль тогтоомжийн зам гэдгээс ялгахын тулд) хүний суурь эрх гэж үздэг эрхийн ангилалыг хүлээн зөвшөөрдөг боловч заавал хуульчлах буюу институцийн хувьд тогтоодоггүй байна.<sup>10</sup> Өнгөрсөн зуунд

<sup>7</sup> Энэ шинжилгээнд би үйлдэгч тодорхой болон үйлдэгч тодорхой бус ёс суртахууны үнэлгээний аргын хоорондын ялгаа руу орсонгүй. Энэ тодорхойлолтыг цаашид өмнө “Rights and Agency”, “Positional Objectivity”-д авч үзсэний аргаар байр суурь тодорхой үнэлгээг түлхүү ашиглан өргөжүүлж болно.

<sup>8</sup> Рациональ үнэлгээний хүрэн дэх зайлах аргагүй мухардалын боломжит байдлыг “Internal Consistency of Choice” *Econometrica* 65 (1993): 495-521, “Maximization and the Act of Choice,” *Econometrica* 65 (1997): 745-79-д бичсэн. Хоёуланг нь Rationality and Freedom-д хэвлэсэн. Inequality Reexamined, 46-49, 131-35 дахь талаас харж болно.

<sup>9</sup> Жишээ нь Эндрью Эшворт ба Эва Стейнэрийн “Criminal Omissions and Public Duties: The French Experience,”-ийг үзнэ үү. *Legal Studies* 10 (1990): 153-64; Glanville Williams, “Criminal Omissions: The Conventional View,” *Law Quarterly Review* 107 (1991): 86-98

<sup>10</sup> Чарльз Бейцийн тэмдэглэсэнээр хүний эрх “ёс суртахууны

хүний эрхийн талаарх дэлхий нийтийн үйл ажиллагааг дэмжсэн, магадгүй хамгийн чухал алхам болох Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1948 онд батласан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал бол бүхэлдээ энэ ухагдахуунд хамаарна (өмнө хэлсэнчлэн хэдий уг тунхаглалын их биеийг босгогчид өөр бусад улс оронд эрхийн тодорхой биллүүд батлахад нөлөөлнө гэж найдаж байсан ч). Хожим нь олон улсын тунхаглалууд ар араасаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүрээнд гарч хууль эрх зүйн, албадлагын статустай гэхээсээ илүү ерөнхий шинжтэй олон шаардлагад хүлээн зөвшөөрөгдөх статусыг олгосны нэг жишээ нь 1986 онд гарсан Хөгжих эрхийн Тунхаглал юм.<sup>11</sup> Энэ хандлага нь хүний эрхэд хэдий сахиулах биелүүлэх байгууллыг байгуулж өгөөгүй ч нийгмийн зөвшил, хүлээн зөвшөөрөгдсөн статусыг олгох замаар хүний эрхийн ёс зүйн хүчийг практикт илүү хүчирхэгжүүлнэ гэсэн санаанаас үндэслэлээ олсон байна.

Дараагийн ахиц дэвшил бол хүлээн зөвшөөрөгдөхөөс цаашлан идэвхтэй ухуулан уриалах үйл ажиллагаад шилжинэ. Хүний эрх гэж үзэж болох бүх хүн төрөлхтний тодорхой суурь хэрэгцээ шаардлагатай нийцүүлэхийг уриалсан зохион байгуулалттай нөлөөллийн ажил байж болох бөгөөд мөн эдгээр эрхийн зөрчилд хяналт тавьж, нийгмийн үр дүнтэй шахалт үзүүлэх боломжтой. Дэлхий

жишиг буюу дотоодын байгууллагуудыг үнэлж, шүүмж өгөх стандарт, тэдний шийтгэл хийх эрмэлзлийн стандарт, цаашилбал олон улсын эдийн засгийн болон улс төрийн байгууллагуудын бодлого, үйл ажиллагааг үнэлэх сатндартын үүрэг” гүйцэтгэдэг. “Human Rights Common Concept,” 269 дэх тал.

<sup>11</sup> Хөгжих эрхийн агуулгад хийсэн дүн шинжилгээнүүдийг НҮБ-ын ХХ-ийн Хүний хөгжлийн Илтгэл 2000 он, С.Р.Османийн “Хүнс хоолоор хангагдах, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрх” мимеографийн хувилбар, UNDP and the University of Ulster, 2000; Аржун Сенгуптагийн “Хөгжлийн бодлого ба Хөгжих эрх” Frontline, February 7-March 2001; Аржун Сенгупта, Асборн Эйдэ, Стефен Маркс, Бард Андерсон нарын “Хөгжих эрх ба Хөгжил дэх хүний эрх,” 2003 оны 10- сард Осло хотод болсон хөгжих эрхийн талаарх Нобелийн Симпозиум дээр тавьсан илтгэл зэрэгт тусчээ.

дахины ТББ-ууд нэг талаас олон нийтийн хэлэлцүүлэг, дэмжлэгийн аргаар, мөн нөгөө талаар гарч байгаа зөрчлийг нийтэд ил болгож, шүүмжлэх замаар хүний эрхэд ахиц дэвшил гаргах ажилд улам бүр татагдан оролцох болов. Эдгээр хүчин чармайлт Хүний эрхийн Хяналт, Эмнести Интернейшнл зэрэг тусгайлсан хүний эрхийн байгууллагуудаас төдийгүй Оксфам, Хил Хязгааргүй Эмч нар, Улаан Загалмай, Хүүхдийн ивээх сан, Экшн Эйд зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас ч гарч ирсэн юм. Энэхүү “ухуулга уриалгын зам”-аар гарч ирсэн эрх нь тухайн нэг оронд эрх зүйн статустай байж ч болно, үгүй ч байж болно. Гэхдээ хуулиар баталгаажуулж гээд нөлөөлөл, дэмжлэг нь үр дүнгүй дэмий гэж үзнэ гэсэн үг биш. Цаашилбал зарим тодорхой хүний эрх эрх зүйн статустай, холбогдох хууль тогтоомжийн дагуу сахин биелүүлэхээр байхад ч олон нийтийн нээлттэй идэвх зүтгэл шаардаж болох бөгөөд энэ нь хууль батлах үйл явцаас ялгаатай юм.

Гурав дахь арга зам бол мэдээж хууль тогтоомжид тусгах үйл ажиллагаа болно. Ш бүлэгт өгүүлсэнчлэн хүний эрхийн ёс зүйг “хүний эрхийн эрх зүйн” “эцэг эх” төдийхнөөр үзэж болохгүй ч олон тийм хууль тогтоомж хүний эрхийг анхааран авч үзсэнээс дэмжлэг авч буюу сэдэл авч бүтсэн байдаг. Олон хуулийг улс орнууд дангаараа буюу бусад улстай хамтран баталсан байдаг нь зарим эрхийг суурь хүний эрх гэж үзэхэд хууль зүйн хүчин чадал өгсөн байдаг юм. Жишээ нь Европын Конвенцийг баталсны дараа 1950 онд байгуулагдсан Европын Хүний эрхийн Шүүх хүний эрхийн зөрчлийн эсрэг гарын үсэг зурсан улс орны хувь хүний гаргасан өргөдлийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх боломжтой. Түүнээс гадна дотоодын хууль тогтоомжийг Европын Конвенцийн гол зүйл заалтуудтай

нийцүүлэхэд чиглэсэн Хүний эрхийн хууль 1998 онд гарснаар дотоодын шүүхийн тогтоол шийдвэрт конвенцийн заалтууд “шударгаар хангах” шаардлагад нийцэж байгаа эсэхийг авч үзэх Европын Шүүхийн хяналтын үүрэг ролийг баталгаажуулсан ажээ. Дэлхий өнцөг булан бүрээс өөр олон жишээ татаж болно. “Хуульчлах зам”-ыг маш идэвхтэй хэрэглэж ирсэн.

Хуульчлах арга замын зохистой хамрах хүрээний талаар нэгэн сонирхолтой асуулт байна. Хүний эрх тийм чухал юм бол түүнийг тухайлан нарийн тодорхойлсон хууль зүйн эрх болгож хуульчлах хэрэгтэй гэж ойлгох нь алдаа гэж хэлэх гэсэн юм. Жишээ нь гэр бүлийн шинжтэй шийдвэр гаргахад санал бодлыг нь сонсох ёстой гэсэн эхнэрийн ёс зүйн эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалах нь бүр хүйсийн эрх тэгш байдлын талаарх хуучинсаг уламжлалтай нийгэмд ч тун чухал бөгөөд хүний эрх гэсэн шалгуур хангах босго нөхцлийг хангахад гайхах зүйлгүй.<sup>12</sup> Гэлээ ч ёс зүйн болон хууль зүйн хамрах хүрээг нь онцолдог энэ эрхийн талыг баримтлагчид ч үүнийг Херберт Хартын хэлснээр томъёолвол албадлагын шинжтэй эрх зүйн журам болгох нь тийм ч ухаалаг алхам биш гэдгийг хүлээн зөвшөөрөх байх (магадгүй нөхөр нь эхнэртэйгээ зөвлөөгүйнхээ төлөө баривчлагдах байсан бол). Шаардлагатай өөрчлөлтийг өөр арга замаар бий болгох шаардлагатай байх сан. Өргөдөл гомдол, нөлөөлөл, урьдчилсан мэдээлэл бүхий нээлттэй хэлэлцүүлгийн ач холбогдлоор хүний эрх албадлагын арга хэмжээнд тулгуурлалгүйгээр нөлөө үзүүлж чадна.

Түүнтэй төстэйгөөр хүний эрх гэж хялбарханаар үзэж болох зарим талаар удаан

ярилцагчийн нээлттэй олон нийтийн уулзалт дээр бүдүүлэг хурдан яриатай нэгнээр доромжлуулахгүй байх ёс зүйн болон улс төрийн эрх ямба нь тайван чөлөөтэй яригчийн өөрийгөө хүндэтгэх байдал болон олон нийтийн ашиг тусад ч гэсэн чухал а холбогдолтой байж болох юм. Хүний эрхийг хаа сайгүй хамгаалах шаардлагатай. Хүний эрхийг хууль тогтоомжид оруулдаг санал шиг харлаа гээд хүний эрхийн чиг баримжаа үр дүнд хүрч байна гэж үзэх аргагүй.<sup>13</sup>

### VIII. Эдийн засаг, нийгмийн эрх

Одоо хүний эрхийн ойлголтод өлсөхгүй байх эрх, суурь боловсрол эзэмших болон эмнэлгийн тусламж авах эрх зэрэг эдийн засаг, нийгмийн эрхийг багтаан дэлгэрүүлэх гэсэн санааны эсрэг чиглэж ирсэн шүүмлэлийн талаар ярья. Эдгээр эрх нь жишээ нь АНУ-ын Тусгаар тогтнолын тунхаглал, эсвэл Францын “хүний эрх” зэрэг хүн төрөлхтний эрхийн сонгодог тайлбарт томъёоллоо олоогүй боловч, Касс Санстейний “эрхийн хувьсгал” гэж нэрлэсэн ойлголтын хүрээнд багтах ойлголт юм.<sup>14</sup> Эдгээрийг хүний эрхийн ерөнхий ангилалд оруулах нь зүй ёсны эсэхийг хоёр тусгайлсан чиглэлээр үгүйсгэж байсныг бий институцчилалын шүүмжлэл болон магадлалын шүүмжлэл гэж нэрлэж байна.

Тухайлан эдийн засаг, нийгмийн эрх рүү чиглэсэн институцчиллын шүүмжлэл нь бодит эрх ба нарийвчлан заасан хамаарах үүргийн хоорондох харилцааны ерөнхий асуудалтай хамаатай юм. Энд маргаж байгаагаар тийм харилцаа нь эрхийг институцчилж байж л оршино гэдэг. Онора О’Нейл шүүмжлэлийн ийм чиглэлийн харуулахдаа:

<sup>12</sup> Гэр бүлд шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцооны ач холбогдол, нийгмийн хамрах хүрээг *Development as Freedom* гүүлэлдээ бичсэн. Ch 8, “Women’s Agency and Social Change.”

<sup>13</sup> Илүү өргөн хүрээтэй хандлагын эрт үеийн нөлөөллийн жишээ харъя гэвэл Мари Волстенекрафт-ын “Эмэгтэй хүний эрхийг нэхэх нь: Улсын төрийн болон ёс суртахууны субъектуудын талаарх шүүмж”-ийг үз. 1792 он

<sup>14</sup> Sunstein, *After the Rights Revolution: Reconceiving the Regulatory State*.



Харамсалтай нь эрхийн талаарх олон зохиол, бүтээл бодлогогүйгээр бараа, үйлчилгээгээр хангагдах түгээмэл эрх, ялангуяа “халамжийн эрх”, мөн олон улсын дүрэм, тунхаглалуудад нийтлэг болсон нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг тунхаглаж, эрх эдлэгч бүр тодорхой үүрэг хүлээгчтэй юугаар холбогдож байгааг анхаарахгүй байгаа нь эдгээр яриад байгаа эрхийн агуулгыг бүхэлд нь ойлгомжгүй болгож байна...Зарим эдийн засаг нийгэм, соёлын түгээмэл эрхийг хамгаалагчид эдгээр эрхийг институцчилах боломжтой онцлохоос хэтрэх юм алга. Тэр нь ч үнэн. Гэвч ялгаа нь тэднийг институцчилах ёстой гэдэгт оршиж байна. Үгүй бол эрх гэж огт байхгүй болно.<sup>15</sup>

Энэ шүүмжлэлийн хариуд бид хэдийн өгүүлсэн үүрэг хариуцлага төгс ба төгс бус аль алинаар илэрнэ гэсэн ойлголтыг дахин сөхөх ёстой. Халдлагаас ангид байх эрх чөлөө зэрэг сонгодог “нэгдүгээр үеийн” эрх ч Нью-Йорк хотод Китти Женовезед олны нүдэн дээр халдсан хэргийн жишээн дээр тайлбарласнаар бусдад нэн тодорхой бус үүрэг хариуцлага оноож байгаа юм шиг харагдаж мэднэ. Институцийн боломжоос хамаараад эдийн засаг, нийгмийн эрхийг мөн төстэй байдлаар нэн тодорхой ба нэн тодорхой бус үүрэг хариуцлага гэж нэрлэж болох юм. Нийгэм, төр засаг, бүр үгээгүй ядуу нэгэн ч гэсэн эдийн засаг нийгмийн тодорхой эрх зөрчигдөхөөс сэргийлэхэд юу хийж болох вэ (өлсгөлөн, хүнс тэжээлийн архаг дутагдалд нэрвэгдэх, эмнэлгийн үйлчилгээ авч чадахгүй байх зэрэгтэй холбогдон) гэдэг талаар үр дүнтэй олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, шахалт үзүүлэх зэрэг нь маш өргөн боломжтой.

Мэдээж нийгмийн байгууллагуудын

<sup>15</sup> Onora O’Neil, *Towards Justice and Virtue*, pp. 131-32. Түүний *Boundds of Justice-ийг харна уу.* (Cambridge: Cambridge University Press, 2000)

дэмжлэг нь институцийн шинжтэй өөрчлөлтөд тухайлан чиглэдэг бөгөөд эдгээр үйл ажиллагааг суурь хүний эрх зөрчигдөхөд нийгэмд хувь хүн, бүлэгт байж болох нэн тодорхой бус үүрэг хариуцлагын нэг хэсэг гэж үзэж болно. “Халамжийн эрх” хэрэгжихэд институц байх шаардлагатай гэсэн нь Онора О’Нейлийн зөв (эдийн засаг, нийгмийн эрхийн хувьд ч бас) боловч эдгээр эрхийн ёс зүйн ач холбогдлоос институцийн өргөтгөл, шинэтгэлээр дамжуулан хэрэгжүүлэх боломж хайх хангалттай үндэслэл бий болгоно. Үүнийг тохиромжтой хууль тогтоомж гаргахыг шаардах буюу уриалан ухуулах, мөн эрх зүйн шаардлагыг улс төрийн хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх буюу нийгмийн мониторингийн аргаар нэмж оруулах зэрэг олон янзын аргаар гүйцэлдүүлж болно. Эдгээр эрхийн ёс зүйн статусыг үгүйсгэх нь эдгээр бүтээлч үйл ажиллагааг идэвхжүүлэн дэмждэг бодомж, эргэцүүллийг үл хэрэгссэн хэрэг болно.

Магадлалын шүүмжлэл нь дээд зэргээр чармайгаад ч эдийн засаг, нийгмийн эрхийн олонхийг нь хэрэгжүүлэх нь боломжгүй байж болно гэсэн бодлоос үүдэлтэй юм. Энэ нь зөвхөн эмпирик ажиглалтын үр дүн байж болох юм (өөрийнх нь ямар нэг сонирхлоос гарсан). Гэвч хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх нь бүгд хэрэгжих боломжтой гэсэн итгэл дээр үндэслэн эдгээр эрхийг хүлээн зөвшөөрөхийг нилээн хүчтэй шүүмжлэх болжээ. Хэрэв энэ итгэлийг хүлээн зөвшөөрвөл боломжит хүний эрхийн хүрээнээс гадуур маш олон эдийн засаг, нийгмийн гэх эрхийг тавьсны нөлөө ялангуяа ядуу бурай орнуудад бодитой болох байв.

Морис Кранстон энэ асуудлыг ийн тоймлосон нь:

Уламжлалт улс төрийн болон иргэний эрхийг институтчилахад бэрх биш. Ихэнхдээ тэдгээрээр хувь хүнийг тайван орхихыг төр



засаг болон бусад хүнээс шаарддаг... Эдийн засаг, нийгмийн эрхэд чиглэсэн шаардлагаас үүдэн гарч буй асуудлууд бол харин бүхэлдээ огт өөр зүйл юм. Аж үйлдвэржилт эхлэх төдий байгаа Ази, Африк, Өмнөд Америкийн засгийн газруудыг яаж тэнд оршин суугаа, хурдацтай өсч байгаа олон сая хүнийг нийгмийн баталгаагаар хангаж, цалинтай амралт олгож бай гэж уриалж болох вэ?<sup>16</sup>

Үгүйсгэлийн энэ мөрийг үнэлэхдээ бид шаардлагатай бол боломж магадлалыг нь ихэсгэх замаар хүний эрхийн бодит хэрэгжилтийг нэмэгдүүлэхийн тулд ажиллах зорилт тавьж байхад яагаад бүрэн магадлалтай байх нь хүний эрх маргашгүй байх нөхцөл байх ёстой гэж хэмээн асуух хэрэгтэй юм. Зарим эрх бүрэн хэрэгжээгүй, магадгүй өнөөгийн нөхцөлд огт бүрэн хэрэгжих боломжгүй байх тухай ойлголт нь эдгээр нь эрх ердөө ч биш гэж дүгнэх шалтгаан болохгүй.<sup>17</sup> Харин ч энэ ойлголтоос хэрэгжээгүй байгаа эрхийг хэрэгжихүйц болгож, эцэст нь хэрэгжүүлэхийн тулд өнөөгийн бугшсан нөхцөл байдлыг өөрчлөх зорилготой ажиллах шаардлага харагдаж байна.<sup>18</sup>

Энэ агуулгаараа магадлалын асуудал бол эдийн засаг, нийгмийн эрхэд л зөвхөн хязгаарлагдах асуудал биш, нилээн өргөн дэлгэрсэн асуудал гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Эрх чөлөө, хараат бус байдлын тохиолдолд ч гэсэн Кранстоны баталгаажуулах нь их энгийн зүйл гэж бодсон шиг хэн нэгнийг “тайван орхино” гэж батлах

<sup>16</sup> Кранстон, “Хүний эрх гэж бий юу” 13 дахь тал  
<sup>17</sup> Энэ шалтгаанаар би “ёстой гэдэг нь боломжтой гэсэн утгатай” гэсэн зарчмыг сөхөж бүрэн хэрэгжих боломжгүй шаардлага бол эрх огт биш гэсэн санаа илэрхийлэх гэж буй эндүү ташаа хэрэглээ гэж байгаа юм. Зарим шаардлагын ёс зүйн хүчин чадлыг авч үзэх нь тэдгээрийг хэрэгжихүйц болгохын тулд юу хийх хэрэгтэй вэ гэж бодох шаардлага болдог.

<sup>18</sup> Энэ нь Чарльз Бэйцийн хүний эрхийн практик ойлголт гэж нэрлэсэнтэй дүйнэ. “Ямар нэг зүйлийг хүний эрх гэж хэлнэ гэдэг нь тэр эрхийг хамгаалж чадаагүй нийгмийн институцийг согогтой гэсэнтэй адил”

нь хэзээ ч тийм хялбархан асуудал байсан удаагүй. Тэрхүү хэзээд хялбарханаар харж байсан наад захын баримтыг одоо ч тийм хялбархан хүлээн зөвшөөрч чадахааргүй байна. Одоогийн бүрэн, нэг бүрчлэн биелүүлнэ гэж батлах боломж нь эрх бүрийн үнэмшил төрөхүйц хүлээн зөвшөөрөгдөх шаардлагатай нөхцөл болох байсан бол эдийн засаг, нийгмийн эрх төдийгүй эрх чөлөө, өөртөө засах байдал, бүр улс төрийн эрх ч үнэмшил төрүүлэх хэмжээнд очихгүй байх байлаа.

### IX. Нийтийн зөвшилцөлд хүрэх нь

Хүний эрхийн шаардлагын хүлээн зөвшөөрөгдөх чанарыг хэрхэн дүгнэж, тэдгээрт тулгарах сорилтыг яаж үнэлэх вэ? Тийм маргаан буюу хамгаалалт хэрхэн үргэлжлэх вэ? Би бусад ёс зүйн шаардлагаас ялгаатай нь нээлттэй, урьдаас мэдээлэлтэй хяналтын сорил байх ёстой гэж хэлэх гэсэн юм. Эдгээр ёс зүйн шаардлагын статус нь эцсийн эцэст чөлөөт хэлэлцүүлгийг давах чанараас нь хамаарна.<sup>19</sup> Энэ нь хүний эрхийн оршин тогтнох чанар нь Жон Ролзын нэрлэсэнчлэн “нийтийн эргэцүүлэл” болон “ёс зүйн бодит чанар”-гүйцэтгэх үүрэгтэй холбогдоно.

Мэдээж олон нийтийн бодомж эргэцүүлэл болон хүний эрхийн томъёолол, хэрэглээний хоорондын холбоо нь ойлголт авахад тун чухал. Эдгээр шаардлага эсвэл тэдгээрийн үгүйсгэлд байгаа үнэмшигдэхүйц чанар нь энэ онол ёсоор бол тэдгээрийн хязгаарлалтгүй нээлттэй шүүмж, хэлэлцүүлэгт орох үед тэсч үлдэн, цэцэглэхээс хамаарна. Хүний эрхийн шаардлагын хүчин чадал нээлттэй олон нийтийн ярилцлагыг давж чадахгүй болмогц л доройтдог. Үл итгэх, үгүйсгэхэд нийтлэг

<sup>19</sup> Энэ шаардлага процесийн хэлбэртэй боловч хэн ч хамрагдахгүй байх боломжгүй нээлттэй хэлэлцүүлгийг эн тэргүүнд тавих нь

хэрэглэдэг шалтгаанаас ялгаатай нь нээлттэй олон нийтийн хэлэлцүүлгийг огт хүлээн зөвшөөрдөггүй улс төрийн болон нийгмийн хувьд дарангуйлах дэглэмд эдгээр олон хүний эрхийг нухацтай харгалзадаггүй гээд хүний эрхийн хэрэг тохиолдлыг зүгээр л нэг орхичихдоггүй. Хязгаарлалтгүй шүүмжлэлт хяналт нь татгалзах, хамгаалахын аль алинд чухал үүрэгтэй. Хэрэглээг нь хөндөж л байвал хүний эрхийн зөрчилд хяналт тавих, олон нийтэд ил тод дэлгэх нь тун үр дүнтэй байж болох нь мэдээлэл хүртээмжтэй, ёс зүйн ойлголтууд хоиротой гэхээсээ чөлөөтэй болох үед олон нийтийн бодомж эргэцүүллийн хамрах хүчин чадал, хүрээ ямар байхыг илтгэж байна.

Гэхдээ олон нийтийн санаа бодлын хүрээг тодорхой нийгэмд хязгаарлаад ойлгочихож болохгүй. Ялануяа хүний эрхийн асуудалд эдгээр эрхийн гарцаагүй хязгаарлагдаж болохгүй чанарыг харгалзан үзвэл бүхий л хүн төрлөхтөнд хамаарах ёстой юм. Энэ нь Ролзын ялангуяа тодорхой ядаж дотоодын асуудалд яавал дээр вэ гэдгийг шийдэхэд нэг үндэстэн бүрийн (Ролзын энэ бүс нутгийнхныг хамтын байдлаар нь нэрлэсэнчлэн “ард түмэн” бүр) хил хязгаарын дотор олон нийтийн тийм сөргөлдөөнийг хязгаарлахын тулд хожмын бүтээлүүддээ тухайлан тусгасан хазайлттай харшилдаг. Бид эсрэгээр нь хэлэлцүүлэгт дотоодын шударга ёсны төлөө ч гэсэн (явцуу алагчлалаас зайлсхийж байвал мөн өргөн хүрээтэй сөрөг мэдэгдлийг шалгаж үзэхийн тулд) “тодорхой зай”-наас өгсөн үзэл бодол оролцуулахыг шаардаж болно. Үүний ач холбогдлыг Адам Смит тун оновчтой тодорхойлсон:

Бид хэзээ ч өөрсдийн сэтгэл санаа, сэдлийг шүүрдэн үзэж чаддаггүй. Бид өөрсдийгөө байгаа төрөлх орчноосоо ангижруулж, тэдгээрийг өөрсдөөсөө

тодорхой зайд харахаар хичээхгүй бол бид тэдгээртэй холбоотой шийдэл гаргаж огт чаддаггүй. Гэвч бид бусад хүний нүдээр харах буюу бусад хүн тэдгээрийг харж байгаа юм шиг харахаас өөр аргаар харж чадахгүй.

Адам Смитийн арга замын универсалист шинж чанар нь хэрэг дээрээ юуг соёлын “зөрчиж болшгүй” хязгаар гэх вэ гэдгээс хамаараад хоорондоо хол зайтай байдаг хүмүүс орон нутгийн шинжтэй асуудалд зохих шүүмж өгч чадах эсэх тухай асуудлыг сөхсөн ажээ. Францын “хүний эрх”-ийн тунхаглалын талаар Эдмунд Буркегийн өгсөн шүүмжлэлүүдийн нэг, мөн түүний универсалист амин сүнс нь бусад соёл дахь тэрхүү ойлголтын зөвшөөрөгдөх байдлыг үгүйсгэх тухай байв. Бурке “чөлөөт байдал ба хязгаарлалт бол цаг хугацаа, нөхцөл байдлаас шалтгаалаад янз бүр байдаг бөгөөд ямар нэг хийсвэр дүрмээр тогтоочихож болшгүй хэмжээ дамжаагүй өөрчлөлтийг хүлээн зөвшөөрдөг” гэжээ. Ийм буюу үүнтэй төстэй ч гэхүү шалтгаанаар хүний эрхийн ойлголтын үндсийг тавьсан түгээмэл байдал бол гүнзгий алдаа гэсэн үзэл бусад олон бүтээлд орсон байдаг. Жишээ нь тэргүүлэх Марксист онолчдын нэг бөгөөд хорьдугаар зууны эхэн үеийн улс төрийн зүтгэлтнүүдийн нэг Роза Люксембург ‘хүний эрх’, ‘иргэний эрх’ гээч зүйлүүдийн метафизик үлгэр” хэмээн шүүмжилсэн нь бий. Гэхдээ Роза Люксембургийн жинхэнэ санааг шинжилж үзвэл Максисст уламжлалд стандарт болсноор тэр өөрөө нийтлэг байдлын зарчмыг гаргаж ирсэн нь онцлог юм (чадварынх нэг бүрээс, хэрэгцээнийх нь нэг бүр рүү). Харин Люксембург эдгээр зарчмын биелэлээ олох нь бүтэлтэй байх тодорхой нөхцөл байдлаас шалтгаална гэдгийг мэдрэмжтэйгээр онцолжээ. Үнэндээ Люксембургийн заалт нь хүний эрхийн шаардлагын зүй ёсны

санамсаргүй буюу хэмжүүрийн шинжтэй тодорхойлсон жагсаалт дахь нутгийн болон бүс нутгийн нөхцлийн учир холбогдол заасныг тэмдэглэхийн зэрэгцээ нийтлэг чанарын зарчмыг ерөнхийд нь хэрэглэхэд тийм хэцүү зүйл байхгүй гээд энэ хүүрнэлийг өндөрлөө.

Гэвч өөр өөр соёлын үнэт зүйлсийн хооронд давж болшгүй зааг байдаг талаарх үзэл олон зууны турш байн байн гарч ирсээр өдийг хүсэн бөгөөд өнөөдөр ч амь бөхтэй зууралдсаар байна. Гайхалтай өвөрмөц, ихэвчлэн давуу дээд чанарын онцлог байдаг талаарх яриа бүс нутгийн ёс зүйн номлогчид (“Азийн үнэт зүйлсийн онцгой шинжийн тухай 1990-ээд оны хөөрлөөр илэрсэн”) буюу шашны буюу соёлын салан тусгаарлагчдаас (аль нэг шашны тулгуур үзлээр гэх мэт) ялгарч “Өрнийн үнэт зүйлсийн” шүүмжлэгчдийн зүгээс гарч байв. Заримдаа гэвч өвөрмөц онцлогийн тухай яриа Өрнийн онцгойрогчдоос ч гарч байсан юм. Нэг тод жишээ нь Самуэль Хантингтоны “Өрнөд бол орчин үе болохоос ч өмнө Өрнөд байсан” гэсэн мэдэгдэл бөгөөд “бодгал ч үзлийн ойлголт болон хувь хүний эрх ба эрх чөлөөний уламжлал” зөвхөн “иргэншсэн нийгмүүдийн дунд” л байдаг гэсэн үзэл юм. Үүнтэй төстэйгөөр Гертруд Химмельфарб “шударга ёс”, “эрх”, “шалтгаан”, “хүмүүнлэгийн хайр” зэрэг ойлголтууд нь “зонхилон, магадгүй бүр гагцхүү Өрнийн үнэт зүйл мөн” гэсэн байна.

Би эдгээр ойлголтын талаар өмнө ярьж байсан удаатай.<sup>20</sup> Соёлын хэвшмэл хандлагаас эсрэгээрээ өөр өөр улсын түүхэн үе үе мөн ихээхэн өөрчлөлт гарч байснаас гадна нэг улсын доторх өөр соёл уламжлалын хувьд ч хувьсал гарч ирсэн байдаг. Нээлттэй

<sup>20</sup> Миний *Development as Freedom* гүүллгийн 10-р бүлэг, мөн Хүний эрх ба Азийн үнэт зүйлс өгүүллгийг үзнэ үү. *The New Republic*, July 14 and 21, 1997, pp.33-40; “The Reach of Reason: East and West,” *The New Republic*, July 20, 2000, pp 33-38; “Democracy and Its Global roots,” *The New Republic*, October, 2003, pp. 28-35.

олон нийтийн хэлэлцүүлгийг зөвшөөрч, харилцан адилгүй үзэл бодлыг хүлцэж, дэмжих туршлага дэлхийн олон оронд урт хугацааны түүхтэй. Мэдээж өөр өөр үзэл бодлын хоорондох маргааныг шийдвэрлэхэд тухайлан чиглэсэн анхны нээлттэй уулзалтуудыг Энэтхэгт Бурхны шашны зөвлөл гээчийн хүрээнд зохион байгуулж байсан бөгөөд анхных нь хоёр мянга таван зуун жилийн өмнө Бурхан багшийн жанч хальсаны дараа болжээ. Эдгээр зөвлөлийн хамгийн том нь буюу гурав дахь зөвлөлийг Ашока хааны ивээл доор нийтийн он тооллын гуравдугаар зууны үед зохион байгуулсан ажээ. Ашока мөн арван есдүгээр зууны Робертийн дэг жаягийн эртний хувилбар шиг олон нийтийн хэлэлцүүлгийн хамгийн эртнийх байж таарах дэг жаягийг тогтоож, түгээхийг оролдсон байна. Жишээ нь тэр “ярихдаа тохиромжгүй үед өөрийнхөө урсгалыг хэт өргөмжлөн магтахгүй байх, өөр урсгалыг дорд үзэхгүй байхын тулд даруулгатай байхыг” шаардсан бөгөөд “тохиромжтой үед ч даруу байх нь зүйтэй” байлаа. Маргаж байх үед ч гэсэн “ямар ч тохиолдолд бусад урсгалынхныг зохих ёсоор хүндлэх ёстой” байв.

Өөр жишээг авч үзвэл долдугаар зууны үеийн Японд өөрийн ээж Сүйко хатан хааны өмнөөс засаг барьж асан Бурхны шашинт Шотоку ханхүү 604 онд арван долоон зүйлт үндсэн хууль гээчийг боловсруулсан байна. Уг хуулиар хожуу нийтийн он тооллын 1215 онд баталсан Их Хартид туссантай их адилаар “чухал хэрэгт ганц хүн шийдвэр гаргах ёсгүй. Тэдгээрийг олноор хэлэлцэх хэрэгтэй” гэж заасан ажээ.

Арван хоёрдугаар зуунд Еврей философич Меймонде өөрийн шашны итгэл бишрэлээ хэвээр хадгалах хүний эрхээ хамгаалах гэж Европоос дүрвэн гарахдаа Саладин султаны Египетэд орогнол хайж,

Мусульман шашинт султаны ордонд хүндтэй байр суурь олсон байна. Хэдэн зуун жилийн хойно Аград Энэтхэгийн Могол эзэн хаан Акбар бүх иргэнд шашин шүтэх эс шүтэх эрхийг хамгаалах төр засгийн үүргийг чухалчлан, хуульчилж байхад Европт шашны шүүх ажилласаар л байж, 1600 онд Ром хотод Жордано Бруног гал дээр шатаасан билээ.

Эрх чөлөө өөд алхсан нь хэмээх намтартаа Нельсон Мандела залуухан байхдаа Мкхекезуэни дэх засаг баригч сайдын байшинд болсон орон нутгийн уулзалтын үйл ажиллагааг харж байхдаа ардчилал, хувь хүний эрхийн талаар хэрхэн олж мэдсэн тухай дүрслэн бичсэн:

Ярихыг хүссэн бүх хүн үгээ хэлсэн юм. Тэр бол ардчилал хамгийн цэвэр тунгалаг хэлбэрээрээ байлаа. Үг хэлсэн хүмүүсийн дунд байр суурь, ач холбогдлоороо зэрэг зиндаа байсан байж магадгүй, гэвч удирдагч, албат, дайчин, оточ, худалдагч, аж ахуйтан, газрын эзэн, ажилчин ялгаагүй бүх хүнийг сонсч байв.

Өөр өөр нийгмийн хооронд байх хүний эрх, эрх чөлөөний талаар ойлголтын ялгааг хэрээс хэтрүүлээд зогсохгүй тодорхой хугацааны турш, тэр бүү хэл тодорхой нэг үед нутаг бүрийн доторх бодит ялгаануудын талаар тун бага тэмдэглэсэн нь бий. Ираны тэрс үзэлтнүүдийг захиргаадгалтын дэглэм нь буруу номын үзлээс нь болоод шоронд хийлээ гэхэд тэднийг “Ираны тэрс үзэлтнүүд” гэхээсээ илүү “Өрнийн үнэт зүйлсийн элч” гэж үзвэл ил шархан дээр нь тун ноцтой доромжлол нэмэх болно.

Энэ асуудал нь олон ялгаатай соёл бүхий ертөнцөд юуг соёлын хувьд “хэт өрөөсгөл” гэж үзэх вэ гэдгийг тодорхойлоход онцгой ач холбогдолтой юм. Чарльз Бейц хүний эрхийн хэрэглээг “дэлхийн олон соёлд байх улс төрийн шударга ёс буюу хууль

ёсны статусын тухайн ойлголттой холбогдох тэгш хэмт харилцаа”-аас үүссэн гэснийг үнэмшилгүй гээд “тэдгээрийн олон улсын харилцаанд гүйцэтгэх үүрэг роль”-ийн хувьд үндэслэлийг нь хайсан байна. Гэвч энэ “үүрэг роль”-ийг хүлээн зөвшөөрөгдөхүйц чанарынх нь хувь хэрхэн дүгнэх нь зөв бэ? Эсвэл яаж ойлгохоор тийм үнэлгээ нь соёлын хувьд “өрөөсгөл” байдаг байна вэ? Энд тавьсан бодомж эргэцүүлэл зөв юм бол бид (1) нийгэмд зохилон дэмжлэг хүлээдэг үнэт зүйлс, (2) нээлттэй хэлэлцүүлгийг зөвшөөрсөн үед буюу бусад нийгмийн талаар мэдээлэл чөлөөтэй авах боломж бий болох үед, мөн дарангуйлал, айдасгүйгээр тогтчихсон үзэл бодлоос эсрэг санаа илэрхийлж, түүнийгээ хамгаалж болдог үед илүү өргөн дэмжлэг талархал олж болох үнэт зүйлсийг хооронд нь ялгах ёстой болж байна.

“Хэт өрөөсгөл биш” байх нь дэлхийн өнцөг булан бүрийн хүн ардын оролцоог хүдэтгэдэг байхыг шаарддаг нь мэдээлэл туйлын хязгаарлагдмал, хэлэлцүүлэг, маргааныг огт зөвшөөрдөггүй үед оршин байгаа нийгмийн ноёлогч давуу эрхийг хүлээн зөвшөөрөхтэй адил зүйл биш. Урьдаас байсан хаа сайгүй тогтсон зөвшөөрлөөс ялгарах ёстой өргөн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдал нь олон улсын харилцаанд гүйцэтгэх үүргийнх нь хувьд ч тэр ямарваа нийгмийн үнэлгээний чухал асуудал юм.

Мэдээж өөр өөр улс орон, өөр өөр нийгэмд маргаангүй үзэл, урьдчилсан таамаглалын тэнцвэрт ихээхэн хувиралууд гарсан нь бий. Эдгээр итгэл, үнэмшил нь ихэвчлэн Адам Смитийн чадамгай гаргасан шинжилгээндээ тэмдэглэснээр оюун сэтгэлгээний өргөн оролцоогүйгээр дэлхийн өнцөг булан бүрт орших туршлагыг тусгасан байдаг. Нээлттэй шүүмжийн хэрэгцээ нь хязгаарлалтгүй мэдээлэл авах хүртгэмжийн

(дэлхийн өөр өөр хэсгийн туршлагын талаарх мэдээлэл зэрэг) хамтаар уялдаа холбоосоо шалтгаалан нилээд үлэмж байна. Тийм учраас Адам Смитийн үйл ажиллагаа, туршлагыг “тодорхой зайнаас” ажиглах хэрэгтэй гэсэн байр суурь ерөнхийдөө материаллаг ёс зүйн хувьд, тусгайлан хүний эрхийн ойлголтын хувьд ч ихээхэн чухал байгаа юм.

“Ёс суртахууны магтаал, зэмлэлийн сэтгэгдэлд үзүүлэх зан заншил, хэв маягийн нөлөөний тухай” хэмээх бүлэгтээ Смит өөрийн санааг ийн тодорхойлсон байна.

...Дөнгөж төрсөн нярайг хороох явдал Грекийн хот улсуудын бараг бүгдэд нь тэр бүү хэл эелдэг боловсон, иргэншсэн Афинд хүртэл зөвшөөрдөг хэвшил болсон бөгөөд эцэг буюу эх хүүхдээ өсгөхөд тохиромжгүй нөхцөлд орвол хүүхдээ өлсгөх буюу зэрлэг араатанд өгөхийг буруутгаж, зэмлэдэггүй байв. ... Амь бөхтэй зан заншил энэ үед уг үйлдлийг бүрэн зөвшөөрч байснаас ертөнцийн бараг олонх энэ зэрлэг зөвтгөлийг хүлцэж байсан төдийгүй илүү шударга, зөв байх ёстой байсан гүн ухаантнуудын номлол ч бас тогтчихсон заншилд хөтлөгдөж асан бөгөөд энэ тохиолдолд, бусад бүх тохиолдлуудын адилаар, аймшигт энэ үзэгдлийг зэмлэн буруушаахын оронд дэмжиж байлаа. Аристотель шүүх ийм олон тохиолдолд дэмжвэл зохих зүйл гэж үзжээ. Платон ч бас адил байр суурь илэрхийлсэн байх бөгөөд түүний бүх бүтээлийг амилуулж асан хүн төрөлхтний хайр нь энэ практикийг зэмлэсэн нь хаана ч үгүй билээ.

Явцуу хариу үйлчлэл шүүмжлэгч үйлдлээр солигдмогц тусгаарлагдсан нийгэм дэх “хэвийн”, “ухаалаг” гэдэг ойлголтод яг тохирдог зүйлс дэлхий дахинд гарсан олон янзын практик туршлага, хэм хэмжээг ухаарах гэхчлэн өргөн хэмжээний, хязгаарлалт багатай шалгуурыг давж чадахаа больж болно.

Зайнаас шүүмж өгөх нь Талибаны Афганд самуун явдалтай эмэгтэйг чулуугаар цохиж хороох болон Америкийн Нэгдсэн Улсын зарим хэсэгт ялын дээд хэмжээг нийтлэг хэрэглэх зэрэг хоорондоо адилгүй практикийг үнэлэхэд ямар нэг зүйлээр төстэй байж болох юм. Энэ бол бусад хүн төрөлхтний нүдийг шийтгэл шударга байгаа эсэхийг ойлгуулахаар хандуулах ёстой гэж үзэхэд хүргэсэн асуудал юм. Эцсийн эцэст шүүмжлэлт ёс суртахуунаар авч үзэх дэг жаяг нь биднээс өөрсдийн санаа сэтгэл, үзэл бодлоо бусад хүн тэдгээрийг хэрхэн хардаг шиг бусдын нүдээр харах гэж оролдохыг шаарддаг билээ. Хил дамнасан харилцан ажиллагаа мөнгөгүй ядуу нийгэмд чухал байдаг шиг мөнгөтэй баян нийгэмд мөн л чухал ач холбогдолтой. Энд тэмдэглэх гэсэн санаа бол бид хилийн чанад дахийг шүүмжилж болох эсэхтэй хамаагүй бөгөөд ёс суртахууны сэтгэгдэлийг шүүмжлэн үнэлэх дэг жаяг нь хэдий газар нутгийн хамааралтай тогтсон байлаа ч үл ялган шүүмжлэх шалгуураар авч үзэхийг шаарддаг болно.

## Х. Дүгнэх үг

Би энэхүү нийтлэлд хүний эрхийг нээлттэй, нийтийн зөвшилд тогтвортой бөгөөд нийгмийн ёс зүйд орших шийдэл гэж үздэг хүний эрхийн онолын элементүүдийг танилцууллаа. Тэдгээр нь эрх зүйн бүтцэд хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу туссан, тусаагүй аль нь ч байж болно. Гэвч хүний эрхийг хэрэгжүүлэх бусад олон арга байдаг (нийтээр хүлээн зөвшөөрөх, эсэргүүцэл, хяналт тавих гэх мэт).

Энэ нийтлэлд дэвшүүлсэн гол сэдвүүдийг II хэсэгт тэмдэглэсэн тул би энэ дүгнэлт хэсэгт нэмж тоймлох гэхгүй. Гэхдээ хүний эрхийн тухай ойлголт, хэрэгжих боломж нь энэ өнцгөөс бол гарцаагүй олон нийтийн хэлэлцүүлэг хүмүүсийн хооронд

болон хил дамнан хүрэх эсэхтэй холбоотой болохыг онцлон тэмдэглэх болно. Хүний эрхийн хэрэгжих боломж, түгээмэл байдал нь нийтийн зөвшилцөлд нээлттэй шүүмжлэлт байр суурийг хэрхэн давах боломжтой байхаас нь ихээхэн хамаарч байдаг. Нийтийн шүүмжид оруулах арга зүй нь ёс зүй дэх “бодит байдал”-ын талаарх Ролзын ойлголтод дөхөж очих боловч зайлшгүй шаардлагатай үл алагчлалыг нэг үндэстний хил дотор хязгаарлачихаж болохгүй.

Захиргаадалтын дэг журам цензургүй мэдээллийн хэрэгслээс, мөн хязгаарлаагүй нийтийн хэлэлцүүлгээс нилээн жийрхдэг нь байнга хүчээр дарах арга хэрэглэхэд хүргэдэгээс бүх нийтийн зөвшилцлийн нөлөө тун чиг их болохыг шууд бусаар нотлох баримт болж байна. Тэрхүү нөлөө нийгмийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх, мэдээллийн хяналт үнэлгээ, нийтийн дүргүйцэл зэрэг хүний эрхийн идэвхтэнүүд хэрэглэх хандлагатай байдаг ч харилцан идэвхтэй арга, замын үр ашигт хүрэхгүй юм. Үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх боломжийн нийтгч шинжийг ойлгох шаардлага тодорхой бөгөөд энэ нь тус тусын нийгмийнхээ зонхилох бүлгийн зан заншил дээр идэвхгүй

тулгуурлах төдийгөөр хязгаарлахгүй байхыг шаардана.

Дүгнэхэд практик туршлага байсан ч хүний эрхийн идэвхтнүүдэд эрх зүйн болон улс төрийн онолчдын дунд хүний эрхийн ойлголтоос үүсч байгаа шүүмжлэлүүдэд анхаарал хандуулах хангалттай шалтгаан бий. Эдгээр эргэлзээг тайлах ёстой, мөн тайлж болох юм. Мөн түүнчлэн хүний эрхийн үзэл санааны ойлголт нь хүний эрхийн идэвхтнүүдийг хөдөлгөж байгаа учир шалтгаан болон нийгмийн сайшаал, хяналт үнэлгээ, эсэргүүцэл, мөн хууль тогтоомж зэрэг тэдний авч хэрэгжүүлж буй практик ажиллагааны цар хүрээ, үр өгөөжийг авч үзсэнээр мэдэгдэхүйц ашиг тус авч болно. Бодит амьдралд үзэл баримтлалын тодорхой байдал чухал төдийгүй мөн баялаг туршлага хүний эрхийн үзэл санаа, хүртээмжийг ойлгоход шийдвэрлэх учир холбогдолтой хэмээн би гэж хэлж байгаа юм. Онол, практик хоёрын хоорондох тэнцвэртэй байдалд тийм ч их алдаа байхгүй гэж дүгнэх нь зүйтэй.

**Орчуулсан:** Хүний эрхийн Үндэсний  
Комиссын референт Ө.Ундрах

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



## Зочны яриа

## “ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫГ ХОЛБООНООС ГАРГАСАН АНГИЛЛЫН ДАГУУ БОДЛОГОТОЙГООР ХӨГЖҮҮЛБЭЛ ХҮҮХДИЙН ЭРХ АШИГ ХӨНДӨГДӨХ НЬ БАГАСНА”



*Монголын Морин Спорт уяачдын холбооны нарийн бичгийн дарга П.Сэргэлэнтэй уулзаж ярилцлаа.*

*- Монгол хүн бүр морио дээдэлдэг. Хийморь, сур хүчний билэгдэл болсон үндэсний баяр цэнгэлийн утга учир алдагдаж, хүүхдийн амь нас, эрүүл мэндийг зугаа цэнгэлийн золиослох болсныг хүний эрхийг хамгаалагчид анхааруулж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комисс ч хүүхдийн эрхийн асуудлыг хүчтэй хөндөж, танай байгууллага болон холбогдох бусад эрх мэдэлтэн, албан тушаалтнуудад Зөвлөмж, Шаардлагуудыг удаа дараа тавьсаар ирсэн. Хүүхдүүд мориноос унаж, бэртэж, гэмтэж, амь насаа алдсаар байна. Харин танай зүгээс энэ асуудалд яаж хандаж байгаа вэ?*

*- Үндэсний хурдан морины уралдаан, морь гэдэг хоёр зүйл Монгол хүн бүрийн сэтгэл зүрх, цусанд байгаа эд л дээ. Монгол хүн байгаа цагт энэ уламжлал, зан заншил байх болно гэдэгт бид итгэлтэй байдаг. Монголын Морин спорт уяачдын холбоо*

*гэдэг байгууллага бол Монголынхоо уяачдын эрх ашгийг хамгаалах ёстой, уралдаанч хүүхдийн эрх ашгийг ч хамгаалах ёстой. Үндэсний хурдан морины уралдааныг улам боловсронгуй болгож, үндсэн агуулгыг нь алдагдуулахгүйгээр үр хойчдоо өвлүүлэн үлдээх ёстой. Өнөөдөр Монголын морины соёлыг тээж яваа улсууд нь уяачид, Монголын морин спорт уяачдын холбооны морины зүтгэлтнүүд гэж ойлгодог.*

*Бидний ажиллаж, амьдарч байгаа энэ үе бол Монголын уяачдын хувьд хүнд сорилтын үе, завсрын үе. Нийгэм хөгжих, соёл боловсрол, мэдээлэл, харилцаа холбоо бүх юм дээшлэхийн хэрээр үндэсний соёлд хандах хандлага их өөрчлөгдсөн. Монголчууд мориноосоо их холдсон. Хэт их хөгжил, хэт их соёл. Дөрвөн хананы дунд амьдрах болсон хот суурин газрынханд морь шаардлагагүй зүйл болсон. Морь унахыг хүнд хэцүү хөдөлмөрт тооцох болсон.*

*- Хүүхдүүд мориноос унаж амь насаа алдаж байна. Монгол Улс хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд эрх зүйн зохицуулалт шаардлагатай боллоо. Хүүхэд зугаа цэнгэлийн золиос болсон хэвээрээ. Насанд хүрээгүй хүүхдийн амь нас, эрүүл мэндээр нааддаг асуудлыг хуульчлах, хуулийн төслийн ажлын хэсгийг Соёл, аялал жуулчлалын яамны дэргэд байгуулсан нь үндэсний соёл, уламжлалыг үгүйсгэхгүй гэсэн бас санаа байсан. Ажлын хэсэгт танай холбоог ч оруулсан байгаа байх. Зөвлөмж, шаардлага хүргүүлсний дараа уралдаан болсон, хүүхдийн амь нас хохирсон хэвээрээ байна гэж сэтгүүлчид биднээс байнга асуудаг?*

- Танайхаас Зөвлөмж, Шаардлага хүргүүлсний дараа хүүхдийн амь нас сүйдсэн тохиолдол гараагүй. Бид мэдээлэл, судалгааг байнга хийж байгаа. Сэтгүүлчид ташаа мэдээлэлтэй байна. Хүүхэд унаж бэртэх, эндэх асуудалд Уяачдын холбоо бол маш харамсч байна. Аль болох уралдаан наадамд хүүхдийн эрх зөрчигдөхгүй байлгахыг хичээж ажилладаг. Харамсалтай нь зөвшөөрөлгүй жижиг уралдаанууд Монгол Улсын өргөн дэлгэр нутагт зохион байгуулагдаж, сум, багийн хэмжээнд засаагүй замд, зохион байгуулалтгүй уралдах болсноор хүүхэд унах, бэртэж гэмтэх асуудал гарч байна. Бид үүнийг анхааралдаа авч, нөхцөл байдлыг сайжруулахын төлөө хичээж ажиллаж байна. Хууль дүрмийн хувьд ч чангатгах хэрэгцээ шаардлага байна. Хүүхдийн төлөө үндэсний газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, хүний эрхийн бусад байгууллага, хэвлэл мэдээллийнхэн уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, эрхийг хамгаалдаг. Харин уяачдын холбоо, уяачид уралдаанч хүүхдийн эрхийг зөрчөөд байдаг. Нийгэмд ингэж л харагдаж, ойлгогдож байна. Энэ хэдэн байгууллага хүүхдийн эрхийг хамгаалах гээд байдаг, хэдэн уяачид, зугаа цэнгэл хөөцөлдөгчид нь хүүхдийн амиар наадаад байдаг гэсэн маш буруу ойлголт, хандлага нийгэмд тогтчихлоо. Маш харамсалтай зүйл. Монгол уяачид хүүхдээ хамгаалах уламжлалт тогтолцоотой. Орчин үеийн олон улсын жишиг шаардлагын дагуу хамгаалах хувцас хэрэгсэл, тогтолцоог бий болгохын төлөө ажиллаж байгаа. Монголын морин спорт уяачдын холбоо байгуулагдаад 19 жил болж байна. Хүүхдийн асуудал энэ холбооны тэргүүлэх чиглэл, байр суурь байсаар ирсэн. Ялангуяа сүүлийн 4-5 жилд бүр онцгой анхаарал хандуулж, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалахад анхаарч байна. Хүний эрхийн Үндэсний Комисс,

Хүүхдийн төлөө үндэсний газар ч үүнд л анхаарах ёстой. Хүүхдийн эрх гэж ярихаасаа илүү хүүхдийн аюулгүй байдалд анхаарах хэрэгтэй. Нэгдсэн байр сууринд хүрэх ёстой. Хүүхдээр морь унуулахыг хориглох тухай асуудлыг Монгол улс ярьж болохгүй. Хүүхдийн хүнд хөдөлмөр гэж ярьж болохгүй ээ. Үндэсний спортоороо хичээллэж байгаа тамирчин хүүхэд. Тамирчин хүн, ер нь аливаа хүн бусдаас илүү, сод гайхамшигт амжилт үзүүлэхийн тулд илүү хөдөлмөрлөж, хүчин чармайлт гаргах хэрэгтэй болдог. Өнөөдөр олимпийн аварга болсон ОХУ-ын тамирчин Юлия 13 настай. Дөрвөн настайгаасаа уран гулгалтаар хичээллэж эхэлсэн. Энэ хүүхэд үсэрч харайж хичээллэж байх явцдаа маш хүнд бэртлүүдийг аваад явж л байсан. Спорт өөрөө ийм л байдаг. Гэтэл түүний эрхийг хамгаална гээд, уран гулгалтаар хичээллэж болохгүй ээ. Оросын домог болсон тамирчин нурууны бэртлээс болоод олимпоос хасагдаж байна, эрхийг нь хамгаалъя гэдэггүй шүү дээ. Тэгвэл түүн шиг Монгол Улс хүүхдээр морь унуулахыг хориглоё гэхээс илүү уралдаанч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хамгаалъя гэж ярих ёстой. Энэ асуудалд нэгдсэн байр суурьтай байх ёстой. Өнөөдөр танай Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг сэтгүүлд ярилцлага өгч байгаа маань ч үүнтэй холбоотой гэж бодож байна.

- *Хүний эрхийн Үндэсний Комисс цагаан сарын өмнөхөн буюу 2014 оны 1 дүгээр сарын 23-нд танай холбоонд хандаж Зөвлөмж хүргүүлсэн. Тус зөвлөмжид “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 12 дахь илтгэлдээ морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах шаардлагатай байгааг дахин сануулсан билээ. УИХ-ын Хууль зүйн Байнгын Хороо энэхүү илтгэл болон Комиссын санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар 2013 оны 7 дугаар сарын 3-ны өдөр гаргасан 13 дугаар*

*тогтоолдоо хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, хүүхдийг үл хайхрах, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх хууль тогтоомжийг шинэчилж сайжруулах, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага” (MNS 6264-2011) стандартыг хангаж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосон болно... Иймд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн дагуу, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор өвөл цагийн /хүйтний улиралд/ уралдаанд хүүхдийг оролцуулахгүй байхыг сануулан Зөвлөмж хүргүүлж байна” гэснийг санаж байна. Танай холбооноос ч төлөөлөл ирж Комисстой уулзаж, хамтарч ажиллахаар боллоо. Зөвлөмжийг үндэслэн Монголын морин спорт уралдааны холбоо шаардлага гаргасан гээд эндээс ахиц дэвшил гарна гэсэн итгэл найдвар төрж байх шиг. “Хүний эрх” сэтгүүл дугаарын зочноороо таныг урих бас нэг учир шалтгаан энэ юм?*

- Хүний эрхийн Үндэсний Комиссын гаргасан зөвлөмж, шаардлагуудыг холбоо хүлээж аваад бүх салбар холбооддоо бичиг явуулаад бүх уралдааныг зогсоо гэсэн уриалга гаргачихсан. Өнөөдөр зөвшөөрөлгүй нэг ч уралдаан болохгүй. Дийлэхгүй мэр сэр уралдаан явж байгааг үгүйсгэхгүй. Манай улс 360 гаруй мянганы малчин өрхтэй. 360 мянган аав бүгд морь унана, хүүхдүүд нь бас моринд дуртай. Энэ болгоныг бүгдийг бид хорьж чадахгүй байгаагаа хүлээн зөвшөөрнө. Гэхдээ олонх нь энэ холбооны гишүүн, холбооны үйл ажиллагаанд тодорхой

хэмжээгээр оролцдог хүмүүс байдаг учраас уралдаанууд зогсчихоод байна. Жишээлбэл, маргааш замаа засаад уралдана гэж байхад л Орхон аймгийн холбоо, аймгийн Засаг даргатай яриад танай шаардлага, зөвлөмжийг танилцуулаад зогсоохлоо. Иймэрхүү байдлаар ойлголцоод явж байгаа. Тэгэхээр хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хамтарья, уралдаанч хүүхдийн эрх ашгийг хамгаалах тухай ярьцгаая. Энэ зөвшөөрөлгүй олон жижиг уралдааныг зогсоох чиглэлээр ажиллая. Хүлээлгэх хариуцлагыг нь тодорхой болгоё. Зохион байгуулж байгаа дураараа, замбараагүй улсуудад хариуцлага тооцъё. Хүний эрхийн Үндэсний Комисстой хууль дүрмийн хүрээнд хамтраад ажиллая. Монголын Морин спорт уяачдын холбоо хэдхэн уралдаан зохион байгуулдаг. Бид үлгэр жишээ зохион байгуулдаг. Манай уралдааны үеэр хүүхэд унаж эндсэн тохиолдол байхгүй. Сүүлийн 5 жилд 80 хүүхэд унасан байна. Эдгээрээс маш цөөхөн нь хөнгөн гэмтэл авсан. Хүүхэд эндсэн тохиолдол байхгүй. Гэтэл саяхан нэг сэтгүүлч Ерөнхий сайдаас Монголын Морин спортын холбооноос зохион байгуулсан уралдаанд хүүхэд хүнд гэмтсэн, үрэгдсэн тухай асууж байна билээ. Үнэн мөнийг нь тогтоолгоно.

Манай холбоо зохион байгуулах уралдааныхаа замыг маш сайн засч бэлтгэдэг. Батлан хамгаалах яамнаас танк авчруулж хөлдүү замыг зөөллөж засдаг. Уралдаан болохоос өмнө Хүүхдийн төлөө үндэсний газар, уралдаанч хүүхдүүдийн эцэг, эхчүүдийг автобусаар авч явж замыг үзүүлдэг. Замаа ийм болголоо шүү гэдгийг харуулдаг. Хамгаалах хувцас хэрэгслийг ч бэлддэг. Өнгөрсөн жил гэхэд л 850 ширхэг дулаан комбинзоныг хүүхдүүддээ үнэгүй хийлгэж өгсөн. Уралдаанч хүүхдүүдийн эцэг эхээр нь мөнгийг нь төлж хийлгүүлсэн юм. Гадаадын олон улс орны стандарт,

туршлагыг судалж байгаад хурдан морины хүүхдийн хувцас хэрэгслийн стандартыг манай холбоо санаачилж, Засгийн газар, Үндэсний стандарчлал, хэмжил зүйн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар хамтраад батлуулсан юм. Хүүхдийн даатгалын асуудлыг холбоо анх хөндөж гаргаж ирээд, 800-900 хүүхдийг даатгалд хамруулж, бүтэн жилийн турш даатгалтай явуулдаг ажлыг бид хийсэн. Энэ бүхнийг бид хийсэн юм. Түүнээс биш Хүүхдийн төлөө үндэсний газар ч юм уу, өөр байгууллагын хийсэн ажил биш. Одоо бас нэг худлаа зүйлийг ам дамжин, сонин хэвлэл, телевиз радиогоор албан болон албан бусаар ярьцгаагаад байна. Энэ бол морины даатгалын асуудал. Хүүхдээ нэг сая төгрөгөөр даатгачихаад, морио хэдэн тэрбумаар даатгадаг гэж нэг хэвлэл, УИХ-ын гишүүн хүртэл ярьж байх юм. Энэ бол худал цуурхал. Морио даатгуулсан уяач, морь даатгасан компани байхгүй.

Хүүхдийн өсөлтийг зогсоодог тариа хийдэг гэж маш муухай худал хэлсэн. Холбогдох газарт нь мэдэгдэнэ. Дэндүү муухай гүтгэлэг, олон мянган уяачийг гүтгэсэн муухай зүйл болсон.

**-Тарианы асуудлыг мэдэхгүй юм. Морь, хүүхдийн даатгалын хувьд зөрүү үнэхээр байхгүй гэж үү?**

-Морь даатгасан нэг ч даатгалын компани байхгүй. Та нар даатгалын компаниудаас асуугаарай. Морь даатгавал дампуурна гэж үзээд даатгадаггүй юм байна лээ. Морь даатгуулах асуудлаар хандаж үзсэн. Боломжгүй гэсэн. Морь нь өөрөө тодорхой хэмжээний өртөгтэй. Өндөр эрсдэлтэй гэж үздэг. Гэтэл худлаа яриад л иргэдэд буруу ойлголт төрүүлээд байх юм. Уяачдын нэр хүндийг унагаах зорилгоор зориуд гаргасан яриа.

**-Манайхаас хүргүүлсэн Зөвлөмжийн дагуу танай холбоо уриалга гаргасан.**

***Уриалга ч эсэргүүцэлтэй тулгарсныг танай сайтын сэтгэгдлүүдээс харж болохоор байна. Гэхдээ энэ бүхэн хэзээ нэгэн цагт гольдролдоо орох байх?***

-Монголчууд бид ахуйгаасаа их холдсон байна. Гэтэл дэлхий нийт буцаад ахуй руу зүтгэж байна. Монголд ирсэн гадныхан хүүхдээ шороон дээр суулгаж, байгаль дэлхийтэй ойр байлгахыг хичээж байна. Байгальтай ойр байж дархлаа тогтоно гэдгийг мэдэрчихэж. Одоо дулаахан машинаасаа гараад чичигнэтэл даардаг. Гэтэл өдөр бүр тэр цаг уурт зохицон амьдарч байдаг хүүхдүүд түүнийг ер ажрахгүй. Ахуйгаасаа холдсон гэж үүнийг хэлээд байгаа юм. 40 хэмийн хүйтэнд өглөө хар үүрээр босоод үнээгээ сааж байгаа малчин ээжүүд яаж байна вэ. Тэр бол хүнд хөдөлмөр. Удахгүй энэ янзаараа бол тэр эхчүүдийг хамгаалах байгууллага байгуулагдах нь байна шүү. Хүүхэд шороон дээр мөлхөж байвал хоцрогдлоо, хүүхдийн эрх зөрчигдлөө гэж ярих нь байна. Гэтэл аливаа улс орны соёлыг хадгалж, хамгаалж үлдэх асуудал хамгийн чухал зүйл.

***-Уучлаарай, хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах, хариуцлагын тогтолцоог бий болгох явдал зайлшгүй шаардлагатай. Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан буруутай этгээдэд хариуцлага тооцох асуудлыг хөндөж байгаа. Хуулийн төслийн ажлын хэсэгт танай холбооны төлөөлөл бий байх. Энэ талаар танай холбоо ямар байр суурьтай байна вэ?***

-Эндийм хүндрэл үүсээд байна. Нийгэмд уяачид, хүний эрхийг хамгаалагчдыг талцуулаад байгаа нь асуудлыг бүр хүндрүүлээд байна. Энэ нь мэдээж, танай хийж байгаа ажил биш. Хэвлэл мэдээлэл, ам дамжсан яриа ийм байдалд хүргэчихлээ. Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн

төлөө үндэсний газар, Монголын морин спорт уяачдын холбоо нэгдмэл байр сууринаас асуудалд хандаж, хамтарч ажиллах ёстой юм. Гэтэл хамтарч ажиллах ёстой талуудыг холдуулчихдаг байна.

Хүүхдийн аюулгүй байдлыг яаж хэдүүлээ дээд зэргээр хамгаалах вэ. Үүний тулд би Хүний эрхийн Үндэсний Комиссоос ганцхан зүйлийг хүсэх гэж байна. Зөвшөөрөлгүй уралдаануудыг яаж зогсоох вэ. Зөвшөөрөлгүй уралдааныг зөвшөөрөлгүй зохион байгуулдаг том толгойтой компани хүртэл байдаг. Компанийн нэрэмжит уралдаан зохион байгуулдаг. Хариуцлага тооцдог эрх зүйн тогтолцоог нь бий болгож өгөөч гэж та нараас хүсэх байна. Харин Уяачдын холбооны зүгээс уралдааныг зөвшөөрөлтэй хийх ёстой, зөвшөөрөлтэй уралдаанд морины комисс ажиллаад уралдааныхаа замыг засаад, хамгаалалтын хувцас хэрэгслийг өмсүүлээд зохион байгуулалтыг дээд зэрэглэлтэй болгоод гарах эрсдлийг улам бууруулаад Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө үндэсний газар, мал эмнэлэг, цагдаа, эмнэлэгийнхнийг бүгдийг нь байлцуулаад, уралдаан бүрийн дараа эргэж тайлан мэдээлэл өгдөг болоод... ингээд явах боломж бий. Бид үүнийг төлөвлөөд явж байна.

Хамтарч ажиллах ёстой талуудыг холдуулсны уршиг. Одоо хүний эрх гэхээр уяачид буруу хараад суучихдаг болсон. Биднийг байхгүй болгох гэж байна гээд. Хүүхдийн байгууллага гэхээр бас л буруу хараад суучихдаг. Холбоо өөрөө хүнд байдалд орчихсон. “Уралдааныг хориод л, уриалга гаргаад л, та нар бидний эрх ашгийг хамгаалах ёстой байтал нөгөө талд орж, уралдаануудыг хорьж байна. Бидний хоол, амьдралыг хорьж байна” гэдэг. Үнэн шүү дээ. Хүний олон жилийн хөдөлмөрийг зогсоочихоор бидэнд дургүйцэх нь зүйн

хэрэг. Хүний эрхийн Үндэсний Комисс гэж нөхдүүд баахан шаардлага тавьсаар уралдаангүй болчихлоо. Манай холбоо гэж арчаагүй юмнууд үг хэлчихгүй, уралдаанаа хийчихгүй байгаад байна гэдэг. Нэг тал болох ёстой улсууд өөр өөр өнцөг, байр сууринд оччихоод байна. Энэ дунд нь хаданд хавчуулагдсан халиуны зулзага шиг Уяачдын холбоо нь хөөрхий болчихоод байна. Бид юм болгоныг чинь аль болох ойлгоод л байгаад байна.

Холбоо маань төрийн бус байгууллага. Цалин цаваг гэх юмгүй. Хэдэн уяач нийлээд байгуулчихсан. Тус тусдаа өөр өөрийн ажилтай. Хааяа эндээ цуглаад ажил төрлөө ярьчихдаг. Уралдаан зохион байгуулахдаа улсаас нэг ч төгрөг авдаггүй. Хэдэн төгрөг цуглуулаад морьдоо байлчихаад яваад өгдөг. Бай шагналаа тарааж өгчихөөд, цагдаа, хүн эмнэлэг, мал эмнэлэг, бензин тосны мөнгө бүх зардлыг нь бид өгдөг юм. Хэдэн уяачдынхаа хөдөлмөрийг үнэлчихээд яваад өгдөг. Гэтэл моринд хэдэн төгрөг өгсөн улсыг маань зэрлэг баячуул гээд байдаг. Хөөрхий нөгөө хэд чинь морь нь айрагдвал нэг сая төгрөг л авдаг. Тал тал руу тараагаад л гэртээ харихдаа бурхан дээрээ таван мянган төгрөг тавиад л явдаг. Морь уясан хүн мөнгө олдоггүй юм. Мөнгө олох гэсэн хүн морь уядаггүй юм.

Биднийг тойроод олон хамт олон бий болчихсон, одоо 60 мянган уяач байна. Тэдний цаана хамгийн багаар бодоход 60 мянган адуучин, 60 мянган туслах малчин бий. Өнөөдөр хурдан морины уралдаан байгаа учраас хөдөө залуучууд тогтож амьдарч байна. Хэрвээ хурдан морины уралдаангүй болчихвол малчин залуучууд хот сууринд ирээд ажлын байрны хомсдол улам л ихсэнэ.

*- Морин спорт хөгжлийн завсрын үед байна гэж та ярилаа. Хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй, орчин үеийн хэрэгцээ*



*шаардлагад нийцсэн, соёл уламжлалаа хадгалах, уралдааны замыг богиносгох, спортын төрөл рүү түлхүү хөгжүүлэх зэрэг гарц байхгүй гэж үү?*

- Бидэнд бодож төлөвлөж байгаа зүйл байна. Монгол Улсад хурдан морины уралдааны ангилал гэж бий. Холбооноос гурван төрлийн ангилал гаргасан. Нэгдүгээрт, үндэсний хурдан морины уралдаан. Эрийн гурван наадам. Удаахь нь эрлийз морьдын уралдаан, гуравдугаарт, морин тойруулгын уралдаан. Үндэсний морин уралдаан буюу үндэсний их баяр наадмаар уралддаг, эрийн гурван наадмаар хүүхэд нь морь унаж уралдъя. Үндэснийхээ соёлыг хамгаалъя. Морин спортын буюу эрлийз морьдын уралдаанд мэргэжлийн үнэмлэх, сертификаттай мэргэжлийн тамирчин хүүхдийг уралдуулъя. Спорт болгоё, ойрын зайнд уралдуулъя. Морин тойруулгын уралдаан манай улсад маш чухал хэрэгцээтэй. Энэ төрлийн уралдаанд насанд хүрсэн жокейчид оролцоно. Хоёр нь мэргэжлийнх болоод ирэхээр асуудал

цэгцэрнэ. Манай холбооноос гаргасан энэ ангилал, бодлогыг засаг төр судалж, дэмжиж өгөөсэй. Энэ бүхэнд таарсан бодлого, хууль дүрэм хэрэгтэй. Энэ чиглэлээр Монголын Морин спорт уяачдын холбоо шат дараалан ажиллаж байгаа. Сая Азийн морин уралдааны холбооны гишүүн болсон, Олон улсын морин уралдааны гишүүн болсон. Зарим уралдаанууд мэргэжлийн тал руугаа чиглээд ирвэл асуудал аяндаа шийдэгдэнэ. Хурдан морины уралдааныг холбооноос гаргасан ангиллын дагуу бодлоготойгоор хөгжүүлбэл хүүхдийн эрх ашиг хөндөгдөх нь багасна. Хурдан морины уралдааныг мэргэжлийн тал руу нь хөгжүүлэхийг дэмжих хэрэгтэй. Энэ гурван ангилал, энэ гурван уралдаан бол холбооны бодлого. Бодлогыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Холбоо хуулийн төслүүдэд ч ажиллана.

**- Цаг зав гарган ярилцсан танд баярлалаа. Амжилт хүсье.**

**Ярилцсан:** З.Бадмаараг (Хүний эрхийн Үндэсний Комиссын референт)

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН